



Жилийн тайлан 2020



Агуулга

➤ ТУЗ-ийн даргын мэндчилгээ	4
➤ Гүйцэтгэх захирлын мэндчилгээ	6
➤ Урьд өмнө тохиолдож байгаагүй хүндрэлтэй нүүр тулгарсан жил	
Эрхэм зорилго, Хэтийн зорилт	10
ХасБанк: 2020 он	11
Санхүүгийн гүйцэтгэл	12
Олон улсын үнэлгээ	14
Санхүүжүүлэгч, түнш байгууллагууд	15
Хувьцаа эзэмшигчдийн бүтэц	16
Төлөөлөн Удирдах Зөвлөл	17
Гүйцэтгэх удирдлага	18
Макро эдийн засгийн төлөв	20
Банкны салбар	22
➤ Ашид хамтдаа: Ковид-19-ыг даван туулахад ба цаашид	
Иргэдийн банк	24
Бизнес банк	28
Эко банк	30
Цахимжуулалт	36
Нийгмийн хариуцлага	38
➤ Хариу арга хэмжээ авах, үйл ажиллагаагаа нөхцөл байдалд нийцүүлэх, манлайлах	
Санхүүгийн үзүүлэлт	40
Дотоод аудит	42
Эрсдэлийн удирдлага	44
Хүний нөөц	46
Онцлох үйл явдлууд	49
Банкны засаглал	50

ТУЗ-ийн даргын МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм хүндэт хувьцаа
эзэмшигчид, харилцагчид,
түншүүдээ,



Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахал 2020 оны туршид хүн бүрийн амьдралд нөлөөлж, он гарснаас хойш ч харамсалтай нь манай дэлхийг бусниулсан хэвээр байна. Цар тахал бид бүгдийн амьдралд янз бүрээр нөлөөлж байна. Бид урьд өмнө тохиолдож байгаагүй энэ хямралтай тэмцэхийн зэрэгцээ өнгөрсөн жилд Банкны ашгийн хэмжээг өсгөж, өөрийн хөрөнгийн хүрэлцээ, төлбөрийн чадварын харьцаа үзүүлэлтүүдийг эрүүл өндөр түвшинд хадгалж ажиллалаа.

Цар тахлын нөхцөл байдалд харилцагч, ажилтнуудын маань эрүүл мэндийн асуудал хамгийн чухал. Бид Ковид-19-өөс хамгаалахын тулд засгийн газар, эрүүл мэндийн байгууллагуудаас өгч буй зөвлөмж, хамгааллын арга хэмжээг чанд сахих хэрэгтэй. Ковид-19-ийн улмаас харилцагчид эдийн засгийн хүндрэлд орж, бид 2020 онд 20 мянган харилцагчдийн хэрэглээний, бичил болон ЖДҮ-ийн зээл, орон сууцны зээлийн нөхцөлийг өөрчилж дэмжлээ. Бид нөхцөл өөрчлөх хүсэлтийг онлайнаар авдаг болгосноор харилцагчдад илүү хялбар, аюулгүй болголоо.

Шинэ цахим банкны аппликейшн нэвтрүүлж, харилцагчдад банкны ихэнх үйлчилгээг гар утсаар дамжуулан илүү түргэн шуурхай, аюулгүй байдлаар авах боломж олголоо. харилцагчийн үйлчилгээг улам боловсронгуй болгох үүднээс бид мэдээллийн технологид оруулж буй хөрөнгө оруулалтаа үргэлжүүлэн ажиллана.

Өнгөрсөн жил Монголбанкнаас банкны системийг бэхжүүлэхэд чиглэсэн Зохиистой харьцааны журмыг баталлаа. Бид 2020 оны 12-р сарын 31-ний байдлаар нэгдүгээр зэрэглэлийн хөрөнгийн харьцааг 16.9% болгосон бөгөөд энэ үзүүлэлт нь банкны салбарт дээгүүрт орж, Монголбанкны журамд зааснаас дээгүүр байна. Бид мөн төлбөрийн чадварын үзүүлэлтийг сайжрууллаа. Өөрийн хөрөнгө, төлбөрийн чадвар сайтай байвал бид харилцагчид болон бусад сонирхол нэгтэй талууддаа илүү сайн үйлчилгээг тогтвортой үзүүлэх болно.

Бид мөн Монголбанкнаас гаргасан арилжааны банкуудыг нээлттэй хувьцаат компани болгох журмыг дэмжиж байна. Хувьцааг нийтэд санал болгосноор бид Монголын иргэдэд ХасБанкны хувьцааг хөрөнгийн бирж дээр нээлттэй ил тод байдлаар худалдаж авах, ХасБанкны өсөлтийн өгөөжийг хүртэх боломж олгоно. Бид хувьцааг санал болгох ажлын талаар Монголбанк, Санхүүгийн Зохицуулах Хороо болон бусад байгууллагатай хамтран ажиллаж цаашид цаг тухайд нь мэдээлж ажиллах болно.

2020 он бидний ажилтнуудын маань хувьд маш хүнд жил болсон ч тэдний мэргэжлийн ур чадвар, хүчин чармайлт, ажлын идэвх бусдад үлгэр дуурайлал боллоо. Би ажилтнуудаараа маш их бахархаж байгаагаа энэ завшааныг ашиглан дахин хэлж талархал илэрхийлье. Ялангуяа харилцагчидтай нүүр тулж ажилладаг Хасчууддаа талархал илэрхийлж байна. Тэд хэцүү хүнд нөхцөлд харилцагчдадаа анхааралтай, хариуцлагатай үйлчилж ажилласан.

Эцэст нь манай хувьцаа эзэмшигчид, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд Банкны бат бөх чанар, хүч чадлын эх үүсвэр болж байгааг тэмдэглэж, Банкны өмнөөс дэмжлэг удирдамжаар хангаж ажилласанд талархлаа илэрхийлж байна.

Санжай Гупта
ТУЗ-ийн дарга

Гүйцэтгэх захирлын МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигч, харилцагч, хамтрагч нар аа,

Юуны түрүүнд бидэнд тулгарсан хамгийн их сорилт бэрхшээлтэй цаг үед сэтгэл харамгүй дэмжсэн Захирлуудын зөвлөлийн дарга ноён Санжай Гүпта, захирлын зөвлөлийн гишүүд болон хувьцаа эзэмшигчиддээ үүгээр дамжуулан талархал илэрхийлье.

Түүнчлэн ХасБанк болон Тэнгэр Санхүүгийн нэгдлийн удирдлагын багт болон нийт 1550 ажилтандаа онцгой талархал илэрхийлэхийг хүсэж байна. Тэд туйлын таатай бус нөхцөл байдалд бүхий л хүч чармайлтаа гаргаж харилцагчдадаа үйлчилж ажилласан.

Үүгээр КОВИД-19 цар тахлын үед бидэнд тулгарсан сорилтууд, шийдвэрлэх нэн тэргүүний асуудлууд болон тэдгээрийн хэрэгжилтийн талаар тоймлон өгүүлэхээс гадна харилцагчдаа дэмжих, ажилтнуудаа хамгаалах талаар авсан арга хэмжээнүүдээс дурдъя. Мөн 2021 онд банкны төлөв байдал, банкны салбарын шинэчлэлтэй холбоотой гарч болзошгүй үр дагаврын талаар өгүүлье.



Гүмэнжавын Цэвэгжав
Гүйцэтгэх захирал



➤ Тодорхой бус байдалд удирдах нь: КОВИД-ын цар тахлын үеийн хямрал, харилцагчид, ажилтнуудаа хамгаалах нь

2019 оны ололт амжилтууд, хийсэн стратегийн өөрчлөлтүүд нь бидний цаашдын хөгжлийн түлхэц болсон юм. 2020 онд дэвшүүлсэн шинэ зорилтууддаа хүрэх итгэл эрмэлзэлтэйгээр бид шинэ оноо угтсан. Харамсалтай нь 1900 оны эхэн үеэс хойш тохиолдож байгаагүй КОВИД-19 цар тахал дэлхий нийтэд хурдтай дэлгэрсэн. Дэлхий дээр эрүүл мэндийн хямралаар эхэлсэн цар тахал төд удалгүй эдийн засгийн хямрал, улмаар нийгмийн хямрал болж цахим шилжилтийг хурдасган, хурдасгуур болж бидний аж амьдралын шинэ хэм хэмжээ боллоо.

Цар цахлын дэгдэлтээс урьдчилан сэргийлэх зорилгоор Монгол Улсын засгийн газраас шуурхай арга хэмжээнүүдийг авсан бөгөөд 2020 оны эхний улиралд бүх нийтийн хатуу хөл хорио тогтоон улсынхаа хилийг хааж, сургууль албан байгууллагуудын үйл ажиллагааг зогсоож, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулахыг хориглосон. Цар тахлын дэгдэлтийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх олон арга хэмжээ авч хэрэгжүүлсний үр дүнд оны ихэнх хугацаанд цар тахлыг дотоодод дэгдэхээс сэргийлж чадсан. Гэсэн хэдий ч 2020 оны 11 дүгээр сард цар тахлын дэгдэлт дотоодод газар авч Засгийн газраас хорио цээрийн илүү хатуу арга хэмжээ авч бүх нийтийн хөл хорио тогтоосон.

Хөл хорионы улмаас бизнесийн олон байгууллагын орлого буурч, зарим нь огт орлогогүй болж, компаниуд үйл ажиллагааныхаа зардлыг төлөх, санхүүгийн төлбөр тооцоогоо хийх чадваргүй болсон. Иргэд ажлын байраа алдаж, зарим нь богиносгосон цагаар ажилласнаар сарын орлого нь үлэмж багасаж байв. Орон сууцны зээл, бусад зээлийн эргэн төлөлт муудаж байв.

ХасБанкны хувьд ч асуудлуудтай тулгарсан. Нэгд, хатуу хөл хорионы үед банкны салбарууд иргэдэд нээлттэй байх зохицуулалт хийгдсэн тул бид ажилтнууд болон харилцагчдынхаа эрүүл мэнд, тэдний аюулгүй байдлыг хамгаалах үүргээ ухамсарлан биелүүлсэн. Эхний ээлжинд бид хүн хоорондын зай барих, ажлын байрны ариутгал халдваргүйжүүлэлтийг олон удаагийн давталттай хийх, амны хаалт заавал зүүх, биеийн халууныг шалгах, гарын ариутгал хийх, ажилтнууд өвчтэй байх тодорхой хугацаанд цалинг нь олгох зэрэг арга хэмжээ авч аюулгүй байдлын хатуу дэглэмийг банкны төв алба болон салбар тооцооны төвүүдэд мөрдсөн. Үүнээс гадна төв албаны ажилтнууд ээлжээр зайнаас буюу гэрээсээ ажиллах арга хэмжээ авлаа. Байгууллагын тасралтгүй хэвийн жигд ажиллагааг хангах цогц арга хэмжээг хурдан шуурхай авч ажилласан багийн гишүүдээрээ би бахархаж байна.

Хоёрт, КОВИД-19 цар тахалтай холбогдуулан Монголбанкнаас гаргасан удирдамжийн дагуу цар тахлын нөлөөгөөр бизнесийн үйл ажиллагаа нь саатсан харилцагчдын зээлийн гэрээний нөхцөлийг өөрчлөх ажлыг цаг алдалгүй хийхэд бид гол анхаарлаа хандуулсан. Мөн зээлийн бүтцийг өөрчлөх харилцагчдын хүсэлтийг цахимаар хүлээн авах хөгжүүлэлт хийлээ.

Манай салбарууд болон дуудлага хүлээн авах төв, мөн төв албаны ажилтнууд харилцагчдынхаа хүсэлтийг барагдуулахын тулд амралтын өдрүүд болон илүү цагаар ажиллаж байв. Шаардлагатай цаг үед харилцагчдадаа үнэнч байж тэдэнд үйлчлэх үүргээ ямагт эрхэмлэн биелүүлдэг нийт ажилтнууддаа талархал илэрхийлье.

Гуравт, эдийн засгийн тааламжтай бус, тодорхойгүй бөгөөд урьдчилан төсөөлшгүй нөхцөл байдалд банкны салбарт хийгдэх шинэчлэлийн хүрээнд тодорхой арга хэмжээнүүд авах шаардлага бидэнд тулгарсан. Шинэ зохицуулалтаар нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтэд илүү хатуу шаардлага тавигдаж, эрсдэлээр жигнэсэн активыг тооцох аргачлалд өөрчлөлт оруулсантай холбогдуулан бид илүү уян хатан бодлого хэрэгжүүлэхийн зэрэгцээ хатуу шийдвэрүүд гаргах шаардлагатай болсон.

Эцэст нь, хувьцаа эзэмшлийн бүтэц, арилжааны банкууд нийтэд хувьцаа гаргах асуудлыг зохицуулсан банкны тухай шинэ хууль гарна гэсэн хүлээлттэйгээр бид ХасБанкны хувьд зохистой актив хөрөнгөтэй, цэвэр хүүгийн эрүүл маржинтай, хангалттай хэмжээний нөөц сантай, цахим технологийг үргэлжлүүлэн хөгжүүлэх зорилт дэвшүүлэн ажиллаж байна.

Гүйцэтгэх захирлын МЭНДЧИЛГЭЭ

➤ Стратегийн зорилтоо биелүүлж бүтээмжийг нэмэгдүүлэх нь

Банкны ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, бизнесийн процессуудыг хялбаршуулах, тоон технологид амжилттай шилжихийн тулд 2019 оны ололт хөгжлийн импульсыг улам хүчтэй болгож хөрөнгийн бүтцийг сайжруулж, зардлаа бууруулах, эх үүсвэрийн өртөг зардлыг багасгах нь бидний стратегийн нэн тэргүүний зорилтууд байв. 2019 онд хийсэн стратегийн өөрчлөлтүүд нь хөрөнгөө илүү үр ашигтай ашиглах, илүү сайн байршуулахад голлон анхаарах, ингэснээр цар тахал зэрэг гэнэтийн асуудлыг даван туулж ирээдүйнхээ өсөлтийг дэмжих явдал юм. Авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн үр дүнд нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт оны эцсийн байдлаар 16.9 хувьд хүрсэн. Одоогийн нөхцөлд ч энэ үзүүлэлт сайн хэвээр байгаа нь бидэнд банкны IPO амжилттай гаргах таатай нөхцөлийг бүрдүүлж байгаа юм.

ХасБанк 2020 онд бизнесийнхээ давуу байдлыг харуулж санхүүгийн хувьд сайн үр дүнд хүрэв. Бид 29.8 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласнаар өөрийн хөрөнгийн өгөөж 12.3 хувь болж нэмэгдэв. Өнгөрсөн жил бид зээлийн хүү болон хураамжийн хэмжээг нэмэгдүүлээгүй, эргэн төлөлтийн хугацаа хэтрүүлсний торгууль суутгаагүй бөгөөд актив пассиваа зохистой удирдах, цэвэр хүүгийн маржиныг эрүүл хэмжээнд байлгахад анхаарч ажилласнаар ашигт ажиллагааныхаа түвшинг өсгөж чадсан юм. Санхүүгийн сахилгыг чандлан баримталж үйл ажиллагаануудын үр ашигт анхаарсан. Үүний үр дүнд ашиг зардлын харьцаа урьд өмнө байгаагүй 51.6 хувьд хүрсэн.

Улмаар тодорхой бус нөхцөл байдалтай өнгөрсөн хугацаанд зээл гаргаж хэт өндөр эрсдэл хүлээлгүй харин одоогийн харилцагчдаа дэмжсэн. Эцэст нь, илүү их хэмжээний эрсдэл, КОВИД цар тахлын нөлөөллөөс сэргийлэх зорилгоор үйл ажиллагааны орлогоосоо бид хангалттай хэмжээний буюу 21 тэрбум төгрөгийн эрсдэлийн сан байгуулсан.

Хэдийгээр цар тахлын сөрөг нөлөөллийг урьдчилан төсөөлөөгүй ч бид 2019 оноос эхлэн банкны баримтлах уян хатан стратегийг боловсруулж ирсэн нь 2020 онд санхүүгийн сайн үр дүнд хүрэхэд нөлөөлсөн. Эргэн харахад асуудлыг багаараа хэлэлцэж сорилтуудад илүү ухаалаг хандаж, чанга хатуу шийдвэрүүд гаргаж, нөлөө ихтэй чухал санаачилга гаргаж ажилласан нь биднийг амжилтад хүргэсэн юм.

➤ Тоон технологид шилжих нь

КОВИД -19 цар тахал нь зөвхөн банкууд төдийгүй бүх салбарынхны тоон технологид шилжих үйл явцыг хурдасгав. Харилцагчид цахим үйлчилгээг эрхэмлэх болсон нь компаниудын хувьд хурдан хялбар үйлчилгээг санал болгох шаардлагыг бий болгож байна. Өнгөрсөн жилийн цар тахлын үед манай банкны цахим үйлчилгээг идэвхтэй хэрэглэгчдийн тоо 58.2%-иар өссөнөөс гадна цахимаар болон картаар хийсэн гүйлгээний тоо 143% болон 120%-иар тус тус нэмэгдлээ.

КОВИД-19-өөс шалтгаалан хугацааны хувьд багагүй хоцорсон хэдий ч бидний удаан хүлээсэн Цахим банкны шинэ платформ харилцагчдад очиход бэлэн болсон. Ингэснээр иргэд, харилцагчид маань салбарт биечлэн очилгүйгээр банкны ихэнх үйлчилгээг байгаа газраасаа хурууны үзүүрээр авах боломжтой боллоо.

Цахим банкны шинэ платформын ашиглалт нэмэгдэхийн хэрээр цахим банкны үйлчилгээг идэвхтэй хэрэглэгчдийн тоо болон гүйлгээний тоо ойрын жилүүдэд өсөх хүлээлттэй байна. Цахим шилжилтийн нэг хэсэг болгож банкны шинэ үндсэн системд шилжих стратегийн шийдвэр гаргасан бөгөөд технологийн хурдан өөрчлөлтөд зохицсон тогтвортой, уян хатан системийг шинээр бий болгоно. Банкны үндсэн системийн багийн гишүүд шинэ системд тавигдах нөхцөл шаардлагуудыг нарийвчлан судалж уйгагүй ажилласны үр дүнд шинэ систем бэлэн боллоо.

Улмаар зээлийн хүсэлт хүлээн авч шийдвэрлэх, зээл хаах, барьцаа хөрөнгө үнэлэх, зээлийн скоринг хийх, хэрэглээний зээлийн мониторингийн үйл ажиллагааг автоматжуулах бизнес процессийн удирдлагын системийг нэвтрүүллээ.

Хурдан хувьсан өөрчлөгдөж буй технологийн ертөнцөд цахим шилжилтийг бид тууштай хийж ойрын ирээдүйд ч ХасБанкны үйлчилгээг илүү цахимжуулахын төлөө анхаарах болно.

➤ ХасЛизинг

2013 оноос хойш баримталсан бидний стратеги нь санхүүгийн болон үйл ажиллагааны үр өгөөжөө өгсөн хэвээр байна.

ХасЛизинг компани нь 2020 оныг 6.8 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай үдлээ. Өөрийн хөрөнгийн өгөөж 24.6 хувь болсноор компани дараалсан зургаан жилийн турш 20-иос дээш хувийн өгөөжтэй ажиллав.

Зээлийн чанар сайн хэвээр хадгалагдаж чанаргүй зээлийн эзлэх хэмжээ 1.1 хувь, эрсдэл даах харьцаа 157.1 хувьтай байв. Зардлыг хатуу удирдсанаар орлого зардлын харьцаа 17.8 хувь байв.

ХасЛизинг компанийн гүйцэтгэх захирал ноён С.Дауренбекийн удирдлага дор компани санхүүгийн амжилтад хүрнэ гэсэн хүлээлттэй байна.

➤ Тэнгэр Даатгал

2020 оны эхээр ноён Ж.Мөнхсайханыг компанийн гүйцэтгэх захирлаар томилсон.

Түүнчлэн шилжилтийн энэ үед туслах гурван захирлыг шинээр ажилд томиллоо. Компанийн үйл ажиллагааг гольдролд нь буцаан оруулах хялбаргүй даалгавар удирдлагын шинэ багт ногдсон. Ашигт ажиллагааг сайжруулах, цахим шилжилтийг удирдан чиглүүлэх, компанийн эрсдэлийг бууруулах нь нэн тэргүүний асуудал байв.

Үүний үр дүнд оны эцсийн байдлаар цэвэр орлого 1.6 тэрбум төгрөг, өөрийн хөрөнгийн өгөөж 15.7 хувьд хүрэв. Зардлын болон хохирлын харьцаа тус тус 59.7 ба 50.4 хувь болж нийлмэл харьцаа үзүүлэлт 110.1 хувьтай байв.

➤ Тянь Ронг

Тянь Ронгийг худалдах үйл явц амжилттай дуусгавар болж борлуулалтаас олсон орлогыг ТСНэгдлийн дансанд шилжүүлж авсан талаар тайлагнахад нэн таатай байна. Анх 2014 онд Тянь Ронгд оруулсан хөрөнгө оруулалтаас гарах шийдвэр гаргасан бөгөөд олон удаагийн амжилтгүй оролдлогын дараа бүгдээрээ биш гэхэд ихэнх хүн Тянь Ронгд оруулсан хөрөнгө оруулалтыг үхмэл гэдэг байв. 2019 оны дөрөвдүгээр сард хэнд яаж борлуулах стратегийг өөрчилж худалдан борлуулах үйл явцад бид бүх хүчээ зориулсан юм.

Бид дардан замыг туулсангүй. Гайхшрал цочрол цөөнгүй тохиолдож байв. Энэхүү цогц хэлцлийг амжилтад хүргэхэд үнэлж баршгүй хувь нэмэр оруулсан ТяньРонгийн гүйцэтгэх захирал ноён Д.Тэнгис, ноён Санжай Гүпта болон Захирлуудын зөвлөлд талархал илэрхийлэхийг хүсэж байна.

➤ Хэтийн төлөв

Эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдалд үндэслэн бид ирэх 2021 он нэлээдгүй сорилттой жил болно гэсэн хүлээлттэй байна. КОВИД-19 хямралын үргэлжлэх хугацаа, үзүүлэх нөлөөлөл нь тодорхойгүй байгаа нөхцөлд бид харилцагчдыг санхүүгийн хүндрэлийг даван туулахад нь дэмжих үүргээ үргэлжлүүлэн хүлээх болно. Бид эдийн засгийг идэвхжүүлэх, ажлын байрыг бий болгох санаачилгуудыг дэмжиж салбарынхаа хамтран зүтгэгчид, засгийн газар, зохицуулагчидтай цаашид ч хамтран ажиллах болно.

2020 оны сүүлийн хагаст нүүрс, зэс, алтны экспорт сэргэж нийт эдийн засгийн өсөлт анх тооцоолж байснаас хавьгүй бага буюу 5.3 хувиар агшсан. Засгийн газраас үзүүлж буй хөнгөлөлт дэмжлэгийн үр дүнд хатуу хөл хорионы үеэс бусад хугацаанд өрхийн хэрэглээ харьцангуй сайн байв. Хатуу хөл хорионы үед зогсмол байдалд байсан худалдаа, үйлчилгээний салбар, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа нь хорио цээрийн арга хэмжээг сулруулж, засгийн газрын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхтэй хамт сэргэнэ гэсэн хүлээлттэй байна. Бараа бүтээгдэхүүний үнэ тогтвортой байвал 2021 онд дотоодын нийт бүтээгдэхүүн 5-аас дээш хувиар өснө гэсэн хүлээлттэй байна.

Банкны тухай шинэ хууль 2021 оны нэгдүгээр сард батлагдаж системийн бүх банк хуулийн зохицуулалтаар 2022 оны зургаадугаар сарын 30-ны өдрийн дотор нээлттэй хувьцаат компани болно. Бид нээлттэй хувьцаа гаргах (IPO) тодорхой төлөвлөгөөнийхөө төслийг хувьцаа эзэмшигчдэд 2021 оны эхний хагаст танилцуулах болно. Нээлттэй хувьцаа гаргаснаар Монгол Улсын иргэдэд ХасБанкны хөгжил дэвшлийн нэгээхэн хэсэг болох боломжийг олгоно гэдэгт бид итгэл төгс байна.

Эцэст нь, ХасБанк, Тэнгэр Санхүүгийн Нэгдлийн ажилтнууддаа гүн хүндэтгэл, талархал илэрхийлмээр байна. Мөн гүйцэтгэх удирдлагын маш сайн баг, Захирлуудын зөвлөлөөс чиглүүлж байсан мэргэн удирдамж болон нийт хувьцаа эзэмшигчдийнхээ дэмжлэгтэйгээр бид энэ оны амжилтад хүрч чадлаа.

2021 оны 12 дугаар сард бид ХасБанкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсны 20 жилийн ойг тэмдэглэнэ. Эрсдэлийг хяналттай удирдаж урт хугацааны тогтвортой өсөлтийг хангахыг эрмэлзэж ажилласнаар манай харилцагчид, ажиллагсад болон хувьцаа эзэмшигчдэд илүү их үнэ цэн хүргэнэ.



Эрхэм зорилго

Эрдэнэт хүмүүн, Эх дэлхий, Эрүүл ашгийг эрхэмлэн харилцагчдадаа үнэ цэнтэй санхүүгийн үйлчилгээг хүргэж, насан туршийн түнш нь байх болно.



Хэтийн зорилт

Бид Монголдоо дэлхийн түвшний санхүүгийн үйлчилгээтэй байгууллага болно.

ХасБанк: 2020 он

Эрдэнэт хүмүүн, Эх дэлхий, Эрүүл ашиг эрхэмлэгч

БИД ХАСЧУУД

Бид БАГААРАА Санаачилгатай, Харилцагч төвтэй шийдлийг, Мэргэжлийн түвшинд ХАРИУЦЛАГАТАЙ, СЭТГЭЛТЭЙ үзүүлэн Нийгмийн хариуцлагаа ухамсарлан ёс зүйтэй, ХҮНЛЭГ байж илүү урагшаа тэмүүлнэ.

ХасБанк - 2020 он

2001



Анх 17 ажилтантай,

1 сая

ам.долларын хөрөнгөтэй,

бичил зээлийн үйл ажиллагаанаас эхэлсэн.

ХасБанк нь 2001 онд байгуулагдсан цагаасаа Монгол Улсын банк санхүүгийн системд тогтвортой өсөлтийг бий болгож, үйл ажиллагаагаа өргөтгөж ирсэн бөгөөд өдгөө системийн хэмжээний 4 том банкны нэг болоод байна.

2020



Өдгөө бид 1550 ажилтан

1.5 тэрбум

ам.долларын хөрөнгөтэй

системийн банк болон өргөжлөө.

2020 онд:


Ковид-19 хямралын хариу арга хэмжээг цаг тухайд нь авч, хямралаас гарах төлөвлөгөөг хэрэгжүүлж
Харилцагч, ажилтнуудын аюулгүй байдал, хэрэгцээг анхаарч
Санхүүгийн байдал, багцын чанарыг сайжруулж
Харилцагчдын итгэлийг дааж
Стратегийн чиглэлийг хадгалж ажиллалаа.

Санхүүгийн гүйцэтгэл

Нийт хөрөнгө

-6.1%


Тэрбум төг.



Зээлийн багц

-24.2%


Тэрбум төг.



Цэвэр ашиг


+244.4%

Тэрбум төг.



Өөрийн хөрөнгийн өгөөж


+8.5 %



Харилцах хадгаламж

+9.9%


Тэрбум төг.



Зээллэгийн эх үүсвэр


-33.2%

Тэрбум төг.




Хөрвөх чадвар (%)

+17.5%



Өөрийн хөрөнгийн хүрэлцээ (%)

+4.9%



Олон улсын үнэлгээ

2020 онд тус Банкны үнэлгээний агентлагууд болох Мүүдиз болон Фитч Рейтинг үнэлгээ хийж ХасБанкны гадаад зээлжих зэрэглэлийг баталгаажууллаа. Ковид-19 цар тахал болон олон нийтийн дунд банк, санхүүгийн системд томоохон шинэчлэл дагуулахаар хүлээгдэж буй Монгол Улсын Банкны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр тодорхойлогдсон тус жил банкны зүгээс үнэлгээний агентлагуудтай идэвхтэй хамтран ажиллаж, ажил хэрэгчээр харилцаж ирлээ.

СҮҮЛИЙН ҮЕИЙН ЯВЦЫН МЭДЭЭЛЭЛ:

- 2020 оны 5 дугаар сард** Мүүдиз агентлагаас манай банкны зэрэглэлийг B3 түвшинд хэвээр хадгалж, хандлагыг тогтвортойгоос сөрөг рүү шилжүүлсэн. Тус шийдвэр Монгол Улсын Засгийн газрын зэрэглэлийг B3 түвшинд хэвээр хадгалан, хандлагыг тогтвортойгоос сөрөг рүү шилжүүлсэн шийдвэртэй уялдан гарсан болно.
- 2021 оны 3 дугаар сард** Мүүдиз агентлагаас ХасБанкны хандлага сөрөг байсныг макро эдийн засгийн төлөв сайжирсан болон тус банкны зээлийн эрсдэлээс хамгаалах нөөц өндөр түвшинд байгаатай холбоотойгоор тогтвортой болгон сайжруулсан.
- 2020 оны 8 дугаар сард** Фитч Рейтинг агентлаг жил тутмын үнэлгээгээрээ манай банкны өмнөх зэрэглэл B болон хандлага тогтвортой байсныг хэвээр хадгалсан.

Moody's

"Мүүдиз" олон улсын үнэлгээний байгууллага (www.moody's.com) нь дэлхийн даяар бизнесийн болон төрийн байгууллагуудын санхүүгийн судалгаа, эрсдэлийг үнэлэх үйлчилгээ үзүүлдэг.

	2021 оны 3 дугаар сар
Оролцогч талын эрсдэлийн зэрэглэл – гадаад валют	B3/NP
Оролцогч талын эрсдэлийн зэрэглэл – төгрөг	B2/NP
Хадгаламж	B3/NP
Зээлийн суурь үнэлгээ	B3
Үнэт цаас гаргагчийн зэрэглэл	B3
Хандлага	Тогтвортой

FitchRatings

"Фитч" олон улсын үнэлгээний байгууллага (www.fitchratings.com) нь дэлхийн даяар бизнесийн болон төрийн байгууллагуудын санхүүгийн судалгаа, эрсдэлийг үнэлэх үйлчилгээ үзүүлдэг.

	2020 оны 8 дугаар сар
Гадаад валютын урт хугацаат үүргийг биелүүлэх зэрэг	B/Тогтвортой
Гадаад валютын богино хугацаат үүргийг биелүүлэх зэрэг	B
Төгрөгийн урт хугацаат үүргийг биелүүлэх зэрэг	B/Тогтвортой

Санхүүжүүлэгч, түнш байгууллагууд



ОУСК бол Дэлхийн банкны группийн гишүүн, хөгжиж буй зах зээл дэх хувийн хэвшлийг дэмжих зорилттой дэлхийн хамгийн том хөгжлийн чиглэл бүхий байгууллага юм. ОУСК-ийн гол зорилго нь хувийн хэвшилд зориулсан санхүүгийн эх үүсвэрийг дайчлах, ядууралд нэрвэгдсэн хүмүүст ажлын байр бий болгох бизнесийг дэмжих замаар ард иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх боломжийг бий болгох явдал юм. ОУСК нь ХасБанкны хувьцаа эзэмшигч юм.



1962 онд байгуулагдсан DEG нь 2001 оноос хойш KfW группийн бүрэн эзэмшлийн охин компани бөгөөд хөгжиж буй зах зээл дээр эзэл эсвэл өөрийн хөрөнгө хэлбэрээр урт хугацааны эх үүсвэрийг олгодог. DEG нь хөгжиж буй болон шилжилтийн үеийн орнуудад гарааны бизнес эрхлэх санаачилгыг дэмжиж, санхүүжүүлж ажилладаг. DEG нь өөрийн хөрөнгө оруулалтынхаа, тухайн улсын хэтийн хөгжлийн нөлөөнд ихээхэн эц холбогдол өгдөг ба урт хугацааны харилцааны туршид ХасБанкаар дамжуулан Монгол Улсын эдийн засагт ЖДҮ-ийн сегментийг санхүүжүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг буй болгосон.



Ногоон Уур амьсгалын Сан ("GCF") нь НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн хүрээний конвенцын хүрээнд 2010 онд байгуулагдсан сан юм. GCF нь хүлэмжийн хийн ялгарлыг хязгаарлаж, цаг уурын өөрчлөлтөд дасан зохицохыг, ирээдүйд уур амьсгалд тэсвэртэй хөгжлийн замыг бий болгох талаар улс орнуудыг дэмжиж ажилладаг. Санхүүжилтийг итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжүүдээр дамжуулан олгодог бөгөөд ХасБанк нь Монгол улс дахь магадлан итгэмжлэгдсэн арилжааны цорын ганц банк юм.



Proparco бол хувийн хэвшлийн хөгжилд чиглэсэн Францын Хөгжлийн Агентлагийн ("ФХА") эзэмшдэг томоохон компани бөгөөд эдийн засаг, нийгэм, байгаль орчны тогтвортой хөгжлийг дэмжсэн гол чиглэл баримталдаг. PROPARCO нь дэлхийн 80 оронд үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд 500 гаруй үйлчлүүлэгчтэй, эдгээрт нь жижиг дунд бизнес эрхлэгчдээс бичил санхүүгийн байгууллагуудыг багтаасан бүс нутгийн банкны байгууллагуудад орох бөгөөд 2019 онд ХасБанкны хамтын санхүүжилтээр татан төвлөрүүлсэн эх үүсвэрийг олгогчдын нэг юм.



Инкофин хөрөнгө оруулалтын удирдлагын компани (Инкофин ХӨМ) нь хөгжиж буй орнуудын бичил санхүүжилт олгодог бизнесүүдийг дэмждэг хөрөнгө оруулалтын сангуудад зөвлөгөө өгдөг байгууллага юм. Бичил санхүүгийн бизнесүүд нь банк тогтмол хүрч ажиллах боломжгүй хүмүүс, хувиараа бизнес эрхлэгч нарт зээл, хадгаламж, даатгалын зэрэг санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг. Бичил санхүүгийн чиглэл дотроо хөдөө орон нутгийн санхүүжилтэд мэргэшсэний хувьд Инкофин ХӨМ-ийн гол зорилго бол илүү алслагдмал орон нутагт амьдардаг, мөн хөдөө аж ахуйн салбарт идэвхтэй ажилладаг хүмүүст хүрч дэмжлэг үзүүлэх явдал юм. Инкофин ХӨМ 66 орны 300 гаруй байгууллагыг санхүүжүүлж, дэмжиж ажилладаг.



Нидерландын Хөгжлийн Санхүүгийн Компани ("FMO") нь Голландын засгийн газрын олонхын хувь эзэмшдэг гурван А үнэлгээтэй, хөгжлийн банк юм. FMO нь гарааны бизнесийн хөгжлийг эдийн засгийн тогтвортой өсөлтийн түлхүүр бөгөөд улмаар ард түмний амьжиргааны түвшин сайжирна гэж үздэг. FMO-ийн үндсэн чиг үүрэг бол эрсдэлийн хөрөнгө оруулалтаа урт хугацааны төслүүдэд болон ирээдүйд нөлөө бүхий салбарт чиглэсэн урт хугацааны хөрөнгө оруулалт хийх явдал юм.



Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны банк ("IBEC") нь 1963 онд байгуулагдсан олон улсын хөгжлийн санхүүгийн байгууллага юм. IBEC нь түүний гишүүн найман орны аж ахуйн нэгжүүдийн эдийн засгийн хөгжил, гадаад худалдааны харилцааг дэмжихэд чиглэдэг. IBEC нь экспорт импортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгжийг санхүүжүүлэх зорилгоор 100 сая ам.долларын хамтын ажиллагааны гэрээг байгуулсан байгаа.



ОПЕК-ийн Олон улсын хөгжлийн сан ("OFID") нь 1976 онд байгуулагдсан олон улсын хөгжлийн санхүүгийн байгууллага юм. OFID нь дэлхий даяар нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд дэмжлэг үзүүлэх зорилгоор төр, хувийн болон худалдааны салбарын санхүүжилтийг олгодог. 100 сая ам.долларын хамтын ажиллагааны санхүүжилтийн хэлэлцээрт, худалдааны санхүүжилтийг дэмжих эх үүсвэрийн гэрээг ХасБанктай байгуулсан.



Швейцарын хөрөнгө оруулалтын сан ("SIFEM") нь Швейцарын засгийн газрын 2005 онд байгуулагдсан хөгжиж буй орнуудыг дэмжих зорилттой санхүүгийн байгууллага юм. SIFEM нь ажлын байр бий болгож буй бизнес эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх замаар хөгжиж буй орнуудад урт хугацааны, тогтвортой, хүртээмжтэй эдийн засгийн өсөлтийг бий болгодог. Тус санг 2016 оноос хойш ХасБанктай амжилттай хамтран ажиллаж, идэвхтэй харилцааг бий болгосон хөрөнгө оруулалтын мэргэшсэн зөвлөх Obviaм удирддаг.




Хөгжиж буй дэлхийн зах зээл ("DWM") нь АНУ-д суурилсан хөрөнгө оруулалтын удирдлагын компани бөгөөд эдийн засгийн тогтвортой хөгжлийг дэмжих чиглэлтэй зөвхөн хөгжиж буй зах зээлд хөрөнгө оруулалт хийдэг байгууллага юм. 1994 онд байгуулагдсан үүсгэн байгуулагчдын хувийн өмчлөлтэй ба Голланд, Герман, Япон гэх мэт олон улсын зах зээлээс өнөөг хүртэл 2 тэрбум гаруй ам.долларын санхүүжилтийг босгосон бөгөөд тэдгээрийн хөрөнгө оруулалтыг удирддаг.



Азийн хөгжлийн банк ("АХБ") нь 1966 онд байгуулагдсан, 1991 оноос хойш Монгол Улсыг эгнээндээ багтаасан 68 гишүүн бүхий бүс нутгийн хөгжлийн банк ба боловсрол, хүрээлэн буй орчин, дэд бүтэц, бүс нутгийн хамтын ажиллагаа, санхүүгийн салбар гэсэн үндсэн чиглэлтэй үүсэж байсан бол хувийн хэвшлийн санхүүжилт сүүлийн 10 жилд ихээхэн хэмжээгээр өсөж, одоо үндсэн хөрөнгийн 20 орчим хувийг эзэлж байна.



Европын сэргээн босголт, хөгжлийн банк ("ЕСБХБ") нь олон улсын хөгжлийн хөрөнгө оруулалтын банк бөгөөд 1991 онд байгуулагдсан санхүүгийн байгууллага юм. Үндсэн чиг үүрэгтээ байгаль орчны хариуцлагыг багтаасан анхны олон улсын банк бөгөөд 40 хувийн санхүүжилтээ ногоон хөрөнгө оруулалтад зориулах хэтийн зорилтдоо 2017 онд хүрчээ. ХасБанк болон ЕСБХБ-ны хоорондын урт хугацааны харилцаат хамтын ажиллагаанд хөрөнгө оруулалт, эх үүсвэр болон худалдааны санхүүжилт зэрэг багтана.



АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Санхүүгийн Корпораци ("DFC") хуучнаар OPIC) буюу Америкийн хөгжлийн банк нь 1971 оноос үүсэлтэй байгууллага юм. DFC нь хөгжиж буй дэлхийд өмнө тулгараад байгаа хамгийн хүнд сорилтуудын шийдлийг санхүүжүүлэх зорилгоор хувийн хэвшилтэй хамтран ажилладаг ба ажлын байр бий болгогч жижиг бизнес эрхлэгчид, эмэгтэй гарааны бизнес эрхлэгчдийг дэмжиж ажилладаг. ХасБанк нь эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор 2017 онд DFC-с санхүүжилт авсан байна.



Финландын аж үйлдвэрийн хамтын ажиллагааны сан ("FinnFund") нь Финландын төрийн болон хөрөнгийн зах зээлийн санхүүжилттэй хөгжлийн санхүүгийн компани юм. Finnfund нь эрсдэлийн хөрөнгө, урт хугацааны зээл, хөгжиж буй орнуудын хэрэгжүүлж буй төслүүдийн санхүүжилтийг олгож, улмаар тогтвортой хөгжлийг хангах төслийн хөрөнгө оруулалтынхаа бүх ашгийг ахин санхүүжилтээр эргэж олгох бодлого баримталдаг. Finnfund болон ХасБанктай харилцаагаа 2019 онд гүйцэтгэсэн хамтын санхүүжилтээр бэхжүүлж бататгасан байна.



Symbiotics бол хөгжиж буй орнуудын бичил, жижиг, дунд үйлдвэрлэл аж ахуй (БЖДҮ) болон дундаж болон түүнээс доош орлоготой өрхийг дэмжих, санхүүжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг тэргүүлэгч хөрөнгө оруулалтын компани юм. Тус компани нь хөрөнгө оруулалтын цогц үйлчилгээний төвлөрлийг буй болгосон байдаг ба хувийн хэвшлийн эх үүсвэрийн удирдлага, зөвлөх үйлчилгээ зэргийг санал болгодог юм. Одоогийн байдлаар олон тооны зээлдэгчдийг хамарсан 25 гаруй санг удирддаг.

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц

ХасБанк нь ТэнГэр Санхүүгийн Нэгдэл /ТСН/ ХХК-ийн бүрэн эзэмшлийн охин компани юм.

ТСН ХХК нь олон улсын санхүүгийн байгууллагууд, дотоодын болон гадаадын нэр хүндтэй компаниуд, хөрөнгө оруулалтын сангууд, төрийн бус байгууллагууд болон хувь хүмүүсээс бүрдсэн хувьцаа эзэмшигчидтэй ба одоогоор Монгол Улсын банк, санхүүгийн салбарт ийм олон талын хувьцаа эзэмшигчдийн бүтэцтэй цорын ганц компани юм.

20.00%	МОНГОЛЫН АЛТ /МАК/	
17.171 %	ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН КОРПОРАЦИ	
16.812 %	ОРИКС КОРПОРАЦИ	
12.905 %	ЕВРОПЫН СЭРГЭЭН БОСГОЛТ ХӨГЖЛИЙН БАНК	
10.516 %	КАНАДЫН ҮНДЭСНИЙ БАНК	
10.150 %	РОНОК ПАРТНЕРЗ	
6.625 %	МОНГОЛИАН ФАЙНЭНШЛ СЕРВИСИЗ	
3.730 %	ТРИОДОС ФЭЙР ШЭЙР ФАНД	
1.593 %	НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ ТББ	
0.301 %	УЛААНБААТАР РОТАРИ КЛУБ ТББ	
0.102 %	МАГВАНЫ БОЛДОО	
0.093 %	ЧУЛУУНЫ ГАНБОЛД	

Төлөөлөн Удирдах Зөвлөл¹

(2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар)

ТУЗ-ийн дарга

Санжай Гүпта

ТУЗ-ийн дарга

ТУЗ-ийн гишүүд

Гүмэнжавын Цэвэгжав

ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал

Андрэж Витак

ТУЗ-ийн гишүүн

Майкл Мадден

ТУЗ-ийн гишүүн

Ив Жако

ТУЗ-ийн гишүүн

Нираж Вэдва

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Албертус Браггинк²

ТУЗ-ийн гишүүн

Мелисса Мой Тиан

ТУЗ-ийн гишүүн

Нямтайширийн Цэлмүүн

ТУЗ-ийн гишүүн

Морис Лам

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Баянсаны Уламбаяр

ТУЗ-ийн хараат бус гишүүн

¹Жилийн тайлангийн 56-р хуудас дахь Зохистой засаглалын тайлангаас дэлгэрэнгүй мэдээллийг авна уу.
²2021 оны 3 дугаар сарын 31-ний өдөр хуралдах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэлх түр томилолт.

Гүйцэтгэх удирдлага

(2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар)



Гүмэнжавын Цэвэгжав

Гүйцэтгэх захирал
2019 оны 5 дугаар сарын 8-нд томилогдсон



Ганзоригийн Эрдэнэбаяр

Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч бөгөөд
Санхүү хариуцсан захирал
2013 оны 1 дүгээр сарын 7-нд томилогдсон



Энэбишийн Уламбаяр

Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд
Иргэдийн банк хариуцсан захирал
2020 оны 1 дүгээр сарын 31-нд томилогдсон



Бавааны Еркин

Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд
Байгууллагын банк хариуцсан захирал
2020 оны 1 дүгээр сарын 31-нд томилогдсон



Илия Аврамов

Эрсдэл хариуцсан захирал
2019 оны 10 дугаар сарын 15-нд томилогдсон



Ганзоригийн Зул

Үйл ажиллагаа хариуцсан захирал
2020 оны 1 дүгээр сарын 31-нд томилогдсон



Хүрэлбаатарын Өнөрбат

Мэдээллийн технологи хариуцсан захирлын
үүрэг гүйцэтгэгч
2021 оны 1 дүгээр сарын 18-нд томилогдсон



Энхбаярын Ундармаа

Ерөнхий аудитор
2016 оны 5 дугаар сарын 6-нд томилогдсон



Дашнямын Ашидмаа

Хөрөнгө оруулагчдын харилцаа, компанийн
засаглал хариуцсан захирал
2014 оны 8 дугаар сарын 1-нд томилогдсон


Макро эдийн засгийн төлөв

Монгол Улсын Үндэсний Статистикийн Хорооны урьдчилсан мэдээгээр Монгол Улсын эдийн засаг 5.3%-иар уналаа. 2017-оос 2019 оны 5.9%-ийн дундаж өсөлттэй харьцуулахад ийнхүү буурсан нь Ковид-19 цар тахалтай холбоотой авч хэрэгжүүлсэн хориг арга хэмжээнүүд уул уурхай болон үйлчилгээний сектор хүчтэй сөргөөр нөлөөлсөнтэй холбоотой. Зардлын талаас авч үзвэл хувийн секторын хөрөнгө оруулалт огцом бууралттай байсан.

Хэдий вакцинжуулалт нийт хүн амд хангалттай хүрч, цар тахал хумигдах хүртэл эдийн засгийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх хориг арга хэмжээ болон тодорхой бус байдал байсаар байх боловч уул уурхайн салбар дахь хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн өсөлтийн тусламжтайгаар 2021-2022 онуудад эдийн засгийн өсөлт 5 орчим хувьд хадгалагдахаар байна.

Эдийн засгийн өсөлт 2015-2020

Эх сурвалж: Монголбанк



Монгол Улсын төрийн зүгээс Ковид-19-той холбоотой хориг арга хэмжээ болон эрэлтийн удаашралыг тааламжгүй нөхцөл байдлын эсрэг эдийн засгийг хамгаалахаар сангийн болон мөнгөний бодлогын хүрээнд томоохон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн. 2020 оны төсвийн алдагдал батлагдсан хэмжээ болох ДНБ-ий 5.1%-иас тэлж ДНБ-ий 12.5%-тай гарсан нь эрэлтийг дэмжих томоохон арга хэмжээний илэрхийлэл болно. Засгийн газрын зүгээс орлогын татвар, нийгмийн даатгалын хураамжийг түр хугацаанд цуцлан эдийн засаг дахь татварын дарамтыг бууруулж өгөхөөс гадна Хүүхдийн мөнгийг нэмэгдүүлэх замаар өрхүүдэд чиглэсэн шилжүүлгийн зардлыг нэмэгдүүлсэн.


Эдгээр арга хэмжээ нь цар тахлын үед өрхийн хэрэглээ харьцангуй тогтвортой байхад дэмжлэг үзүүлсэн. Цаашлаад Засгийн газрын зүгээс “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наяд” – ын 3 жилийн хугацааны хөтөлбөрийг 2021 оны 2 дугаар сард зарлаад байгаа бөгөөд уг хөтөлбөрийн хүрээнд жижиг, дунд үйлдвэрлэл, уул уурхайн бус экспорт, барилга, хөдөө аж ахуй зэрэг гол салбаруудад болон стратегийн төслүүдэд хөнгөлөлттэй зээл олгохоор байна.

Монгол Улсын 2018-2020 оны экспортын 84.7%-ийг худалдаж авсан, хамгийн том худалдааны түнш болох Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ)-ын эдийн засаг 2020 онд 2.3%-иар өслөө. Энэ нь хэдийгээр бусад томоохон эдийн засгуудтай харьцуулахад сайн үзүүлэлт боловч БНХАУ-ын хувьд сүүлийн 40-өөд жилийн хамгийн бага өсөлт байлаа. Хэдий тийм боловч, худалдааны нөхцөл чангарсан болон Хятадын зүгээс Монгол Улсаас худалдан авах эрдэс бүтээгдэхүүний эрэлт харьцангуй сайн байсан зэрэгтэй холбоотой Хятадын эдийн засгийн удаашралын Монгол Улсад үзүүлэх нөлөө харьцангуй зөөлөн байв. Дэлхийн эдийн засаг 2021 онд сэргэх хүлээлттэй байгаа бөгөөд Хятадын эдийн засгийн хувьд 7-9% өсөлттэй гарахаар байгаа нь Монгол Улсын хувьд эерэг нөхцөлийг бүрдүүлж байна.

Өнгөрсөн онтой харьцуулахад импорт нэлээд буурч (0.9 тэрбум ам.доллар), экспорт өөрчлөлт багатай байсны улмаас гадаад худалдааны тэнцэл 2020 онд 2.3 тэрбум ам.долларын (ДНБ-ийн 17%) ашигтай гарлаа. Хэдий жилийн эхний хагаст огцом бууралттай гарсан боловч хоёрдугаар хагасаас нүүрс, зэсийн экспорт сэргэж, алтны экспорт огцом нэмэгдсэн. Газрын тосны үнэ бага болон дотоодын эрэлт сул байгаатай уялдан импорт буурсан. Цаашид Оюутолгойн үйлдвэрлэлийн эерэг хүлээлт зэргээс шалтгаалан экспорт тогтвортой өсөлт үзүүлэхээр байгаа боловч эдийн засгийн сэргэлттэй уялдан импорт сэргэснээр гадаад худалдааны ашиг харьцангуй сулрах талтай.

Худалдааны тэнцэл (тэрбум.доллар)

Эх сурвалж: Монголбанк




Төлбөрийн тэнцэл (гадаад валютын албан нөөц (ГВАН)-ийн өөрчлөлт) гадаад худалдааны ашиг болон Ковид-19-ийн холбоотой олон улсын дэмжлэгтэй холбоотойгоор 2020 онд 0.8 тэрбум ам.долларын ашигтай гарлаа. Тийнхүү Монголбанкны ГВАН 2020 оны эцсийн байдлаар түүхэн дээд түвшин 4.5 тэрбум ам.долларт хүрсэн.

2021 онд томоохон гадаад эргэн төлөлт үгүй тул 10 сар орчим импорттой тэнцэх гадаад валютын нөөц нь харьцангуй өндөр гэж үзэж байна.

ГВАН болон долларын ханш

Эх сурвалж: Монголбанк



2020 оны 12 дугаар сарын байдлаар газрын тосны бага үнэ болон дотоодын сул эрэлттэй холбоотойгоор жилийн инфляци 2.3% байлаа. Хүнсний бүтээгдэхүүний инфляцийн хувьд гэнэтийн худалдан авалт, хөл хорионы улмаас 2020 оны эцсийн байдлаар 8.5% байна. Эдийн засгийн сэргэлт, газрын тосны үнэ хэвийн түвшинд хүрэх явдал дотоодын үнэнд нөлөөлөх зэргээс шалтгаалан инфляци нэмэгдэх хүлээлттэй байна. Монголбанкны инфляцийн зорилт 2021 оноос хуучин “8% буюу түүнээс доош” байснаас “6% (+/- 2%)” болж өөрчлөгдөж буйг дурдах нь зүй. Хуучны 8%-ийн зорилтоос бага 6%-ийн түвшинд төвтэй интервал бүхий шинэ зорилт нь дунд хугацаанд инфляци болон нэрлэсэн хүүг бууруулах нөлөө үзүүлэх хүлээлттэй байна.

2020 оны 1 дүгээр сараас хойш 4 орчим хувь сулраад байсан төгрөгийн ам.доллартай харьцах ханш жилийн хоёрдугаар хагаст экспорт сэргэсэнтэй уялдан тогтвортой байлаа. 2020 онд төгрөг Хятадын юанийн эсрэг 10%-иар суларсан байна.


Нам инфляци, төгрөгийн ханшийн тогтвортой одоогийн орчинд Монголбанкны зүгээс эдийн засгийг Ковид-19-ийн нөлөөнөөс хамгаалахад ихээхэн оролцоотой байна. Бодлогын хүү 2020 оны 3 дугаар сард 11% байснаас 11 дүгээр сард 6% болон буурсан. Түүнчлэн банкнууд болон тэдгээрийн харилцагчдад тулгарч буй хөл хорио, тодорхойгүй байдлаас үүдэлтэй хүндрэлийг хөнгөвчлөх зорилгоор заавал байлгах нөөц болон бусад зохистой харьцааны шаардлагуудаа сулруулсан. Мөн орон сууцны болон репо санхүүжилтээ нэмэгдүүлсэн. Цаашид Монголбанкны зүгээс “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын хөтөлбөр”-ийн санхүүжүүлэх зарим үүргийг хүлээхээр байна.

Банкны салбар

Ковид-19 цар тахлын тодорхойгүй байдлын улмаас банкны салбар дахь нийт зээлийн хэмжээ 17.2 их наяд төгрөг болж 2020 онд 4.9%-иар буурлаа. Нийт зээлийн үлдэгдлийн 8.7 их наяд төгрөг (50.1%) нь иргэдийн, 7.9 их наяд (46.1%) нь байгууллагын, 0.6 их наяд (3.8%) нь бусад секторт олгогдсон байна. 2020 онд байгууллагын зээл 6.6%, иргэдийн зээл 7.7%-иар тус тус буурчээ.

2020 оны 12 дугаар сарын байдлаар банкны систем дэх Чанаргүй зээлийн хувь өмнөх жилийн мөн үеийн 10.1%-иас өсөж 11.7% хүрсэн бол Хугацаа хэтэрсэн зээлийн хувьд 4.6%-иас 7.4% болж нэмэгджээ. Нийт эрсэдсэн зээлийн хэмжээ (Чанаргүй+Хугацаа хэтэрсэн) өндөр түвшин байгаа нь Ковид-19 цар тахлаас үүдэн суларсан эдийн засгийн үйл ажиллагаатай холбоотой.

Банкны салбарын чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ, хувиар




Эх сурвалж: Монголбанк

Монголбанкны мэдээлснээр системийн хэмжээний өөрийн хөрөнгийн харьцаа үзүүлэлт нь хамгийн доод шалгуур үзүүлэлт болох 12%-ийг давсан байдалтай байна. Нийт банкны нөөцийн хуримтлал (Монголбанкин дахь) 2020 оны 12-р сарын байдлаар нийт хадгаламжийн 19 орчим хувийг эзэлж буй нь төгрөгийн зайлшгүй байх нөөцийн доод хэмжээ болох 6%-иас (гадаад валютын хувьд 15%) давсан үзүүлэлт юм. Түүнчлэн, хөрвөх чадварын харьцаа буюу банкны нөөц, төв банкны үнэт цаас, Засгийн газрын бонд зэргийг багтаасан түргэн хөрвөх активуудын банкны нийт өртэй харьцуулсан харьцаа нь 2020 оны 12-р сард 36% буюу Монголбанкнаас тогтоосон доод хэмжээ болох 20%-с мөн давсан үзүүлэлт болно.

2020 оны 12 дугаар сарын байдлаар төгрөгийн шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 14.75% болж өмнөх жилийн мөн үеэс 2.1 нэгж хувиар буурсан бол, гадаад валютын шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 9.8% болж өмнөх оны мөн үеэс 1.1 нэгж хувиар нэмэгдсэн байна. Харин шинээр татсан төгрөгийн хадгаламжийн хүү 2020 оны 12 дугаар сарын байдлаар 8.36% болж өмнөх оны мөн үеэс 2.2 нэгж хувиар буурсан байна. Төгрөгийн хүүгийн бууралт бодлогын хүү бага түвшинд хүрсэн болон харилцах, хугацаагүй хадгаламжид хүү тооцохыг зогсоосон шийдвэрүүдтэй голчлон хамааралтай.

Банкны салбарын зээлийн хэмжээ болон зээлийн хүү



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Иргэдийн Банк

Галтсуман мөндөр ХХК

ХасБанкны Ард салбарын харилцагч Галтсуман мөндөр ХХК нь “Оргил”, “Жанчивлан” рашаан үйлдвэрлэл, “Цэвэр жимс” чавганы цай, үзэмний шүүсний үйлдвэрлэл эрхэлдэг. Мөн 2007 оноос эхлэн Монгол улсад Кука Курортная, Алостар брендийн сахаргүй жүүс зэрэг бүтээгдэхүүнүүдийг тасралтгүй импортлон оруулж ирж Улаанбаатар хотын сүлжээ дэлгүүрүүдэд болон орон нутгийн харилцагч нарт нийлүүлж байна. ХасБанктай 2011 оноос хойш бизнесийн зээлээр хамтран ажиллаж байгаа.

Хамгийн сүүлд 2018 онд 130 сая төгрөгийн бизнесийн зээлийн шугам авч, хэвийн төлж барагдуулсан. Нийт 20 гаруй ажилтантай. 2020 онд цар тахлын нөлөөгөөр ажлын байрыг цомхотгоогүй, ажлын байраа тогтоон барьж ажилласан.

➤ КОВИД-19 цар тахлын нөлөөнд өртсөн харилцагчдад үзүүлсэн дэмжлэг

Бидний нэн тэргүүний зорилт харилцагчдад банкны бүтээгдэхүүн үйлчилгээг тасралтгүй, эрсдэлгүй, түргэн шуурхай хүргэх явдал байлаа.

Энэхүү ажлын хүрээнд харилцагчдад банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг цахимаар хүргэхэд анхаарал хандуулж, цахим үйлчилгээнд бүртгэлгүй харилцагчдыг цахимжуулж, салбар, тооцооны төвүүдэд тогтмол хугацаанд ариутгал, халдваргүйжүүлэлт хийж, хөл хорионы үед салбар, нэгжүүд ажиллахгүй үед банкны Харилцагчийн үйлчилгээний төвийн нөөцийг нэмэгдүүлж, харилцагчийн санал, хүсэлтийг түргэн шуурхай шийдвэрлэж ажиллалаа.

Мөн банкны цахим хуудас болон харилцагчийн банканд бүртгэлтэй цахим шуудан, гар утсаар дамжуулан харилцагчдад шаардлагатай мэдээ, мэдээллийг тогтмол хүргэлээ.

Иргэдийн зээлийн нөхцөл өөрчлөх болон МИК-ийн орон сууцны зээлийн төлбөр хойшлуулах хүсэлтийг банкны цахим хуудсаар дамжуулан онлайнаар хүлээн авч, 2020 онд нийт 5.9 мянган харилцагчийн 269 тэрбум төгрөгийн орон сууцны зээлийн төлбөрийг хойшлуулж, 16 мянган харилцагчийн 313 тэрбум төгрөгийн зээлийн нөхцөлийг өөрчилсөн байна.

➤ Иргэдийн харилцах, хадгаламж

Иргэдээс татсан харилцах, хадгаламжийн багц өмнөх оноос 13 хувиар өсөж 1 их наяд 874 тэрбум төгрөгт, нийт харилцах, хадгаламж эзэмшигчдийн тоо 857 мянгад хүрсний 208 мянган хадгаламж эзэмшигч нь хүүхэд байна. Эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан банк хадгаламжийн хүүг шат дараалан бууруулсан нь тайлант хугацаанд эх үүсвэрийн өртөг 2 нэгж хувиар буурч, банкны санхүүгийн үр ашгийг нэмэгдүүлэхэд голлон нөлөөллөө.

Тайлант хугацаанд Корона вирус цар тахлын тархалт нэмэгдэж, бизнесүүд хөл хорионд өртөж үйл ажиллагаа нь хумигдсан хүндхэн жил байсан ч ХасБанк иргэдийн зээлийн багцыг тогтвортой түвшинд хадгалж 1 их наяд 48 тэрбум төгрөгт хүргэлээ. Мөн харилцагчийг хамгаалах зарчмуудыг зээлийн үйл ажиллагаандаа мөрдөж, банкны харилцагчдыг өрийн дарамтад оруулах бус хэрэгцээтэй санхүүжилтийг олгосноор иргэдийн чанаргүй зээлийн түвшинг 5.9 хувьд барьж банкны салбарт тэргүүлэх үр дүнг үзүүлээ.

Монголбанкнаас бодлогын хүүг бууруулсантай холбогдуулан 2020 онд ХасБанкнаас иргэдэд олгодог бизнесийн зээлийн хүү 2 хүртэлх нэгж хувиар, хэрэглээний зээлийн хүү 4 хүртэлх нэгж хувиар тус тус буурлаа.

Харилцагчдад зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг түргэн шуурхай хүргэх зорилгоор дэвшилтэт технологийг зээлийн үйл ажиллагаандаа үе шаттай нэвтрүүлснээр иргэдийн зээл шийдвэрлэх дундаж хугацааг 2 дахин багасгаж, 2020 оны нийт зээл олголтын 62 хүртэл хувь нь цахимаар олгогдлоо.

➤ Салбарын удирдлага

Харилцагчдад тав тухтай үйлчилгээ үзүүлэх, цар тахлын үед үйлчлүүлэгч хоорондын зай бариулах, харилцагч, ажилтнуудыг эрсдэлээс хамгаалах зорилгоор салбаруудад хөрөнгө оруулалт хийхээс гадна харилцагчид санхүүгийн зөвлөгөө өгдөг ажилтнуудыг шинээр авах, сургах ажлыг зохион байгуулж ажиллалаа.

2020 онд салбар, нэгжийн байршил болон тоонд өөрчлөлт ороогүй байна.



Улаанбаатар хот

Салбар	10
Тооцооны төв	24
Өргөтгөл	1



Орон нутаг

Салбар	23
Тооцооны төв	17
Өргөтгөл	2

Нийт **77**

Иргэдийн Банк

Шинэ сорилт Шинэ боломж

2020 он сорилтоор дүүрэн жил болж өнгөрлөө. КОВИД-19 цар тахал манай бизнесийн үйл ажиллагаанд шууд нөлөөлсөн хэдий ч хамт олноороо хүрсэн амжилт, хийж бүтээсэн зүйлсээрээ бахархахгүй байхын аргагүй. Өнгөрсөн онд ХасБанкны цахим шилжилтийг зогсолтгүйгээр үргэлжилсэн төдийгүй бидний сүүлийн 3 жилийн нөр их хөдөлмөр, бэлтгэл ажил үр хоосонгүй байсныг баталж, бодит үр шимээ өгч эхэлсэн юм. КОВИД-19 цар тахлын энэхүү тодорхойгүй нөхцөлд манай хамт олон гэрээсээ ажиллах горимд хялбархан шилжиж чадсан. Энэ нь бидэнд хором ч алдалгүй зайнаас банкны үйлчилгээ үзүүлэх улам эрчилж, шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх, өөрсдийнхөө үйл ажиллагааны процессуудыг технологийн шинэчлэлтэй уялдуулж ажиллах шаардлагыг үүсгэж, хөшүүрэг нь болж өгдөг онцлогтой.

Энэ хэцүү цаг үед харилцагчдадаа банкны үйлчилгээг авах боломжийг нээлттэй үлдээх, банкныхаа ажилчдын эрүүл аюулгүй байдлыг хангаж ажиллах нь бидний хувьд маш чухал даваа байлаа. Цар тахал олон шинэ бэрхшээлийг бий болгосон хэдий ч мөн олон шинэ боломж бололцоо байгааг ойлгуулсан юм. Цар тахал нь бид бүгдийн нийтээрээ цахимжих процессыг хүчээр хурдасгаж, харилцагчдыг зайнаас цахим сувгууд ашиглан банкны үйлчилгээ авах хэрэгтэй болгосон гэж хэлэхэд буруутахгүй. Харилцагчид хэдий чинээ цахим бүтээгдэхүүн, үйлчилгээг ашиглаж эхэлнэ, банк болон технологийн компаниудыг улам эрчилж, шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх, өөрсдийнхөө үйл ажиллагааны процессуудыг технологийн шинэчлэлтэй уялдуулж ажиллах шаардлагыг үүсгэж, хөшүүрэг нь болж өгдөг онцлогтой.

Технологи суурьтай иргэдийн банк

ХасБанк 2017 оноос цахим сувгууддаа идэвхтэй хөрөнгө оруулалт хийж ирсэн бөгөөд үүний үр дүнд манай мерчантын сүлжээ хоёр дахин нэмэгдлээ. Мерчантын сүлжээ тэлсэн нь төлбөр тооцооны хялбар шийдэл, нягтлан бодох бүртгэл, шуурхай зээл олголт зэрэг давуу талуудыг мерчантууддаа олгож байна. Нөгөө талдаа карт хэрэглэгчдэд картын гүйлгээний үнийн дүнгийн тодорхой хувийг буцаан авах зэрэг төрөл бүрийн картын урамшуулал, давуу талыг эдлэх өргөн сүлжээ бий болж байна. Мөн АТМ-н сүлжээ 2.5 дахин нэмэгдэж харилцагчид өөрт ойр байрлах АТМ болон Экспресс банкны үйлчилгээг орон даяар авч байна. Бидний түүх энгийн. Бид үйлчлүүлэгчтэйгээ хамт өсөж хөгждөг. 2017 оноос хойш интернэт банк хэрэглэгч 170 хувь, карт эзэмшигч 181 хувь тус тус өссөн бөгөөд ХасБанкны карттай харилцагч нартаа ХасБанкны АТМ-н бүх үйлчилгээ, интернэт банкаар банк дотроо шилжүүлэг хийхэд авдаг шимтгэлийг тэглэсэн бөгөөд өнөөдрийн байдлаар 1.9 тэрбум төгрөгийг харилцагч нартаа хэмнэж өгсөн. Өнгөрсөн жилээс бид IT-н дэд бүтцээ сайжруулахаар хөрөнгө оруулалтыг ихээр хийсэн бөгөөд системийн түвшинд хамтын ажиллагаа маань илүү хялбар болж бизнесийн хүрээнд хамтрагч байгууллагатай хамтран шинэлэг зүйлсийг хийсээр байна.

Цахим шилжилт үргэлжилсээр...


Цахим шилжилтийн гол зорилго нь бизнесийн үр ашгийг нэмэгдүүлэх, үйл ажиллагаа явуулахад хялбар байх юм. Жишээ нь бид BPMS (business process management system)-г нэвтрүүлснээр салбарын өдөр тутмын үйл ажиллагаа илүү хурдан болж харилцагч нарт таатай болсон. Банкны үйл ажиллагаа хурдан явагдахад ашиг тусыг хамгийн их хүртдэг нь манай харилцагч нар юм. Энэхүү өөрчлөлтүүд мөн цахим сувгуудад ч хамааралтай, байнгын өөрчлөгдөж байдаг технологийн шинэчлэлд тулгуурласан банк санхүүгийн салбарт хийгдэх ажлууд их байгаа бөгөөд бид цахим стратегиа тодорхойлсноор алхам тутамдаа цахим зорилтдоо ойртож байна. ХасБанкны цахим стратеги бол үндсэн бизнестээ төвлөрсөн хялбар банк байх юм, харилцагчид хүргэх бүтээгдэхүүн үйлчилгээг хялбар, ойлгомжтой байлгах үүднээс технологийн шинэлэг шийдлийг санал болгох урт хугацааны бие биедээ ашигтай байх хамтын ажиллагааг нэвтрүүлсээр ирлээ.

Шинэ түвшинд дижитал болох нь

Цар тахлын улмаас бэлэн мөнгөөр өдөр тутмын төлбөр тооцоогоо хийдэг харилцагч нарт хэцүү байдал үүссэн хэдий ч харилцагчид маань цахим сувгуудыг амжилттай ашиглаж байна. 2020 онд манай харилцагчдын цахим сувгууд болон картын хэрэглээ шинэ түвшинд хүрч цахим банк болон картын гүйлгээ тус бүр 143 хувь болон 120 хувь болон нэмэгдсэн. 2019 онтой харьцуулахад гурван харилцагчийн нэг нь цахим сувгийг идэвхтэй ашиглаж байна. Жилийн турш үргэлжилсэн хөл хорионы улмаас зарим харилцагч нар маань банкны салбарт биечлэн ирж үйлчилгээ авах боломжгүй болсон ч засгийн газраас олгодог хүүхдийн мөнгө авдаг хүүхэдтэй гэр бүл болон өндөр настнууд зайнаас банкны үйлчилгээ авах бүх боломжийг бүрдүүлж өглөө. Бид эдгээр харилцагч нартаа эхний жилийн хураамжгүй дебит картыг олголоо. Бид 2021 он болон ирж буй жилүүдэд харилцагч нартайгаа хамт хөгжин өссөөр байх болно.

Дотроо ч, гаднаа ч хамгийн шилдэг нь болохын төлөө

Бид бусадтай хамтран төлбөр тооцооны нээлттэй эко-системийг хөгжүүлэх хэрэгтэй гэдгээ ойлгон сүүлийн үеийн финтек үйлчилгээний нэг болох цахим түрийвч/QPay 2.0-тай хамтран ажиллаж байгаадаа баяртай байна. Энэхүү үйлчилгээ нь Ковид-19 цар тахлын үед мерчант болон харилцагч нарт зайнаас буюу биет картыг гар дамжуулалгүйгээр төлбөр тооцоо хийх боломжийг олгож байна. 2020 оны сүүлээс бид Андройд ПОС-г мерчантын сүлжээндээ нэвтрүүлсэн Монголын анхны банк болсон. Андройд ПОС нь мерчантын кассын системтэй холбогдож төлбөр тооцооны шинэлэг боломжуудыг нээж өгч байна. Бидний зорилго бол өөрсдийн харилцагч нартаа дэлхийн төвшний цахим банкны үйлчилгээг үзүүлэх юм. Энэ хэдий хялбар биш ч бид шилдгийг эрэлхийлсээр байна. Банкны хувьд бид ашиглахад хялбар, аюулгүй цахим банкны үйлчилгээг нэвтрүүлэхийн тулд үйлчлүүлэгчдэд хэрэглэхэд хялбар шинэлэг back-end технологид хөрөнгө оруулсаар байна. 2021 онд дараагийн үеийн цахим банкны платформ болох шинэлэг цахим банкны аппликэйшнээ нэвтрүүлэх гэж байгаадаа баяртай байна.



Бизнес Банк

Өгөөж гурил ХХК

Өгөөж гурил ХХК зах зээлийн хүнсний хэрэгцээг эрүүл чанартай гурилаар ханган ажиллаж буй, бизнесийн амжилтаараа манлайлагч ХасБанкны харилцагчдын нэг юм. ХасБанк нь Өгөөж гурил ХХК-тай хамтын ажиллагааг 2006 онд эхлүүлсэн цагаас хойш хөрөнгө оруулалт, эргэлтийн хөрөнгийн зээл болон худалдааны санхүүжилтийн үйлчилгээг үзүүлэхийн зэрэгцээ гадаад дотоод төлбөр тооцоо, ажиллагсдын багц үйлчилгээ зэрэг санхүүгийн цогц үйлчилгээг харилцагчийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн хүргэж байна.

Тус үйлдвэр нь 2018 онд Турк улсад үйлдвэрлэсэн Европ стандартад нийцсэн бүрэн автомат удирдлагын системтэй орчин үеийн дэвшилтэт технологитой гурилын үйлдвэрийг ХасБанкны гадаад худалдааны санхүүжилтээр оруулж ирж ашиглалтад оруулсанаар технологийн шинэчлэлтийг амжилттай хийсэн билээ. Үйлдвэрийн тоног төхөөрөмжийг бүрэн шинэчилснээр үйлдвэрлэлийн хэмжээ 2 дахин өсөж, компанийн ашгийн түвшин 2.3 дахин нэмэгдсэн байна. Өгөөж гурил ХХК нь жилд дунджаар 40,000 тонн үр тариа хүлээн авч боловсруулан Буудайн гурил техникийн ерөнхий шаардлагын дагуу дээд, нэг, хоёрдугаар гурил болон хүнсний хивэг, хүүхдийн будаа, малын тэжээл зэрэг бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлэж хүн амын хүнсний хэрэгцээнд эрүүл, чанартай экологийн цэвэр бүтээгдэхүүн нийлүүлэн ажилладаг.

Бизнесийн банк нь сорилтоор дүүрэн боловч амжилттай жилийг үдлээ. Дэлхий дахинаа нүүрлэсэн Ковид-19 цар тахлын тодорхойгүй нөхцлийн үед манай чадварлаг корпорейт банкирууд харилцагчдадаа тулгарч буй санхүүгийн хүндрэлийг хохирол багатай даван туулахад дэмжлэг үзүүлж тэдний эрэлт хэрэгцээнд нийцсэн санхүүгийн уян хатан үйлчилгээг үзүүлэн ажиллалаа. Банкны зүгээс тодорхойгүй нөхцөлд бизнесээ удирдан ажиллаж буй харилцагчдынхаа аливаа хүсэлтэд шуурхай хариу арга хэмжээ авч ажиллахыг гол зорилгоо болгов.

➤ Бидний 2020 оны онцлох ажлууд:

- Санхүүгийн үйлчилгээг чанарын өндөр түвшинд хүргэж ажиллах нь Бизнесийн банкны эрхэм зорилго байдаг билээ. Энэ ч утгаараа бид шинэ харилцагч татаж зах зээлд эзлэх хувиа нэмэгдүүлэхээс илүүтэйгээр өөрсдийн харилцагчиддаа гол анхаарлаа хандуулж тэдэнд төвлөрөв. Цар тахлын үеийн эдийн засгийн хүндрэл бэрхшээлийг даван туулахад харилцагчдын зээлийн бүтцийг өөрчлөх, нэмэлт эргэлтийн хөрөнгийн зээл олгох зэргээр хамтран ажилласан нь үр дүнтэй арга хэмжээ байв. Бид 2020 оны эхэнд корпорейт зээлийн багцын талаас илүү хувьд бүтцийн өөрчлөлт хийх төсөөлөлтэй байсан хэдий ч он дуусахад багцын 25-аас доош хувьд бүтцийн өөрчлөлт хийгдсэн байна.
- Бизнес банк нь эдийн засгийн таагүй нөхцөл байдалд үүсэх эрсдлээс харилцагчдаа урьдчилан сэргийлэх үүднээс багцын оновчтой удирдлагын стратегийг 2019 оноос эхлэн хэрэгжүүлж байна. Энэхүү стратегийн хүрээнд зээлийн багцыг цөөн тооны томоохон зээлдэгчдээс бүрдүүлэхээс татгалзаж илүү олон тооны дундаж хэмжээний зээлдэгчээр бүрдүүлэхийг зорьсон бөгөөд тус зорилтын хүрээнд 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгөд эзлэх ТОП 40 зээлдэгчийн төвлөрлийг 220 хувиас 153 хувь болгож бууруулав.
- Харилцагч байгууллагуудтайгаа нягт уялдаа холбоотой хамтран ажилласны үр дүнд Бизнесийн банкны харилцах дансны үлдэгдэл өмнөх оноос 25 хувиар өссөн нь цар тахлын санхүүгийн хүндрэлийн үед томоохон амжилт болж чадлаа. E-gateway, cash pooling гэх мэт дансны удирдлагын хэрэгсэлүүд нь ХасБанкны харилцагчдад дансаа үр дүнтэй бөгөөд хялбар удирдах боломжоор хангаж чадлаа.
- Арилжааны банкны үйл ажиллагааныхаа хүрээнд ХасБанк харилцагчдынхаа өмнөөс аккредитив, баталгаа гаргаж тэдний зээлийн түвшинг дээшлүүлэх зорилгоор ажилладаг. Манай хувьцаа эзэмшигчдийн өвөрмөц бүтэц, ил тод байдал нь олон улсын санхүүгийн байгууллагуудын худалдааны санхүүжилтийн шугамыг ашиглах боломж олгодог бөгөөд үүний үр дүнд дотооддоо худалдааны санхүүжилтийн гол тоглогчийн байр сууриа хадгалж чаддаг. Эдийн засагт тохиолдож буй цар тахлын хор уршигтай үр дагаврыг үл харгалзан ХасБанк худалдааны санхүүжилтийн бизнесээс олсон шимтгэлийн орлогыг өмнөх оны 3.2 тэрбум төгрөгтэй харьцуулахад 2020 онд 3.4 тэрбум төгрөгт хүргэж өсгөв. Манай худалдааны санхүүжилтийн баг 2020 онд нийт 92.5 тэрбум төгрөгийн 5,705 ширхэг аккредитив, баталгааг боловсруулсан.
- ХасБанк нь Оюу Толгой ХХК-ийн ханган нийлүүлэгчдэд авлагын санхүүжилтийн үйлчилгээг санал болгодог. Оюутолгойгоос авах авлагаа барьцаалснаар харилцагчид хамгийн бага бичиг баримт бүрдүүлэн бага хүүтэй, хурдан санхүүжилт авах боломжтой. ХасБанк 2020 онд 20 орчим үйлчлүүлэгчид 30 тэрбум гаруй төгрөгийн авлагын санхүүжилт олгожээ. ОТ ХХК-ийн газар доорхи 2-р шатны төсөл урагшилж эхэлмэгц энэ тоо нэмэгдэх хандлагатай байгаа.
- ХасБанк нь олон улсын хөгжлийн байгууллагуудтай хамтран капиталын зардлын зорилгоор үйлчлүүлэгчиддээ синдикатын зээлийг хямд үнээр олгодог. Эдгээр зээлүүд нь дотоодын компаниудын хөрөнгө оруулалтын зардлын хэрэгцээг хангахын хажуугаар ХасБанкинд зохицуулах хөрөнгийн хөнгөлөлт үзүүлэх боломжийг олгодог. Энэ хүрээнд олгосон 25 сая гаруй ам.долларын зээлүүд харилцагчдынхаа үйл ажиллагааг өргөжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан.

Байгаль орчны хариуцлага

Тогтвортой шийдлүүдийг нэвтрүүлэх нь

Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилгоор ХасБанк нь төсөл хөтөлбөр болон зээлийн бүтээгдэхүүнээр дамжуулан бодит шийдлүүдийг нэвтрүүлж ажиллаж байна. Бидний хэрэгжүүлж буй үйл ажиллагаанууд нь олон улсад тулгамдаж буй асуудлуудыг тогтвортой хөгжил бий болгох замаар шийдэх Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тогтвортой Хөгжлийн Зорилготой (ТХЗ) нийцэж байгаа юм.


ТХЗ	ХасБанкны үйл ажиллагаа	ТХЗ	ХасБанкны үйл ажиллагаа
1 Ядуурлыг устгах: 	Ядуурлыг устгах: ХасБанкны төсөл, хөтөлбөрүүдийн хүрээнд хэрэгжүүлж буй хөнгөлөлттэй эко зээл, хүүгийн татаастай эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн нь эцсийн хэрэглэгчдэд боломж болон хүртээмжийг нэмэгдүүлдэг.	6 Инноваци болон дэд бүтцийг нэмэгдүүлэх: 	Инноваци болон дэд бүтцийг нэмэгдүүлэх: ХасБанк нь том хэмжээний нарны цахилгаан станцыг бүрэн санхүүжүүлсэн Монголын анхны арилжааны банк болсон.
2 Эрүүл мэндийг дэмжих: 	Эрүүл мэндийг дэмжих: Эрчим хүчний хэмнэлттэй (ЭХХ) бүтээгдэхүүн борлуулах хөтөлбөрийн хүрээнд 173,852 ЭХХ-тэй бүтээгдэхүүнийг 150,489 өрхөд борлуулж нүүрсхүчлийн хий болон агаарын бохирдлыг бодитоор бууруулсан.	7 Тэгш бус байдлыг бууруулах: 	Тэгш бус байдлыг бууруулах: Мерси Кор Олон Улсын байгууллагатай хамтран туршилтын журмаар хэрэгжүүлсэн Ногоон бэлчээрийн төсөл нь Монголын бэлчээрийн доройтолтой газар нутгийн малчдад уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах зорилготой юм.
3 Жендэрийн эрх, тэгш байдлыг хангах: 	Жендэрийн эрх, тэгш байдлыг хангах: Уур Амьсгалын Ногоон Сантай хамтран хэрэгжүүлж буй Хүлэмжийн хийг бууруулах бизнес зээлийн хөтөлбөрийн 50-иас доошгүй хувь нь эмэгтэй бизнес эрхлэгчдэд чиглэсэн байдаг. Тус тоо 2018 оны байдлаар 77.9% -д хүрсэн..	8 Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих: 	Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих: ХасБанкны Эко автомашины зээлийн хөтөлбөр нь утаа бага ялгаруулдаг 1,067 тээврийн хэрэгслийн худалдан авалтын санхүүжилтыг олгосон бол бизнесийн зээл нь агаарын бохирдлыг бууруулсан байна.
4 Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах: 	Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах: ХасБанкны хамтран санхүүжүүлсэн 10 МВт-ын хүчин чадалтай Нарны цахилгаан станц нь 25 жилийн ашиглалтын хугацаанд ойролцоогоор 4.3 тэрбум литр усыг хэмнэнэ.	9 Хариуцлагатай эргэлзэг дэмжих: 	Хариуцлагатай хэрэглээг дэмжих: Уур амьсгалын Ногоон сантай хамтран хэрэгжүүлж буй зээлийн хөтөлбөрүүд нь бизнес болон өрхийн байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг эрчим хүчний хэмнэлттэй худалдан авалтаар бууруулах боломжийг олгож байна.
5 Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх: 	Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх: ХасБанкны хамтран санхүүжүүлсэн 10 МВт-ын хүчин чадалтай нарны цахилгаан станц нь 15,395 мВт/жил бага нүүрстөрөгч бүхий эрчим хүчийг Төвийн Бүсийн Эрчим Хүчний Системд нийлүүлж байна.	10 Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах: 	Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах: Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах Үндэсний хүлээсэн үүрэг болон Ногоон Хөгжлийн бодлогын хүрээнд хүлэмжийн хийг бууруулж байна.

Нийгэм болон хамтрагч байгууллагуудын байгаль орчны тогтвортой байдлыг хангахад чиглүүлэх

Бид байгууллагын нийгмийн хариуцлага болон урт хугацааны тогтвортой хөгжлийг үндэс болгон Нийгэм болон Байгаль Орчны Бодлогыг боловсруулан мөрдөн ажиллаж байна.

ХасБанк нь тогтвортой хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэгч байгууллагын хувьд банкны үйл ажиллагааны экологи болон нийгэмд үзүүлэх нөлөөг хянах зорилгоор 2002 оноос эхлэн ISO 14001 стандартын дагуу Байгаль Орчин Нийгмийн Хариуцлагын Эрсдэлийн Үнэлгээг (БОНХЭҮ) нэвтрүүлсэн билээ. ХасБанкны нийт ажилчид БОНХЭҮ-ний талаар сургалтад хамрагдаж, зээл олголт, худалдан авалт зэрэг банкны үйл ажиллагаанд хэрэгжүүлж ажиллаж байгаа ба тус үнэлгээг 2008, 2011, 2014, 2018 онуудад шинэчилсэн болно.

Бид улс орон даяар хэрэгжүүлж буй үйл ажиллагаанаас нийгэм, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн мэдээллийг системтэйгээр цуглуулж, стратегийн хувьцаа эзэмшигчид болон хөрөнгө оруулагчдад байгаль орчин, нийгмийн тайланг тогтмол гарган өгдөг. Бид эрчим хүч, түлш, усыг үр ашигтай ашиглах, цаасны хэрэглээ болон хог хаягдлыг багасгах зэрэг байгаль орчноо хамгаалах арга хэмжээнүүдийг санаачлан хэрэгжүүлж байна.



ХасБанк нь Монгол улсын тогтвортой санхүүжилтийн тэргүүлэгч санхүүгийн байгууллагын хувьд уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах чиглэлээр цаашид үргэлжлүүлэн санхүүжилт олгон ажиллана.

Эко Банк

Эко Харилцагч

Маймон Соорс ХХК
| LEED сертификат бүхий Ногоон Барилга

ХасБанкны Хүлэмжийн хийг бууруулах бизнесийн зээлийн хөтөлбөрийн санхүүжилттэй баригдаж буй “Маймон Соорс” ХХК-ний оффисын барилга нь Монголд анх удаа ОУ-ын ногоон барилгын LEED сертификат авахаар барилга угсралтын ажлаа энэхүү стандартын дагуу гүйцэтгэж байна. LEED /Leadership in Energy and Environmental Design/ бол дэлхийд хамгийн өргөн ашиглагддаг ногоон барилгын үнэлгээний систем билээ. Энэхүү сертификат нь дэлхийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн тогтвортой хөгжлийн бэлэг тэмдэг юм.

“Маймон Соорс” Оффисын Барилгын Төсөл нь нийт 4,800 метр квадрат талбайтай Оффис, Агуулах, Засварын Төв бүхий холимог ашиглалтын зориулалттай барилга төдийгүй 200кВт-ын хүчин чадал бүхий дээврийн нарны эрчим хүчний систем суурилуулсан бөгөөд ингэснээр жилд 720,000 кВтц эрчим хүч хэмнэж, хүлэмжийн хийн ялгарлыг 403,200 тонноор бууруулна. Мөн түүнчлэн борооны ус хадгалах систем суурилуулж байгаа бөгөөд ингэснээр жилд 400 тонн усыг хэмнэх ногоон барилгын төсөл юм.

Эко Банк

Эко банкны санаачилга

ХасБанкны Эко банкны хэлтэс нь тогтвортой санхүүжилт хийх, бизнесийн үйл ажиллагааны эрчим хүчний хэмнэлтийг тооцох, хүлэмжийн хийн ялгарлын суурь үзүүлэлтийг тогтоох чиглэлээр мэргэшин ажиллаж буй Монгол улсын банкны систем дэх цорын ганц банкны нэгж юм.

Эко банкны хэлтэс нь 2009 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, Карбоны санхүүжилт, Тогтвортой эрчим хүчний санхүүжилт хийх гэсэн үндсэн гурван чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх

ХасБанкны төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь Ногоон зээлийн хөтөлбөрүүдийн үр нөлөөг өргөжүүлэх, өмнөх хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хянах зорилгоор чадавх бэхжүүлэх, зээлийн хөтөлбөрийг олон нийтэд таниулан сурталчлах үйл ажиллагаануудад чиглэсэн байдаг.

2020 онд ХасБанкны Уур Амьсгалын Ногоон Сантай хамтран хэрэгжүүлж буй Хүлэмжийн хийг бууруулах бизнесийн зээлийн хөтөлбөрийн дөрөв дэх жил тохиож байна. Хөтөлбөрийн хүрээнд ХасБанкны харилцагч жижиг дунд бизнес эрхлэгч нарт зориулан санхүүгийн болон эрчим хүчний хэмнэлтийн чиглэлээр чадавх бэхжүүлэх сургалтууд, зээлийн мэргэжилтнүүдэд зориулан ногоон зээлийг тодорхойлох талаар сургалтууд, мөн ногоон зээлийг тодорхойлох ажлыг хялбарчлах зорилгоор эрчим хүчний хэмнэлттэй технологийн жагсаалт боловсруулах, Бизнес эрхлэгч нарт зориулан жил бүр Ногоон санхүүжилтийн форумыг уламжлал болгон зохион байгуулдаг боловч КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах зорилгоор улсын хэмжээнд хэрэгжүүлсэн гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт үе шаттайгаар шилжсэнээр олон нийтийг хамарсан арга хэмжээ болох Ногоон санхүүжилтын форум болон харилцагч нарт зориулсан төлөвлөгөөт сургалтууд цуцлагдсан юм.

Мөн Уур амьсгалын Ногоон сантай хамтран Эрчим хүчний хэмнэлттэй хэрэглээний зээлийн хөтөлбөр (EECLP) -ийн эхний жилийг амжилттай дуусгаад байна. Төслийн хүрээнд ХасБанк нь Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яамтай цэвэр халаалтын шийдэл, байшин сууцын дулаалгын хэрэглээний зээлийг хүүгийн татаасаар дэмжин ажиллах гэрээг байгуулсан юм. Түүнчлэн, халаагуурын зээлд хамрагдсан иргэдийн хуучин зуухыг хураан авч устгалд оруулах ажлыг зохион байгуулах; хэрэглээний зээлийн талаар 630 гаруй хэсгийн ахлагч нарт мэдлэг, мэдээлэл хуваалцах бага хурал, зээлийн мэргэжилтнүүдэд зориулан эрчим хүчний хэмнэлттэй хэрэглээний зээлийн олголтын явц, өрхийн түвшинд эрчим хүчний хэмнэлтийн ашиг тусын талаарх сургалтуудыг зохион байгуулж ажиллалаа.

ХасБанк нь Монголын Тогтвортой Санхүүжилт Холбоотой хамтран эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны урьдчилгаа төлбөрийн 30 хүртэл хувийг буцалтгүй тусламж хэлбэрээр зээлдэгч нарт олгох хөнгөлөлттэй амины орон сууцны зээлийн хөтөлбөрийг туршилтаар хэрэгжүүлсэн.

Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх хүрээнд хийгдсэн онцлох ажлууд

- **2010-2015:** Эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн борлуулах хөтөлбөрийг хэрэгжүүлснээр гэр хорооллын өрхийн 80 орчим хувьд ХасБанкны бүтээгдэхүүн борлуулалтын цэгээр дамжуулан эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүнүүдийг татаастай үнээр борлуулсан.
- **2017-2020:** Хүлэмжийн хийг бууруулах бизнесийн зээлийн хөтөлбөрийн хүрээнд чадавх бэхжүүлэх, хөтөлбөрийг олон нийтэд таниулах арга хэмжээнүүдийг үргэлжлүүлэн зохион байгуулав. 2020 онд 222 салбарын ажилтнуудыг сургалтад хамруулаад байна.
- **2018:** ХасБанк нь Уур амьсгалын ногоон сангийн Үндэсний хэрэгжүүлэгч байгууллагын чадавх бэхжүүлэх хөтөлбөрийн гүйцэтгэгчээр ажилласан бөгөөд энэ хүрээнд нийт 18 сургалт, семинарыг амжилттай зохион байгуулж, хөтөлбөрт оролцогч талуудаас 782 хүнийг хамруулсан байна. Ингэснээр

- Уур амьсгалын ногоон сангийн Үндэсний хөтөлбөрийн талаарх ойлголт оролцогч талуудын дунд нэмэгдэж, Үндэсний хөтөлбөрийг нийтээр хүлээн зөвшөөрөхөд чухал нөлөө үзүүлсэн билээ.
- **2019:** 10МВт-ын хүчин чадалтай Сүмбэр нарны цахилгаан станцын барилга угсралтын ажил дуусаж, 2019 оны 3 дугаар сараас эхлэн цахилгаан эрчим хүчний нэгдсэн сүлжээнд эрчим хүч нийлүүлж эхлэв.
- **2019:** Эрчим хүчний хэмнэлттэй хэрэглээний зээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд энэ хүрээнд уг хөтөлбөрийг олон нийтэд сурталчлан таниулах ажлыг эхлүүлээд байна. Ногоон санхүүжилтийн гуравдугаар чуулганыг зохион байгуулснаас гадна Сэргээгдэх эрчим хүчний 10-р форумыг ивээн тэтгэж, ХасБанкны дотоод ажилчдын чадавхыг бэхжүүлэх ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулав.

ХасБанк нь Монгол улсын тогтвортой санхүүжилтийн тэргүүлэгч санхүүгийн байгууллагын хувьд уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах чиглэлээр цаашид үргэлжлүүлэн санхүүжилт олгон ажиллана.

- **2019:** Монголын Ногоон Санхүүгийн Корпораци (MGFC) байгуулахад дэмжлэг үзүүлэх Төслийг батлуулж, мөн онд хийж гүйцэтгэв. Төслийн хэрэгжилтийн явцад хамтран оролцогчид болох Монгол Улсын Засгийн газар болон тэргүүлэгч банкуудтай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан.
- **2019-2020:** Гэр хорооллын бүсэд хэрэгжих “Мини Гридд/Офф Грид-Халаалтын бие даасан шийдэл” төсөл нь 2019 онд Уур Амьсгалын Ногоон Сангийн төсөл хөгжүүлэх санхүүжилтэд хамрагдан хэрэгжиж

эхэлсэн. Уг төслийн зорилго нь гэр хорооллын айл өрхийн хэрэгцээнд нийцсэн, Монголдоо анхдагч бизнес загварыг боловсруулах явдал юм. 2020 онд дэлхий дахинд дэгдээд байгаа КОВИД-19 цар тахал нь төслийн хэрэгжилтийн хугацааг хойшлуулахад нөлөөлсөн.

- **2020:** Эрчим хүчний хэмнэлттэй хэрэглээний зээлийн хөтөлбөрийн хүрээнд Байгаль Орчин, Аялал Жуучлалын Яамтай гэрээ байгуулж харилцагчдад зээлийн таатай нөхцөлийг бүрдүүлсэн.

- **2020:** Нийслэлийн захиргаатай хамтран эрчим хүчний хэмнэлттэй хэрэглээний зээлийн талаарх мэдээллийг олон нийтэд таниулан сурталчлах зорилгоор 640 орчим хэсгийн ахлагч нарт өдөрлөг зохион байгуулав.
- **2020:** Монголын Тогтвортой Санхүүжилт Холбоотой хамтран эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны зээлийн туршилтыг амжилттай хэрэгжүүлсэн.

Карбоны санхүүжилт

2020 онд Эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн борлуулах хөтөлбөрийн хүрээнд айл өрхүүд авсан бүтээгдэхүүнээ хэрэглэж байгаа эсэхэд хяналт тавих судалгааны сүүлийн шатны аудит хийгдсэнээр хяналтын ажил дуусгавар болсон. 2016 онд хэрэгжиж эхэлсэн хяналт тавих судалгааны ажил нь “МикроЭнержи Кредитс” компанитай хамтран карбон кредитийг НҮБ-ын Цэвэр хөгжлийн механизм болон Карбоны сайн дурын зах зээлд бүртгүүлэн карбоны нөхөн олговор хүлээн авах боломжийг бүрдүүлсэн. Нэгж карбон кредит гэдэг нь нэг тонн нүүрстөрөгчийн ялгарлын бууралт гэсэн үг юм.

Карбон кредитийг байгууллагын нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэх гэж буй корпорациуд болон нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулах зорилтдоо хүрэхээр зорьж буй улс орнуудад зарж борлуулах боломжтой байдаг. ХасБанкны карбон кредитийн голлох худалдан авагч нь Шведийн Засгийн газар, Микрософт корпораци нар юм.

Карбоны санхүүжилтийн хүрээнд хийгдсэн онцох ажлууд

- **2009:** Карбоны нөхөн төлбөрийг авч эхлэх зорилгоор МикроЭнержи компанитай хамтын ажиллагааны гэрээ байгуулав.
- **2011:** Төслийн хүрээнд бий болсон карбон кредитийг Нүүрстөрөгчийн сайн дурын зах зээлд бүртгүүлснээр анхны карбоны нөхөн төлбөр хүлээн авав.
- **2013:** Цэвэр хөгжлийн механизмд Эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн борлуулах төслүүдээ бүртгүүлснээр карбон кредитээ борлуулах боломж бүрдлээ.
- **2015:** ЭХХ-тэй бүтээгдэхүүн борлуулах төслийн үр дүнд бий болсон карбон кредитээ Шведийн Засгийн газарт худалдах гэрээ байгуулав.
- **2016-2019:** Төслүүдийн үр дүнд бий болсон карбон кредитийг Цэвэр хөгжлийн механизмд 2016 онд бүртгүүлснээс хойш нийт 350,000 карбон кредитийг бүртгүүлээд байна.
- **2020:** Хяналтын сүүлийн шатны аудитыг амжилттай хийж гүйцэтгэсэн.

Тогтвортой Санхүүжилт

ХасБанк нь 2009 онд ЭкоБанкны хэлтсийг байгуулж, тогтвортой санхүүжилтийн үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн ба олон улсын байгууллагуудтай идэвхтэй хамтран ажилласны үр дүнд бизнес эрхлэгчид болон иргэдэд эрчим хүчний хэмнэлттэй, сэргээгдэх эрчим хүчний технологиудыг санхүүжүүлэх хөнгөлөлттэй зээл олгож ирсэн.

2019 оны хувьд Хүлэмжийн Хийг Бууруулах Бизнесийн Зээлийн хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, 2019 оны 9-р сараас эхлэн Эрчим Хүчний Хэмнэлттэй Хэрэглээний Зээлийн Хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлээд байна.

Эрчим Хүчний Хэмнэлттэй Хэрэглээний Зээлийн Хөтөлбөрийн зорилго нь иргэдийн цахилгаан халаагуур, байшингийн дулаалга зэрэг эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүнүүдийн хэрэглээг нэмэгдүүлэх юм. Тус хөтөлбөр нь өрхийн түвшинд ногоон технологийн сонголтыг нэмэгдүүлэх ач холбогдолтой учраас ард иргэдэд ногоон технологийн хэрэглээний талаарх мэдээлэл түгээн ажиллаж байна.

Эко Банк

➤Тогтвортой санхүүжилтийн хүрээнд хийгдсэн онцлох ажлууд:

- 2009: Нидерландын Хөгжлийн Банкны (FMO) 6.5 тэрбумын төгрөгийн хөнгөлөлттэй зээлээр дамжуулан 1,778 айл өрхөд Эрчим Хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүнүүдийг хэрэглээний зээлээр олгосон.
- 2012-2020: Бизнес эрхлэгчдэд зориулсан Эко зээл олгогдож эхэлснээр бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид, борлуулагчид, хэрэглэгчид эрчим хүчний хэмнэлттэй болон сэргээгдэх эрчим хүчний бүтээгдэхүүнийг хөнгөлөлттэй зээлээр дамжуулан худалдан авах боломж бүрдсэн.
 - 2012 онд Даян Дэлхийн Уур Амьсгалын Хамтын Ажиллагааны Сангаас (GCPF) тогтвортой санхүүжилтийг дэмжих зорилгоор 20 сая ам.долларын эх үүсвэр хүлээн авсан.
- Тогтвортой эрчим хүчний санхүүжилтийн цар хүрээг өргөжүүлэх зорилгоор 2013 онд Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкны Монголын Тогтвортой Эрчим Хүчний Санхүүжилт (МонСЭФФ)-ийн 10 сая ам долларын эх үүсвэр хүлээн авсан.
- 2017 онд Уур Амьсгалын Ногоон Сангаас Хүлэмжийн Хийг Бууруулах Бизнесийн Зээлийн хөтөлбөрийн хүрээнд 19.5 сая ам долларыг зээлийн зориулалтаар, 500,000 ам долларыг хөтөлбөр хөгжүүлэлтийн зориулалтаар тус тус хүлээн авсан.
- 2013 оноос эхлэн нийт 120.3 тэрбум төгрөгийг эрчим хүчний хэмнэлттэй шийдлүүдийг дэмжих зорилгоор бизнес эрхлэгчид, аж ахуйн нэгжүүдэд олгож, хүлэмжийн хийн ялгарлыг 1,460,479.25 тонноор бууруулсан.

➤Уур Амьсгалын Ногоон Сан

Уур Амьсгалын Ногоон Сан нь хүлэмжийн хийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенц (UNFCCC)-ийн хүрээнд байгуулагдсан сан билээ. ХасБанк нь Монгол Улс дахь Уур Амьсгалын Ногоон Сангийн (УАНС) цор ганц магадлан итгэмжлэгдсэн Үндэсний хэрэгжүүлэгч байгууллага юм.

Уур Амьсгалын Ногоон Сан нь ХасБанкны тогтвортой санхүүжилтийн зорилтын хүрээнд хамгийн том хамтрагч байгууллага бөгөөд 2019 оны хувьд Эрчим Хүчний хэмнэлттэй хэрэглээний зээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн нь УАНС-ийн Хялбарчилсан батлах загвараар төслийн саналаа батлуулсан анхны хувийн хэвшлийн магадлан итгэмжлэгдсэн үндэсний хэрэгжүүлэгч байгууллага болсон. Харин, Сүмбэр Нарны Цахилгаан станц нь 2019 оны 3-р сард Төвийн Бүсийн Эрчим Хүчний Системтэй холбогдсон нь УАНС-тай хамтран хэрэгжүүлсэн төслүүдээс амжилттай гүйцэтгэж дууссан эхний төсөл хөтөлбөр болсон юм.

2020 онд ХасБанкны дөрөв дахь төслийн санал болох FP153 “Монголын Ногоон Санхүүжилтийн Корпораци” (МНСК)-ийг Уур амьсгалын Ногоон сангийн Удирдах зөвлөлийн ээлжит хурлаар батлуулав. МНСК нь уур амьсгалын санхүүжилтийг дэмжих гол хөшүүрэг болох Монголын анхны ногоон санхүүгийн байгууллага бөгөөд Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого Алсын хараа 2050-д тусгагдсан “Байгальд ээлтэй ногоон төсөл, үйл ажиллагааг санхүүжүүлэх төр, хувийн хэвшлийн хамтарсан үндэсний ногоон санхүүгийн тогтолцоог байгуулж хөгжүүлэх” зорилтын хүрээнд үүсгэн байгуулагдах юм. Төслийн хэрэгжилтэд Монгол Улсын Засгийн газар, УАНС болон дотоодын арилжааны банкууд хамтран ажиллах бөгөөд энэхүү олон улсын байгууллага, засгийн газар, хувийн хэвшлийн 3 талт хамтын ажиллагаа нь Монгол улсын ногоон санхүүжилтын хөгжлийг дэмжих, чадавхыг бэхжүүлэх, эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой байна.

ХасБанк нь Монгол улсын тогтвортой санхүүжилтийн тэргүүлэгч санхүүгийн байгууллагын хувьд уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах чиглэлээр цаашид үргэлжлүүлэн санхүүжилт олгон ажиллана.

ХасБанк болон Уур Амьсгалын Ногоон Сангийн хамтын ажиллагааны хүрээнд онцлох үйл явдлууд:

- 2016: ХасБанк нь хөгжиж буй орнуудаас Уур Амьсгалын Ногоон Сангийн хамгийн анхны магадлан итгэмжлэгдсэн Үндэсний хэрэгжүүлэгч байгууллага болсон.
- 2016: FP 028: Уур Амьсгалын Ногоон Сангаас Хүлэмжийн Хийг Бууруулах Бизнесийн Зээлийн хөтөлбөр хэрэгжүүлэх зорилгоор 19.5 сая ам долларын зээлийн эх үүсвэр, хөтөлбөр хөгжүүлэлт, хэрэгжүүлэх зорилгоор 500,000 ам долларын санхүүжилт авах гэрээ байгуулсан.
- 2017: FP 028: Хүлэмжийн Хийг Бууруулах Бизнесийн Зээлийн хөтөлбөрийн санхүүжилтийн ХасБанк хүлээн авсан нь УАНС-аас төслийн саналыг бүрэн олгосон анхны тохиолдол боллоо.
- 2017: ХасБанкны хоёр дахь төслийн санал болох FP 046: Сэргээгдэх Эрчим Хүчний Хөтөлбөрийг УАНС баталж, 8.65 сая ам долларын санхүүжилт хийхээр болов. Уг төслийн хүрээнд ХасБанк нь том хэмжээний нарны цахилгаан станцыг бүрэн санхүүжүүлсэн анхны арилжааны банк болсон юм.
- 2018: ХасБанкны гурав дахь төслийн санал болох SAP004: Эрчим Хүчний Хэмнэлттэй Хэрэглээний Зээлийн хөтөлбөрийг УАНС баталж 9 сая ам долларын зээл, хөтөлбөр хөгжүүлэлтийн хүрээнд 1 сая ам долларын санхүүжилт хийхээр уг төслийг батлав. ХасБанк нь Хялбарчилсан батлах загвараар төслийн саналаа батлуулсан анхны хувийн хэвшлийн магадлан итгэмжлэгдсэн Үндэсний хэрэгжүүлэгч байгууллага болсон.
- 2018: Бэлэн байдлын дэмжлэгийн хөтөлбөрийн хүрээнд УАНС-ийн Үндэсний Эрх Бүхий Байгууллага болон Үндэсний зохицуулагчийн Уур Амьсгалын Ногоон сантай стратегийн чиглэлийн хүрээнд хамтын ажиллагааг хөгжүүлэх, мөн улсын хэмжээнд хэрэгжих хөтөлбөрүүдэд бэлтгэхэд түнш байгууллагаар ХасБанк шалгаран, амжилттай ажилласан билээ.
- 2019: Сүмбэр Нарны Цахилгаан станцын бүтээн байгуулалт 2019 онд бүрэн дуусаж, Төвийн Бүсийн Эрчим Хүчний Системтэй 2019 оны 3-р сард холбогдсон. Ашиглалтад орсон цагаас эхлэн нийт 13,714 MBT эрчим хүчийг ТБЭХС-д нийлүүлж, хүлэмжийн хийн ялгарлыг 11,945 тонноор бууруулсан. Нарны цахилгаан станц нь 20,000 гаруй өрхийг сэргээгдэх эрчим хүчээр хангах хүчин чадалтай бөгөөд 25 жилийн ашиглалтын хугацаанд жилд 171 сая литр ус хэмнэх юм.
- 2019: Уур Амьсгалын Ногоон Сантай хамтарсан Монголын Ногоон Санхүүжилтийн Корпорац (МНСК)-ийг байгуулахад дэмжлэг үзүүлэх төслийг амжилттай батлуулж 4 сарын хугацаанд хэрэгжүүлж дуусгав.
- 2019: Гэр хорооллын бүсэд хэрэгжих “Мини Гридд/Офф Грид- Халаалтын бие даасан шийдэл” төсөл нь Уур Амьсгалын Сангийн төсөл хөгжүүлэх санхүүжилтэд хамрагдав.
- 2020: Бэлэн байдлын дэмжлэгийн хөтөлбөрийн хүрээнд Монгол Улс: УАНС-тай уялдаа холбоо, хамтын ажиллагааг бэхжүүлж, улсын хэмжээнд хэрэгжих хөтөлбөрүүдийг Үндэсний зорилтот хувь нэмэр болон Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан шинэчлэхэд түнш байгууллагаар ХасБанк шалгарав.
- 2020: Бэлэн байдлын дэмжлэгийн хөтөлбөрийн хүрээнд Эрчим хүчний хэмнэлтийн даатгалын загвар боловсруулахад түнш байгууллагаар ХасБанк шалгарав.
- 2020: ХасБанкны дөрөв дахь төслийн санал болох FP 153: Монголын Ногоон Санхүүжилтийн Корпораци (МНСК)-ийн төслийг 5 сая ам долларын хувьцааны санхүүжилт, 20 сая ам долларын зээлийн эх үүсвэр, хөтөлбөр хөгжүүлэлт, хэрэгжүүлэх зорилгоор 2 сая ам долларын санхүүжилт хийхээр уг төслийг батлав.

➤Эко Банкны Стратегийн тэргүүлэх чиглэлүүд

Бид Эко Банкны стратегийн тэргүүлэх чиглэлүүдийг ирэх жилүүдэд дараах байдлаар тодорхойлно:

- Тэргүүлэгч: ХасБанкны эрхэм гурван зорилго “Эрдэнэт хүмүүн, Эх дэлхий, Эрүүл ашиг”-ын Эх дэлхий зорилгын хэрэгжүүлэгчдийн тэргүүлэгч болох.
- Манлайлагч: Нэгдсэн Үндэсний байгууллагын Уур Амьсгалын Ногоон Сан (УАНС)-гийн анхны магадлан итгэмжлэгдсэн үндэсний хэрэгжүүлэгч байгууллагын хувьд Монголын ногоон санхүүжилтийн манлайлагчаар ХасБанкийг стратегийн бодлогоор хүргэх.
- Нэгдэл: Ногоон санхүүжилтийг хэрэгжүүлэх үүднээс ХасБанкны одоогийн бүтээгдэхүүний нэмэлтээр бүтэц боловсруулах
- Өргөжин тэлэлт: Нарны цахилгаан станц, усны хэмнэлт зэрэг дэд бүтцийн томоохон төслүүдэд шинэ харилцагчдыг татах үүднээс урт хугацааны томоохон ногоон санхүүжилтийг бий болгох.
- Хамтын ажиллагаа: Нийгэм, байгаль орчинд ээлтэй хөрөнгө оруулалтын боломжийг бүрдүүлэх замаар Монголын Банкуудын Холбоог нэгтгэж Монголын Ногоон Санхүүгийн Корпораци төслийг хэрэгжүүлнэ. ТоС санаачилгын хүрээнд МБХ-г үргэлжлүүлэн тэргүүлэн ажиллана.

Цахимжуулалт

Цахимжуулах шийдлүүд

Технологийн хэвийн найдвартай ажиллагаа болон аюулгүй байдал

- Ковидын нөхцөл байдал үүссэн даруйд сүүлийн үеийн технологийн шийдлүүдийг шуурхай нэвтрүүлж нийт ажиллагсдаа зайнаас ажиллуулж эхэлсэн ба ТУЗ-ийн ээлжит, ээлжит бус хурлууд болон нийт ажиллагсдын тайлангийн хурал гэх мэт томоохон үйл ажиллагаа цахимаар амжилттай зохион байгууллаа.
- Ковидтой холбоотойгоор зохицуулагч байгууллагуудаас гаргасан шийдвэрийн дагуу харилцагчдын эзэлийн нөхцөл өөрчлөх хүсэлтийг онлайнаар хүлээн авах болон бусад автоматжуулах шийдлүүдийг хэрэгжүүллээ.
- Харилцагч карт ашиглалгүйгээр ХасБанкны ATM –ээс бэлэн мөнгө авах, гүйлгээ хийх боломж олгосон шинэ шийдлийг хөгжүүлж нэвтрүүллээ.
- Android POS төхөөрөмжийг нэвтрүүлж дотоод картын системүүдтэй холболтыг хийв. Ингэснээр картаар үйлчлэгч байгууллагууд хялбар Ибаримт хэвлэх, өөрийн бизнесийн онцлогт тохирсон урамшууллын хөтөлбөр явуулах мөн өөрийн байгууллагын бусад системтэй интеграц хийх гэх мэт илүү өргөн хүрээнд банктай хамтран ажиллах боломж нээгдэв.
- Qpay wallet аппликейшныг ККТТ компанитай хамтран нэвтрүүллээ. Ингэснээр харилцагч ХасБанкны UPI картаа Qpay wallet –д холбон олон улсын болон дотоодын бүх төрлийн гүйлгээг цахимаар хялбар хийх боломжтой болсон.
- Cloud шийдэл бүхий Chatbot –ийг банкны бүтээгдэхүүн үйлчилгээний мэдээллийг цахимаар түргэн шуурхай өгөх, харилцагчид үйлчлэх хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор нэвтрүүлж сошиал сувгууд дээрээ харилцагчийн үйлчилгээндээ ашиглаж эхлэв.
- Банкны нээлттэй API үйлчилгээндээ 10 орчим Fintech компаниудтай системийн түвшинд интеграци болон хөгжүүлэлтүүдийг хийж хамтран ажиллав.
- Thunes олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээнд банк хоорондын их дүнтэй буюу 3 саяас дээш гүйлгээ хийх боломжтой болгох шийдлийг нэвтрүүллээ.
- Цахилгаан түгээх компаниудтай хамтран харилцагч байгууллага болон хувь хүн цахилгааны төлбөрөө ХасБанкны цахим сувгийг ашиглан онлайнаар төлөх боломжийг нээв.
- Ажилтнуудын онлайн сургалтын дэмжих зорилгоор Talent LMS cloud системийг нэвтрүүллээ.
- Гадаад төлбөр тооцооны олон улсын SWIFT системийн аюулгүй байдлыг хангах Customer Security Program-н дагуу жилийн үнэлгээг хийн, SWIFT-д хүргүүлэв.
- Төлбөрийн картын аюулгүй байдлын PCI DSS v3.2.1 олон улсын стандартын шаардлагын дагуу Self-Assessment Questionnaire бөглөн стандартын хэрэгжилтийг амжилттай баталгаажуулав.
- Хамгаалалтын системүүдийн ажиллагаа хамрах цар хүрээг нэмэгдүүлж хамгаалалтыг системээр дамжин өнгөрөх мэдээллийн урсгалыг нэмэгдүүллээ.
- Вирусийн хамгаалалтыг шийдлийг шинэчилж чанарыг ахиулан зардал бууруулах санаачилга гарган амжилттай хэрэгжүүлсэн.
- Цахим шуудангийн хамгаалалтын шийдлийг бүрэн шинэчилж олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн тэргүүлэх зэргийн шийдлийг амжилттай нэвтрүүлэн цахим шуудангийн хамгаалалтын үйл ажиллагааг хөнгөвчлөн шинэ түвшинд гаргалаа.
- Мөн ХасБанк нь харилцагчдаа үзүүлж буй бүтээгдэхүүн үйлчилгээгээ өргөжүүлэх, цахим шилжилтийг дэмжих зорилгоор банкны үндсэн системээ шинэчлэх төслийг эхлүүлээд ажиллаж байна.

2020 оны Нийгмийн хариуцлагын ажлууд

Сайн үйлсийн хандив

Харилцагчдынхаа шинэ жилийн
бэлгийн төсвөө хүүхдийн
эрүүл мэндийн төлөөх 2 төсөлд
хандивлалаа.

100 сая ₮

- Зүрх мартахгүй төсөлд 50 сая
- ЭХЭМҮТ-ийн резидент эмч
нарын ажиллах, сурах орчинг
сайжруулах төсөлд 50 сая



Хасын Хүлэгүүд сагсан бөмбөгийн баг

Хасын хүлэгүүд багийг

**14 дэх
жилдээ**

дэмжиж байна. Хасын Хүлэгүүд
Үндэсний дээд лигийн дэд
байранд орсон.




Хүүхэд бүр уран бүтээлч

Хүүхдийн баярыг тохиолдуулан
“Хүүхэд бүр уран бүтээлч”
бүтээлийн уралдааныг

**5 дахь
жилдээ**

зохион байгууллаа.



Ковид-19-ийн эсрэг хамтдаа

Эмч, эмнэлэгийн байгууллагын
ажилтнууд болон онцгой
байдлын албан хаагчдад
шаардлагатай хувцас, багаж
хэрэгсэл, тоног төхөөрөмж зэрэг
бусад зүйлсийг авахад зориулж

60 сая

төгрөгийн хандив өглөө.



Питер Морроугийн нэрэмжит тэтгэлэг

Питер Морроугийн нэрэмжит
“Оюутны тэтгэлэгт хөтөлбөр”-ийг

**5 дахь
жилдээ**

зарлан, шилдэг оюутнуудаа
шалгаруулан тэтгэлэг олголоо.



АТМ, интернэт банкны үйлчилгээ

АТМ, интернэт банкаар
үйлчилгээ авдаг харилцагчдадаа

1.9 тэрбум

төгрөгийн шимтгэлийг
хэмнэж өглөө.



Сайн сайхан оршихуй

Ажилтнуудын дунд хэрэгжүүлдэг
“Сайн сайхан оршихуй”
хөтөлбөрийн хүрээнд ХасСир
уламжлалт спортын тэмцээн болон

Е-ХасСир

цахим спортын тэмцээнийг
зохион байгууллаа.



Хүний нөөц

Төв алба болон орон даяарх
79 салбар, тооцооны төвд
ажиллаж буй

1200

гаруй ажилтны ажлын байрыг
хадгалан, цалин хөлсийг
саадгүй олголоо.



Хүний нөөц

Жирэмсэн ажилтнуудад
цалинтай чөлөө олгож,

0-12

насны хүүхэдтэй
ажилтнуудаа гэрээсээ
ажиллах нөхцөл
боломжоор хангалаа.



Санхүүгийн үзүүлэлт

➤ Бизнесийн орчин

2019 онд эхэлсэн КОВИД-19 вирусийн халдвар нь 2020 онд дэлхий нийтийг хамарсан цар тахал болж, улс орнуудын эдийн засагт сөргөөр нөлөөлсөн. Цар тахал маш хурдацтайгаар газар аван тархаж байсан тул улс орнууд цар тахлыг хязгаарлах арга хэмжээнүүдийг урьтал болгон авч хэрэгжүүлж эхэлсэн нь эдийн засаг, санхүүгийн салбарыг өмнө нь хэзээ ч тохиолдож байгаагүй хүндрэл бэрхшээл, сорилтуудын өмнө авч ирсэн.

Дэлхийн бусад улс орнуудын нэгэн адил цар тахлын аюул, эдийн засгийн хүндрэл манай улсын өмнө ч тулгарсан. Уг хүндрэл бэрхшээлийг даван туулах, эдийн засгаа сэргээхээр Монгол Улсын Засгийн Газар, Монгол Банкнаас мөнгөний бодлогын хүүг үе шаттайгаар бууруулж, түүхэн доод түвшин болох 6 хувьд хүргэж, иргэд аж ахуй нэгжүүдийг татварын хөнгөлөлтөнд хамруулан, зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах зэргээр шат дараатай олон арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн. Гэсэн хэдий ч улс орнуудтай хийх гадаад худалдааны эрчим саарсан, мөн дотоодод удаа дараа тогтоосон хатуу хөл хорио нь эдийн засаг сэргэх үйл явцад сөргөөр нөлөөлсөн.

Эдийн засагт үүссэн хүндрэлийн улмаас арилжааны банкуудад активын чанараа сайжруулах, хөрвөх чадвараа нэмэгдүүлэх зэрэг асуудлууд тулгарсан. Цаашилбал, эдийн засгийг сэргээхэд голлох хөшүүрэг болохын хувьд арилжааны банкууд нэг талаас засгийн газраас хэрэгжүүлсэн гол гол зохицуулалтаас үүсэх санхүүгийн ачаа дарамтыг үүрэлцэх, нөгөө талаас банкныхаа харилцагчид, ажилтнууд болон хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах үүрэг хариуцлагаа тэнцвэртэйгээр биелүүлэх сорилттой ч тулгарсан.

Үүссэн нөхцөл байдалтай уялдуулан, ХасБанк үйл ажиллагааны болон санхүүгийн эрсдэлээ оновчтой үнэлж, уян хатан зохистой шийдлүүдийг авч хэрэгжүүлж чадлаа. Системийн ач холбогдол бүхий банкны хувьд, ХасБанк нь засгийн газраас хэрэгжүүлж буй эдийн засгийг дэмжих арга хэмжээнүүдэд идэвх чармайлттай түүчээлэн оролцохын зэрэгцээгээр банкныхаа санхүүгийн үзүүлэлтүүдээ тогтвортой хадгалж, улам бүр сайжруулан ажилласаар байна.

➤ Ашигт ажиллагаа

ХасБанк 2020 оны санхүүгийн жилд 29.8 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, өөрийн хөрөнгийн өгөөжийг 12.3%-д хадгалж ажиллалаа. Энэ нь өмнөх оны цэвэр ашиг 8.7 тэрбум төгрөг, өөрийн хөрөнгийн өгөөж 3.8%-тай харьцуулахад 3.4 дахин өссөн үзүүлэлт юм. Тайлант онд орлогын татвар болон зээлийн эрсдэлийн сангийн өмнөх ашиг 59.8 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 15.5 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь үйл ажиллагааны зардлын хэмнэлт, цэвэр хүүгийн орлогын өсөлтийн үр дүн байв.

Тайлант онд эдийн засгийн эргэлт удааширч зээлийн дундаж хүү, зээлийн багцын хэмжээ багассан хэдий ч бусад хөрөнгө оруулалтын багцаас олох орлогыг нэмэгдүүлснээр цэвэр хүүгийн орлого 15.6 хувиар нэмэгдэж, 99.6 тэрбум төгрөгт хүрлээ.

Эдийн засгийн орчин таатай бус байсан хэдий ч банк хүүгийн бус орлогууд болох хураамж шимтгэл, арилжааны болон нэмэлт үйлчилгээний орлогоо 24.6 тэрбум төгрөгт буюу өмнөх оны түвшинд хадгалан ажилласан нь банк үйл ажиллагаагаа цахимжуулж, дэвшилтэт технологи нэвтрүүлсэнтэй холбоотой. Тайлант онд зээлийн эрсдэлийн сангаас 1.4 тэрбум төгрөгийн зээл хааж, нийт зээлийн эрсдэлтэй холбоотой зардалд 21.1 тэрбум төгрөг зарцуулсан нь өмнөхтэй онтой харьцуулахад 30 хувиар буурсан үзүүлэлт байв. Чанаргүй зээл болон эрсдэлийн сангийн харьцаа сайжирч 89% -аас 104% болж нэмэгдсэн нь урьд өмнө нь байгаагүй өндөр үзүүлэлт юм.

2020 онд Банк зардлын төвүүдийнхээ үр ашгийг нэмэгдүүлэх бодлогоо үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн. Тайлант жилд бизнесийн орчин таатай бус байсан хэдий ч банк ажиллагсдынхаа цалин хангамжийг бүрэн олгож, үйл ажиллагааныхаа зардлыг 3.6%-иар бууруулсан. Үйл ажиллагааны зардлын хэмнэлт, ашгийн төвүүдийн үр ашигт байдал нэмэгдсэн нь үйл ажиллагааны зардал орлогын харьцаа 59.9%-с 51.6% болж сайжруулахад нөлөөлсөн.

+244.4%
29.8 тэрбум төг.

Цэвэр ашиг
2020 оны 12 сарын 31-ний байдлаар

-6.1%
3,244 тэрбум төг.

Нийт хөрөнгө
2020 оны 12 сарын 31-ний байдлаар

➤ Тогтвортой санхүүгийн үзүүлэлтүүд

Тайлант онд дотоодын эдийн засаг 5.3%-р агшиж, эдийн засгийн нөхцөл байдалтай холбоотойгоор банкны нийт хөрөнгө 6.1%-р буурч 3 их наяд 244 тэрбум төгрөгт хүрсэн.

Эдийн засгийн агшилт нь зээлийн багцад нөлөөлж, тайлант онд нийт зээлийн багц 24%-иар буурч 1 их наяд 385 тэрбум төгрөгт хүрч, харин бэлэн мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийн хэмжээ өмнөх онтой харьцуулахад 156 тэрбум төгрөгөөр буурсан. Зээлийн багцын бууралттай холбоотой хүүний орлого буурсан хэдий ч банк хөрөнгө оруулалтын багцаа 745 тэрбум төгрөгөөр өсгөж цэвэр хүүний орлогоо хадгалахыг зорьж ажилласан.

2019 оноос эхэлсэн чанаргүй зээлийг бууруулах, эрсдэлийг удирдах стратегийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж нийт зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн хэмжээг 6.5%-д барьж ажиллалаа. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 1.9%-иар нэмэгдсэн үзүүлэлт боловч системийн нөлөө бүхий бусад 5 банктай харьцуулахад хамгийн бага үзүүлэлт бөгөөд нийт банкны секторын дундаж үзүүлэлт 11.7% байв. Түүнчлэн банк зээлийн багцын зорилтот бүтэц болох иргэд ба бизнесийн зээлийн 75:25 гэсэн харьцаанд хүрч чадсан.

Харилцах хадгаламжийн багц 10.3%-иар өсөж 2 их наяд 5 тэрбум төгрөгт хүрэв. Бодлогын хүүний бууралттай уялдуулан банк хадгаламжийн хүүгээ бууруулж, хугацаатай хадгаламжид бусад банкнуудтай харьцуулахад хамгийн бага хүүг зах зээлд санал болгож байгаа хэдий ч хадгаламжийн багц өссөөр байна. Энэ нь зах зээлд ХасБанкны нэр хүнд өндөр байгаа төдийгүй харилцах хадгаламж эзэмшигчдийн хувьд банкны найдвартай байдал хамгийн чухал үзүүлэлт гэдгийг илтгэж байна.

Тайлант онд төслийн санхүүжилтүүд эргэн төлөгдөж, банк хоорондын захаас төвлөрүүлсэн хөрөнгийн эргэн төлөлтүүд хийгдсэнээр дотоодын зах зээлээс татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ 51 тэрбум төгрөгөөр буурлаа.

Тайлант оны эцэст банкны гадаад эх үүсвэр нийт өр төлбөрийн 26% -ийг бүрдүүлж байна. Гадаад эх үүсвэрт олон улсын нэр хүндтэй банк санхүүгийн байгууллагуудаас татан төвлөрүүлсэн эх үүсвэрүүд багтаж байна. Банк тайлант оны эхээр 100.0 сая ам.долларын эх үүсвэрийг хүү хугацааны таатай нөхцлөөр татан төвлөрүүлсэн бол тайлант оны туршид 119.5 сая ам.долларын эх үүсвэр, 20 сая долларын хоёрдогч өглөгийг эргүүлэн төлсөн. Ингэснээр гадаад эх үүсвэрийн зардлаа бууруулж эх үүсвэрийн бүтцээ сайжруулж чадсан.

➤ Өөрийн хөрөнгийн хүрэлцээ ба хөрвөх чадварын харьцаа

Тайлант хугацааны туршид банк зохицуулагч байгууллагын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг давуулан биелүүлж, тасралтгүй хангаж ажилласаар ирлээ. Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ 16.9% болж өмнөх онтой харьцуулахад 4.9% -иар өсөж, мөн тайлант онд хоёрдогч өглөг эргэн төлөгдсөн хэдий ч нийт өөрийн хөрөнгийн хүрэлцээ 1.6%-иар нэмэгдэж 17.4% болсон.

Тайлант онд Банк өр төлбөр, эх үүсвэрийн бүтцээ сайжруулах зорилтуудаа амжилттай хэрэгжүүлж чадсан. Эдгээр зорилтууд зах зээлийн зарчмаараа хэрэгжиж байгаа боловч, нөгөө талаас зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан шаардлагатай арга хэмжээнүүдийн цаг тухай бүрд, хугацаа алдалгүйгээр авч хэрэгжүүлсний үр дүн юм.

Мөн 2020 онд хөрвөх чадвартай хөрөнгийн хэмжээ өндөр байсан нь эх үүсвэрийн эргэн төлөлт, бүтцийн оновчтой удирдлагыг хэрэгжүүлэхэд эерэгээр нөлөөллөө. ХасБанк зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан гадаад валютын нээлттэй позицийг боломжит бага түвшинд үргэлжлүүлэн барьж ажиллалаа. Түүнчлэн гадаад эх үүсвэр 266 сая ам.долларын ханшийн эрсдэлийг бүрэн хааж, үр ашигтайгаар удирдан ажилласаар байна.

Эдийн засгийн хүндрэлийг бууруулах арга хэмжээний хүрээнд Монгол банк банкнуудын хөрвөх чадварын шалгуур үзүүлэлтийг 25%-аас бууруулж 20% болгосон. Банкны хөрвөх чадварын харьцаа үзүүлэлт жилийн туршид өсөж, 54.9%-д хүрсэн нь Монгол банкны шалгуур үзүүлэлтээс даруй 2.5 дахин өндөр байна. Банк хөрвөх чадвартай хөрөнгөө одоогоор Монгол банкны үнэт цаасанд байршуулж байгаа бөгөөд уг хөрөнгийг эдийн засгийн өсөлтийг дэмжихэд шаардлагатай зээл болгон гаргахаар төлөвлөн ажиллаж байна. ХасБанк эдийн засаг эргэн сэргэж түүнийг дагасан зээлийн эрэлт бий болоход, хүлээгдэж буй зээлийн өсөлтийг дэмжин ажиллахад бэлэн байна.

Дотоод аудит

Дотоод аудитын нэгжийн эрх үүрэг, хамрах хүрээг ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооноос баталсан Аудитын дүрэмд тусган баталсан байдаг. Дотоод аудит нь үндсэн чиг үүргийнхээ дагуу ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороонд тайлагнахын сацуу өдөр тутмын захиргааны асуудлаар Гүйцэтгэх захирлаас чиглэл авч ажиллаж байна.

Дотоод аудитын чиг үүрэгт дараах зүйлс багтаж байна, үүнд:

- Банкны дотоод хяналт, эрсдэлийн удирдлага, засаглалын тогтолцоо, процессын найдвартай, бодит байдал (adequacy), үр ашигт байдлыг үнэлэх;
- Банк нь өөрийн үйл ажиллагаанд холбоотой хууль тогтоомж, журам зааврын нийцлийг хэрэгжүүлж ажиллаж байгаа эсэхийг хянах;
- Удирдлагын зүгээс байгууллагын хяналтын үйл ажиллагаанд илэрч буй доголдлыг арилгах талаар зохистой арга хэмжээ авч байгаа эсэхийг хянах.

Дотоод аудитын газар нь Дотоод Аудитын Олон улсын Институтээс гаргасан Дотоод Аудиторуудын Олон Улсын мэргэжлийн практикийн стандарт болон Ёс зүйн дүрмийг үйл ажиллагаандаа мөрдөн ажилладаг бөгөөд дотоод аудитын мэргэжлийн практикийн үндсэн 10 зарчмыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн.

Дотоод аудитын газар нь хэтийн зорилгоо тодорхойлохдоо дижитал хэрэгсэл, дүрэм болон дүн шинжилгээнд суурилсан урьдчилсан таамаглал дэвшүүлэх замаар тасралтгүй (continuous) хяналтыг хэрэгжүүлж, эрсдэлийн үнэлгээ болон хяналтын аргачлалуудыг хэрэгжүүлэн эрсдэлийн менежментийн талаарх мэдээллийн баазаа нэмэгдүүлэн ажиллаж байна.

Эдгээр хяналтын хэрэгслүүд болон арга аргачлалууд нь хүний нөөцийг үр ашигтай удирдан зохион байгуулах, эрсдэлийн дохиог эрт илрүүлэх, илэрсэн алдааг, дутагдлыг цаг тухайд нь засах боломжийг олгож байна.

Түүнчлэн, эрсдэлийн үнэлгээний давтамжийг ойртуулах боломжийг бий болгосноор аудитын төлөвлөгөөг банкны бизнесийн зорилтуудтай нийцүүлэх боломжийг илүү олгодог давуу талтай.

Өнгөрөгч 2020 онд Дотоод аудитын газар нь эрсдэлд суурилсан аудитын төлөвлөгөөний хүрээнд нийт 8 процессын баталгаажуулалтын аудитыг хийж, анх удаа зөвлөх үйлчилгээний аудитыг байгууллагын гүйцэтгэх удирдлагын багийн хүсэлтийн дагуу хийж гүйцэтгэв. Мэдээллийн технологийн аудитын чиг үүргийн хүрээнд Хөрөнгийн удирдлага, Мэдээллийн технологийн удирдлага болон Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын аудитуудыг тус тус хийж гүйцэтгэсэн байна.

Дотоод аудитын газар нь Дотоод Аудитын Мэргэжлийн хүрээний олон улсын стандартад нийцүүлэн, аудитын бүхий л үйл ажиллагааг хамруулсан Чанарын баталгаажуулалт, сайжруулалтын хөтөлбөрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.Энэхүү хөтөлбөрийн хүрээнд аудитын чанарын үнэлгээг тухай бүр үнэлдэг бөгөөд аудитын үйл ажиллагааны өөрийн үнэлгээг жил тутам хийж ажиллаж байна.

Эрсдэлийн удирдлага

ХасБанкны эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэм хэмжээний хүрээнд эрсдэлийн төрөл, хэмжээг тодорхойлж, эрсдэлийн үйл ажиллагааг зохицуулдаг.

Эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэм хэмжээг үр дүнтэй, тодорхой бий болгох нь өгөөж болон хүлээх эрсдэлийн хоорондох зохистой тэнцвэрийг хадгалахын зэрэгцээ банкны хэмжээнд эрсдэлийн соёлыг бэхжүүлэхэд дэмжлэг болдог.

➤ Эрсдэлийн удирдлагын засаглал

ХасБанк нь Төлөөлөн Удирдах Зөвлөлийн идэвхтэй дэмжлэгтэйгээр эрсдэлийн удирдлагын сайн засаглалыг бий болгож чадсан. Банкны эрсдэлийн засаглалыг дараах хороодоор дамжуулан хэрэгжүүлдэг. Үүнд:

Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн эрсдэлийн удирдлагын хороо: ТУЗ-ийг төлөөлөн эрсдэлийн асуудлууд дээр бие даасан, эцсийн хяналт тавьж ажилладаг. **Эрсдэлийн удирдлагын хороо:** Эрсдэлийн үйл ажиллагаа, эрсдэлийн удирдлагын тогтолцооны хэрэгжилт болон банкны хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээг дагаж мөрдөж байгаа эсэхэд хяналт тавих, үнэлж дүгнэх үүрэг бүхий удирдлагын түвшний хяналтын хороо юм.

Үйл ажиллагааны эрсдэлийн хороо: Банкны хяналтад суурилсан үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын тогтолцоо болон үйл ажиллагааны эрсдэлийн зөвшөөрөх хэм хэмжээнд хяналт тавин ажилладаг. **Зээлийн эрсдэлийн хороо:** Тогтоосон эрх хэмжээний хүрээнд зээлийн саналуудыг шийдвэрлэхэд төвлөрөн ажилладаг.

➤ Эрсдэлийн удирдлагын тогтолцоо

Банкны эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь хамгаалалтын 3 бүсийн зарчимд суурилсан ба эрсдэлийг хариуцах, хянах чиг үүргийг дараах байдлаар тодорхойлдог.

Хамгаалалтын нэгдүгээр бүс (Бизнес нэгжүүд болон түүнд дэмжлэг үзүүлэх нэгжүүд) нь эрсдэлийг хариуцах эзэн байх бөгөөд өөрийн үйл ажиллагааны эрсдэлийг үнэлэх, эрсдэлд хяналт тавих, эрсдэлийг бууруулах чиг үүрэгтэй.

Хамгаалалтын хоёрдугаар бүс (Эрсдэлийн удирдлага, хяналтыг хэрэгжүүлэгч нэгжүүд) нь эрсдэлд хяналт тавих чиг үүргийнхээ хүрээнд эрсдэлийн удирдлагын тогтолцоог бий болгох, холбогдох бодлого, журмыг боловсруулах, эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэм хэмжээ, эрсдэлийн хязгаар үзүүлэлтийг тогтоох, эрсдэлийн цар хүрээг хянах чиг үүргүүдийг хэрэгжүүлдэг. Мөн энэхүү чиг үүргийнхээ хүрээнд, хамгаалалтын хоёрдугаар бүс нь хамгаалалтын нэгдүгээр бүсийн хяналтын үйл ажиллагаа болон шийдэлд хяналт тавих ба тогтмол зааварчилгаагаар ханган ажилладаг.

Хамгаалалтын гуравдугаар бүс (Дотоод аудит) нь хараат бус үнэлэлт, дүгнэлт өгөх чиг үүрэгтэй бөгөөд банкнаас хэрэгжүүлж буй эрсдэлийн цар хүрээг үнэлэх, удирдах арга хэмжээ үр дүнтэй байгаа эсэх болон хамгаалалтын нэг, хоёрдугаар бүсийн үйл ажиллагаа үр дүнтэй байгаа эсэхийг үнэлэх байдлаар эрсдэлд суурилсан арга барилын талаарх хараат бус баталгаагаар ТУЗ-ийг хангадаг.

➤ Зээлийн эрсдэлийн удирдлага

2020 оны хувьд дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас эдийн засаг, бизнес, айл өрхүүдийн санхүүгийн байдалд сөрөг нөлөө үзүүлсэн хүндхэн жил боллоо. Цар тахлын үед банк нь санхүүгийн системийн тогтвортой байдлыг хадгалах хүрээнд Монголбанкнаас гаргасан санаачилга, хөтөлбөрүүдийг амжилттай мөрдөж хэрэгжүүллээ. Үүний зэрэгцээ банк эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдлыг даван туулах бодлого, төлөвлөгөөгөө тодорхойлж, Ковид-19 цар тахлын нөлөөллөөр зээлийн эргэн төлөлт нь хүндрэлд орсон харилцагчийн зээлийн нөхцөлд өөрчлөлт оруулан ажиллалаа.

Түүнчлэн, зээл эрсдэлд орохоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг эрт илрүүлэх үүднээс Эрсдэлийн дохионы системийг боловсруулан үйл ажиллагаандаа амжилттай хэрэгжүүлээд байна.

➤ Үйл ажиллагааны эрсдэл

ХасБанк нь өдөр тутмын үйл ажиллагааны хүрээнд үүсэж болзошгүй өргөн цар хүрээтэй үйл ажиллагааны эрсдэлийг урьдчилан илрүүлэх, үнэлэх, хянах, бууруулах замаар эрсдэлийг удирдан ажилладаг. Үйл ажиллагааны эрсдэл нь банкны Үйл ажиллагааны эрсдэлийг удирдах ерөнхий журмаар зохицуулагддаг ба 2020 онд эрсдэлийн үнэлгээг илүү үр дүнтэй хэрэгжүүлэх үүднээс журмыг хянан шинэчилсэн.

Банк нь үйл ажиллагаатай холбоотой үүссэн эрсдэлийг илрүүлэх, тодорхойлох, үнэлэх байдлаар сар бүр хяналт хийн үйл ажиллагааны эрсдэлийг хүлээн зөвшөөрөх хэмжээний түвшинд байлгах арга хэмжээг авч, зөв зохистой дотоод хяналт бүхий тогтвортой процессыг бий болгон тасралтгүй хянан, сайжруулснаар үйл ажиллагааны эрсдэлийг бууруулан ажиллаж байна.

➤ Зах зээлийн болон хөрвөх чадварын эрсдэлийн удирдлага

2020 онд Банк нь зах зээлийн болон хөрвөх чадварын эрсдэлийн үзүүлэлтүүдийг Банкны хүлээн зөвшөөрөх хэмжээнд хангаж ажиллалаа.

Өмнөх жилүүдээс хадгалагдаж ирсэн хөрвөх чадварын өндөр түвшнийг хадгаламжийн хүү буурч буй зах зээлийн нөхцөлд 2020 оны туршид хадгалж чадсан нь банкны хадгаламжийн тогтвортой байдлыг илэрхийлж байна.

Төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2020 онд 4 хувиар суларсан нь экспортын орлого тасраад байсан тодорхойгүй үед Монголбанкны зүгээс авч хэрэгжүүлсэн уян хатан бодлогын үр дүн болно. 2020 оны 7 дугаар сараас хойш экспорт эргэн сэргэж эхэлснээр ам.долларын ханш 2850 төгрөг орчимд тогтвортой байна. Тус хугацаанд Банк гадаад валютын позицийн Монголбанкны шаардлагыг бүрэн хангахаас гадна цэвэр нээлттэй позицийн ашиг, алдагдлын хэмжээг (Хамгийн Их Эрсдэл (Value-At-Risk) - ийн үнэлгээ) Банк хүлээн зөвшөөрөх хэмжээнд хангаж ажиллалаа.

➤ Хянан нийцүүлэлт

Монгол улс нь Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага ФАТФ-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай орнуудын жагсаалт буюу “саарал жагсаалт”-д орсноос үүдэн 2020 он нь Монгол улсын хувьд хүндхэн жил боллоо. ФАТФ-ын саарал жагсаалтад орсонтой холбогдуулан Монголбанк нь арилжааны банкуудад хийгдэх хяналт шалгалтаа улам сайжруулж, арилжааны банкуудаас зохицуулагч байгууллагад хүргэх тайлан мэдээний давтамж нь нэлээн хэмжээгээр нэмэгдсэн.

Мөн саарал жагсаалтад орсонтой зэрэгцэн Европын комисс нь Монгол улсыг өндөр эрсдэлтэй гуравдагч орноор зарлалаа.

ФАТФ-ын саарал жагсаалт болон Европын комиссын өндөр эрсдэлтэй гуравдагч улсаар зарлагдсантай холбогдуулан Монгол улсын засгийн газар нь санхүүгийн секторт олон арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. Үүний үр дүнд төрийн зохицуулагч байгууллага болон банкуудын хоорондох хамтын ажиллагаа сайжирлаа. Түүнчлэн ХасБанк нь Монгол улсын үндэсний эрсдэлийн үнэлгээ хийх ажлын хүрээнд байгуулагдсан банкны секторын дэд ажлын хэсэгт үр дүнтэй идэвхтэй ажиллалаа.

Ийнхүү мөнгө угаах терроризмтой тэмцэх чиглэлээр Монгол улсын засгийн газраас олон арга хэмжээ авч хэрэгжүүлсний үр дүнд Монгол улс нь энэ чиглэлээр дэлхийн жишиг стандартад нэлээн ойртож байна.

Эцэст нь 2020 оны 10 сард ФАТФ-ын үнэлгээний баг Монгол улсад газар дээрх үнэлэлт шалгалт хийсэн бөгөөд шалгалтын үр дүнд Монгол улсыг Санхүүгийн дутагдалтай орон буюу саарал жагсаалтаас гаргах шийдвэр гаргасан. ФАТФ-ын уг шийдвэр гарсны дараа Европын комисс нь Монгол улсыг мөн өөрийн жагсаалтаас гаргах шийдвэрийг саяхан гаргалаа.

Банкны хянан нийцүүлэх функц нь сургалт, танин мэдэхүйн үйл ажиллагаа явуулах замаар банкны бусад нэгж болон функцүүдийг чадавхжуулж харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа, сэжигтэй гүйлгээ илгээх болон хяналт шалгалт хийх өргөтгөсөн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж байна.

ХасБанк нь зохицуулагч байгууллага болон санхүүгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг дэлхийн өнцөг булан бүрд байрлах байгууллагууд болон хууль хяналтын байгууллагуудтай хамтран ажиллаж банк болон Монголын эдийн засагт тулгарч буй тасралтгүй өөрчлөгдөж буй сорилтуудад нийцсэн хянан нийцүүлэлтийн функцийг улам боловсронгуй болгож байна.

Хүний нөөц

Хүний нөөцийн удирдлага

Манай банкны хүний нөөцийн бодлого нь олон талт ур чадвар бүхий ажилтнуудаас бүрдэх ажил хэрэгч соёлыг дэмжих, хүртээмжтэй ажиллах орчинг бүрдүүлэх, өрсөлдөхүйц хэмжээний цалин хөлс олгох, ажил эрхлэлтийн шударга арга барилаар ажиллах, сурч хөгжих боломжийг ажилтан бүрт олгоход чиглэдэг.

Бид төрөл бүрийн нийгмийн хөтөлбөрөөр дамжуулан ажилтнуудынхаа амьдралын чанарыг дээшлүүлэх, ажил амьдралын тэнцвэрт байдлыг хангаж ажиллахад тууштай байр суурийг баримталж ирсэн.

2020 оны эцсийн байдлаар ХасБанк 1135 идэвхтэй ажилтантай байсан, ба өмнөх онуудтай харьцуулвал 2019 онд 1195, 2018 онд 1270, 2017 онд 1304 ажилтантайгаар тус тус ажилласан. Ажилтнуудын дундаж нас 33.9 бол ХасБанкинд ажилласан дундаж хугацаа 7.3 жил байна.

Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуулийн шаардлагын дагуу 2020 оны туршид нийт 200 ажилтны ажлын байрыг хүүхэд асрах чөлөөний хугацаанд хадгалсан бөгөөд хүүхэд асрах чөлөөнөөс 83 ажилтан ажилдаа эргэн орсон.

• Нийт хөдөлмөрийн гэрээтэй ажилтны тоо	1335
• Идэвхитэй ажилтны тоо;	1135
• Урт хугацааны чөлөө;	200
• Төв албаны ажилтны тоо;	366
• УБ хотын салбарын ажилтны тоо;	412
• Орон нутгийн салбарын ажилтны тоо;	357
• Дээд болон дунд шатны гүйцэтгэх удирдлага;	9+117
• Эрэгтэй ажилтан;	449
• Эмэгтэй ажилтан;	686
• Хөгжлийн бэрхшээлтэй ажилтан;	16
• Шинээр ажилд авсан ажилтны тоо;	166
• Ажил горилогчийн тоо;	1068
• Ажилтны дундаж нас;	33.9
• Ажилтны дундаж ажилласан хугацаа;	7.3

Цалин хөлс, хангамж

2020 онд албан тушаалын зэрэглэл, түүнд халгалзах цалингийн сүлжээг шинэчлэн, сүлжээний хамгийн доод хэмжээг дунджаар 20 хувиар нэмэгдүүлэн тогтоолоо. Цалингийн шинэчилсэн сүлжээний дагуу ажилтнуудын цалинг дунджаар 10 хувь нэмэгдүүллээ.

Цалин урамшууллын бодлогоо үргэлжлүүлэн хэрэгжүүлж, гүйцэтгэлийн урамшууллыг нийт ажилтнууддаа олгосон. Мөн урт хугацаат урамшууллын бодлогын хүрээнд Хувьцааны үнэд суурилсан урамшууллын хөтөлбөрөө үргэлжлүүлэн хэрэгжүүллээ.

Онцлох нь

2020 он манай банк төдийгүй дэлхий нийтийн хэмжээнд цар тархлын нөхцөл байдалтай уялдан ажиллах шинэ зорилтын жил байв. Ажил амьдралын шинэ хэв маягт банкны бизнесийн тасралтгүй үйл ажиллагаа хангаж ажиллах, ажилтнуудынхаа эрүүл аюулгүй ажиллах орчин нөхцлийг бий болгоход чиглэж ажиллалаа.

Банкны сургалт, хөгжлийн үйл ажиллагаандаа 2020 оноос TalentLMS онлайн сургалтын платформыг ашиглаж эхэллээ.

Мөн банкны шинэ үндсэн системийг нэвтрүүлэх төслийн хүрээнд Энэтхэг улсын Инфосис компанитай хамтарсан онлайн сургалтуудыг системтэйгээр хоёр сарын туршид зохион байгууллаа.

Дунд шатны менежерүүд болон салбарын захирлуудад тодорхойгүй нөхцөл байдалд удирдах ажилтны манлайллыг хэрхэн хэрэгжүүлэх ур чадварыг хөгжүүлэх сургалтуудыг зохион байгууллаа.

Байгууллагын дотоод харилцаа холбоог сайжруулах, идэвхжүүлэх, түргэн шуурхай мэдээлэл солилцох, нээлттэй харилцааг дэмжих зорилгоор Workplace-г нэвтрүүллээ.

Ингэснээр ХасБанкны нийт ажилтнууд хаанаас ч, хэзээ ч хялбархан харилцах технологийн боломжтой болж илүү нээлттэй, хурдтай, олон талт байдлаар мэдээлэл солилцох болсон.

Коронавируст халдварын нөхцөл байдалтай уялдуулан гаргаж буй аливаа шийдвэр, мэдээ, мэдээллийг цаг алдалгүй солилцох гол хэрэгсэл боллоо.

Түүнчлэн, ажилтнууд албан харилцаанаас гадна сонирхлын бүлгэмээрээ нэгдэх боломжтой болсон.

Ажилтнуудын хөнгөлөлт хангамж, сайн сайхан оршихуй

Ажилтнуудынхаа санхүүгийн баталгааг хангах, ажилтанд нэмэлт тэтгэврийн хуримтлалтай болгох зорилготой хувийн тэтгэврийн хөтөлбөрийг 2007 оноос хойш амжилттай хэрэгжүүлж байна. Мөн ажилтнуудынхаа нийгмийн асуудлыг дэмжих, эрүүл мэндийг хамгаалахад зориулж жил бүр гэнэтийн осол, эрүүл мэндийн даатгалд хамруулж байна.

Ажилтнуудынхаа ажил, амьдралын тэнцвэрт байдлыг хангах бодлогын хүрээнд гэр бүлдээ болон хувийн хөгжилдөө зарцуулах цаг гаргах үүднээс төрсөн өдөр нь тохиож буй ажилтнууддаа нэг өдрийн цалинтай чөлөө, хуанлийн нэг жилд Гүйцэтгэх захирлын нэрэмжит хоёр өдрийн цалинтай чөлөө авах эрхийг олгож эхэлсэн.

Коронавируст халдварын онцгой нөхцөл байдалд ажилчдынхаа эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор ажилчдад автобусаар үйлчилгээ үзүүлэх, халдвар хамгааллын хэрэгслээр хангах, нийслэл хот дахь салбарын ажилтнуудаа коронавируст халдварыг илрүүлэх түргэвчилсэн болон PCR шинжилгээнд хэдэн хэдэн удаа хамрууллаа.

Түүнчлэн салбар, тооцооны төвийн ажилчдын ажлын өдрийн ажиллах цагийг 3 хүртэл цагаар богиносгох, Төв албаны ажилтнуудаа уян хатан цагийн хуваариар ажиллуулах, УОК-оос тогтоосон өндөржүүлсэн бэлэн байдлын хугацаанд зайлшгүй ажлын байранд ирж ажиллах шаардлагатай ажилтнуудаас бусад бүх ажилтнуудыг зайнаас буюу гэрээс нь ажиллуулах зохицуулалтыг хийлээ.

Мөн хөл хорионоос шалтгаалж сул зогссон болон, 0-12 насны хүүхэдтэй эмэгтэй ажилтнууд (1958 хүн-өдөр) болон жирэмсэн ажилтнууддаа (2816 хүн-өдөр) цалинтай чөлөө олгох зэрэг арга хэмжээ авч ажиллалаа.

Гэрээсээ ажилласан (Төв албаны ажилтнуудын 80%) сул зогссон (1650 хүн-өдөр) болон хөл хорио, тусгаарлалтад (250 хүн-өдөр) орсон ажилтнуудынхаа цалин хөлсийг бүтэн буюу 100%, зайлшгүй ажлын байранд ирж ажилласан (1114 хүн-өдөр) ажилтнууддаа цалин хөлсийг 125 хүртэл хувиар тооцож олгохын сацуу томуу, томуу төст өвчнөөр өвдсөн ажилтнууддаа гурав хүртэл өдрийн цалинтай чөлөө олголоо.

Энэхүү арга хэмжээнүүд нь цар тахлын хүнд хэцүү нөхцөл байдалд ажилтнуудынхаа цалин, орлогыг тасалдуулалгүй, эрүүл мэндийг хамгаалах бодит дэмжлэг болж, ажилтнуудын сэтгэл ханамж өндөр байна.

125%

Зайлшгүй ажлын байранд ирж ажилласан

100%

Гэрээсээ ажилласан, сул зогссон, хөл хорио, тусгаарлалтад орсон

1 өдөр

Төрсөн өдрийн цалинтай чөлөө

2 өдөр

Гүйцэтгэх захирлын нэрэмжит цалинтай чөлөө

3 өдөр

Томуу, томуу төст өвчнөөр өвчилсөн бол 3 хүртэл өдрийн цалинтай чөлөө

Хүний нөөц

Сургалт, хөгжил

Коронавируст халдварын онцгой нөхцөл байдалд банкныхаа сургалт, хөгжлийн тасралтгүй байдлыг хангахын тулд онлайн хэлбэрээр нийт сургалтын 86 хувийг зохион байгууллаа.

Ажилтнуудын ажил, мэргэжлийн ур чадвар, мэдлэгийг сайжруулах үүднээс мэргэшсэн зэрэгт бэлтгэх сургалт, олон улсын мэргэжлийн зэрэг олгох сургалт, хөтөлбөрүүдэд зорилтот ажилтнуудыг хамруулахаас гадна салбар, тооцооны төвийн ажилтнуудын сургалтад голчлон анхаарч нийт 27.336 хүн/цагийн сургалтыг зохион байгууллаа. (2019 онд 26.840 хүн/цаг, 2018 онд 47.324 хүн/цаг, 2017 онд 53.178 хүн/цаг).

1,077

Сургалтанд хамрагдсан ажилтны тоо

27,336

Нийт хүн/цаг

91

сая төгрөг

Сургалтын нийт хөрөнгө оруулалт

Иргэдийн банк:

- Бизнесийн зээлийн мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор зээлийн судалгаа шинжилгээ, зээл олголт болон зээл олгосны дараа олгосоны дараах хяналт зэрэг агуулгын хүрээнд Бизнесийн зээлийн судалгаа шинжилгээний сургалтыг зохион байгууллаа.
- Монголын Банкны Холбоо болон ХБНГУ-ын Шпаркассэ Банкны Сангийн хамтарсан төслийн хүрээнд зохион байгуулагддаг “Банкны мэргэжилтэн бэлтгэх” хөтөлбөрт хамтарч ажиллалаа.
- Салбар, тооцооны төвийн 9 албан тушаалын 674 ажилтан TalentLMS онлайн сургалтын платформаар дамжин 40 төрлийн сургалтанд хамрагдсан.
- Шинээр томилогдон ажиллаж байгаа 37 харилцагчийн үйлчилгээний мэргэжилтнийг чиглүүлэх болон програмын сургалтанд хамрууллаа.

Менежмент болон манлайллын сургалт:

- Люксембургийн Их Гүнт Улсын сургалт, судалгаа, зөвлөх үйлчилгээний House of Training байгууллагаас онлайнгаар зохион байгуулсан “People Management” сургалтанд 3 захирал хамрагдлаа;
- Дэйл Карнеги Монгол сургалтын төвийн “Communication Skill” сэдэвт сургалтанд дунд түвшний удирдах 20 ажилтан хамрагдлаа. Сургалтаар өөрчлөлтийн менежмент, удирдахын тулд харилцах, хүчирхэг багийг хэрхэн бий болгох талаарх мэдлэгийг олголоо;
- “Санаагаа хэрхэн оновчтой илэрхийлэх вэ” онлайн сургалтанд дунд түвшний 24 удирдах ажилтныг хамрууллаа. Сургалтыг зохион байгуулахад Discord платформыг ашигласан нь шинэлэг байлаа.

Салбарын ажилтнуудын талант үнэлгээ:

Өндөр гүйцэтгэлтэй болон өсөх ирээдүйтэй ажилтнуудыг тодорхойлох, ажилтнуудын карьер төлөвлөлтийг хийх, сургалт хөгжлийн оновчтой хөтөлбөр боловсруулах зорилгоор Улаанбаатар хотын салбар, тооцооны төвийн нийт 312 ажилтны талант үнэлгээ буюу ур чадварын үнэлгээг хийснээс 119 ажилтан өндөр гүйцэтгэлтэй ажилтнаар үнэлэгдсэн.

Хянан нийцүүлэлт:

- Тогтвортой хөгжил, ногоон эдийн засаг, Монгол улс дах тогтвортой санхүүжилтийн талаарх мэдлэг олгох зорилготой Тогтвортой санхүүжилтийн сургалтыг 2020 онд онлайн хэлбэрээр зохион байгуулж, 216 ажилтнаа хамрууллаа.
- 2016 онд банканд нэвтрүүлсэн Хянан нийцүүлэлтийн цахим сургалтыг үргэлжүүлэн зохион байгуулж, 2020 онд шинээр ажилд орсон 91 ажилтныг хамрууллаа.

Мэдээллийн технологийн сургалт:

Банк мэдээллийн технологийн ажилтнуудаа олон улсын мэргэжлийн зэрэг авах, олон улсын түвшинд ажиллах чадвар олгох сургалтуудад хамруулахад голчлон анхаарч ажиллалаа.

Онцлог сургалтуудыг дурьдвал:

- Data Science болон Complete Oracle SQL сургалт;
- Мэргэшсэн инженерийн сургалт;
- Олон улсад түвшний PMI-PBA, CISM, CISA зэрэг хөтөлбөр;

2020 оны Онцлох үйл явдлууд

ДЭМЖЛЭГ

Ковид 19-ийн улмаас бизнесийн үйл ажиллагаанд нь бэрхшээл учирсан харилцагчдынхаа зээлийн гэрээний нөхцөлд өөрчлөлт оруулах хүсэлтийг банкны салбартаа хамгийн түрүүнд онлайнгаар хүлээн авч, шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлэн, шуурхай зохион байгууллаа.

ЖДБизнес

ЖДБ-ийг дэмжих зорилгоор Нидерландын Хөгжлийн Агентлагаас

100 сая

ам.долларын хамтын санхүүжилт авлаа.

FMO

Entrepreneurial Development Bank

ГЭРТЭЭ

Хөл хориотой холбоотойгоор харилцагчдад цахим үйлчилгээнүүдийг сурталчлан таниулах, сургах, бүртгэл, эрхүүдийг сэргээх ажлыг түлхүү хийсний үр дүнд салбарын ачааллыг бууруулж, олон хүн цуглах эрсдэлийг багасгалаа.

2020 оны шагналууд

Дотоодод

ТОП 100

МҮХАҮТ
ТОП 100 ААН-ийн 21-т

Олон улсад

IFC

Хамгийн хурдтай өсөж буй түнш банк

Эко

ToC

Шилдэг ToC банк

Банкны засаглал



➤ Зохистой засаглал үнэ цэнтэй гэдгээ нотолж байна

Зохистой засаглал нь ХасБанкны байгууллагын соёл, үнэт зүйлсийн салшгүй хэсэг бөгөөд банкны бизнесийг тогтвортой байдлаар амжилттай хөгжүүлэх, хувьцаа эзэмшигчид болон нэгдмэл сонирхолтой бусад талуудад урт хугацааны үнэ цэн бий болгох, ХасБанканд итгэх итгэлийг бэхжүүлэх үндэс суурь гэдгээ өнгөрсөн жилийн дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын нөхцөл байдал, түүнээс үүдэлтэй нийгэм эдийн засгийн хямралын үеэр урьд өмнөөс илүү тод харуулав.

2020 он нь зохистой засаглал үнэ цэнээ нотолсон жил боллоо. Нэгдмэл сонирхолтой бүх талуудын ашиг сонирхол, санхүү үйл ажиллагааны тогтвортой байдал, нийгмийн итгэх итгэл зэргийг харгалзан шийдвэр гаргах явдал урьд өмнөөс чухал байсан бөгөөд үүнийг Монгол улсын хууль тогтоомж, дүрэм журам дагаж мөрддөг, олон улсын стандарт туршлагад нийцсэн зохистой засаглалын тогтолцоо хангаж чадсан. Жилийн туршид ТУЗ, хувьцаа эзэмшигчид болон гүйцэтгэх удирдлагаас цар тахлаас үүдэлтэй хямралын нөхцөлд хариу арга хэмжээ, эдийн засаг бизнесийг сэргээх төлөвлөгөө хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажилласан бөгөөд ингэхдээ байгууллагын урт хугацааны зорилт, хувьцаа эзэмшигчид болон бусад нэгдмэл сонирхолтой талуудын урт хугацааны ашиг сонирхлыг орхигдуулахгүй байхад анхаарч ажилласан.

Хувьцаа эзэмшигчид

- Хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхлыг бусад нэгдмэл сонирхолтой талуудын ашиг сонирхолтой уялдуулж, урт хугацааны үнэ цэн бий болгоход анхаарлаа хандуулан ТУЗ болон гүйцэтгэх удирдлагаас гаргаж буй шийдвэрүүдэд дэмжлэг үзүүлж ажилласан.

ТУЗ

- Хямралын нөхцөлд ажиллаж буй гүйцэтгэх удирдлагад дэмжлэг үзүүлж, оновчтой шийдвэрүүдийг цаг тухайд гаргаж ажилласан.
- Хямралын хариу арга хэмжээ хэрэгжүүлж, цаг үеийн асуудлуудыг шийдвэрлэхээс гадна стратегийн зорилтуудад анхаарч ажилласан.

Гүйцэтгэх удирдлага

- Ажилласад, харилцагчдыг хамгаалах, харилцагчдын хэрэгцээг хангахад чиглэсэн хариу арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн.
- Хямрал, тодорхой бус байдлыг даван туулахад шаардлагатай нөөц бүрдүүлэх, активын чанарыг сайжруулахад анхаарсан.
- Банкны өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, цахим шилжилтийг үргэлжлүүлэх, харилцагчийн үйлчилгээг сайжруулахад чиглэсэн урт хугацааны зорилтуудыг үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн.

ХасБанк нь Монгол Улсад бүртгэлтэй, хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр байгуулагдсан арилжааны банк бөгөөд Монгол Улсын хууль тогтоомжоос гадна банкны салбарын зохицуулагч Монголбанк (Төв Банк)-аас гаргадаг засаглалын дүрэм, журмын заалтуудыг дагаж мөрдөх үүрэгтэй. Бид “Банкны зохистой засаглалын зарчмуудыг хэрэгжүүлэх журам”-ын дагуу зохистой засаглалын тайлан гаргаж, Монголбанканд хүргүүлж тайлагнадаг.

2020 онд ХасБанкны ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь зохистой засаглалын зарчмуудын дагуу ажиллах, засаглалын тогтолцоог үнэлж дүгнэх, цаашид сайжруулах дээр анхаарч ажилласан.

Энэхүү тайланд Компанийн засаглал, хянан нийцүүлэлтийн хүрээнд хийгдсэн үйл ажиллагааг танилцуулсан болно.

Банкны засаглал

Засаглалын бүтэц

ХасБанк нь Монгол Улсын санхүүгийн томоохон компаниудын нэг болох ТэнГэр Санхүүгийн Нэгдэл /ТСН/ ХХК-ийн бүрэн эзэмшлийн охин компани юм. ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК нь олон улсын санхүүгийн байгууллага, дотоодын болон гадаадын нэр хүндтэй компани, хөрөнгө оруулалтын сан, төрийн бус байгууллага болон хувь хүмүүсээс бүрдсэн хувьцаа эзэмшигчдийн бүтэцтэй.

Банкны эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд Банкны засаглалын дотоод журмын дагуу толгой компани ТСН ХХК-ийн хувьцаа эзэмшигчид Банкны хувьцаа эзэмшигчийг төлөөлдөг.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт хувьцаа эзэмшигчдээс сонгогдсон төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”) нь хувьцаа эзэмшигчдийн мэдэлд хамрагдахаар тусгайлан заасан асуудлуудаас бусад бүх асуудлаар шийдвэр гаргадаг. ТУЗ нь Банкны стратеги, бодлогыг тодорхойлж, эдгээр зорилгод хүрэхэд шаардлагатай санхүүгийн болон хүний нөөцийг бүрдүүлэх төлөвлөгөөг батлах зэргээр Банкний стратегийн удирдлагаар хангадаг. ТУЗ нь Банкны үйл ажиллагаа хууль тогтоомж, дотоод журам, батлагдсан төлөвлөгөө, төсөв, мөн Эрдэнэт Хүмүүн, Эх Дэлхий, Эрүүл Ашиг гэсэн эрхэм зорилгын хүрээнд Банктай нэгдмэл сонирхолтой бүх талуудын эрх ашгийн төлөө явагдаж буй эсэхэд хяналт тавьж, эрсдлийг илрүүлж, үнэлж, удирдахын тулд дотоод хяналтын зохистой тогтолцоог бүрдүүлж ажилладаг.

ТУЗ нь эрх үүргээ хэрэгжүүлж, үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулах үүднээс байнгын хороодыг байгуулж, хороод нь ТУЗ-өөс өгсөн тодорхой чиг үүргийн дагуу ТУЗ-ийн хэлэлцэх асуудлуудаар зөвлөмж дүгнэлт гаргаж ТУЗ-д танилцуулдаг, мөн ТУЗ-өөс өгсөн эрх мэдлийн хүрээнд тодорхой асуудлаар шийдвэр гаргадаг. Яаралтай эсвэл онцгой асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор бусад түр хороог байгуулж ажиллуулдаг.

Банкны өдөр тутмын үйл ажиллагааг ТУЗ-өөс томилогдсон гүйцэтгэх захирал удирдаж явуулдаг. Гүйцэтгэх захирал нь Банкнийг төлөөлөн ажиллаж, хувьцаа эзэмшигчид болон ТУЗ-д тогтмол тайлагнах үүрэгтэй.

Хувьцаа эзэмшигчдийн хурал

2020 онд цар тахлын халдвар тархахаас сэргийлэх олон нийтээс зай барих арга хэмжээнүүд хэрэгжиж байгаа энэ үед хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2020 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр хуралдуулахдаа оролцогчдод харилцаа холбооны хэрэгслээр дамжуулан оролцох боломжийг бүрдүүлж, хурлыг цахим хэлбэртэй хослуулсан байдлаар зохион байгуулж явуулсан. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар Банкны жилийн үр дүн, үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, 2019 оны аудитлагдсан санхүүгийн тайлан тэнцэл зэрэг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэж шийдвэрлэдэг асуудлаас гадна дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын нөлөө, ТУЗ болон гүйцэтгэх удирдлагаас авч хэрэгжүүлж байгаа хариу арга хэмжээнүүдэд онцгой анхаарал хандуулж авч хэлэлцсэн.

Банкны тогтвортой байдлыг хангах, банкны бизнесийн хариуцлагыг нэмэгдүүлэх, нэгдмэл сонирхолтой талуудын эмзэг бүлгийг дэмжихэд чиглэсэн стратеги шийдвэрүүд гаргахад анхаарч ажилласан.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар цар тахлын хямралыг давж гарах, дараах өсөлтийг хангахад өөрийн хөрөнгийн хүрэлцээ, түүний хамгаалах нөөц бүрдүүлэх үүднээс 2019 оны үр дүнгийн ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.

Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах өдрөөс өмнө зарим ТУЗ-ийн гишүүдийн хуанлийн хоёр жил гэж тогтоосон 2 жилийн бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болж байгаатай холбогдуулан ТУЗ-ийн гишүүдийн сонгуулийг 2020 оны 3 дугаар сард Компанийн тухай хууль болон дотоод журмын заалтуудын дагуу онлайн санал хураалтаар хуралдсан хурлаар явуулсан.

Тайлант хугацаанд хувьцаа эзэмшигчид, ТУЗ болон гүйцэтгэх удирдлага шийдвэрүүдийн талаар мэдээлэл солилцож, хувьцаа эзэмшигчдийг эрхээ хэрэгжүүлэх боломжоор хангаж, хувьцаа эзэмшигчдийн шийдвэр гаргалтыг дэмжиж ажилласан.

ТУЗ-ийн манлайлал

2020 онд ТУЗ-өөс ухаалаг удирдамжаар хангах, хяналтыг идэвхтэй хэрэгжүүлэх явдал урьд өмнөхөөс илүү чухал байв. Тайлант хугацаанд ТУЗ нь урьд өмнө тохиолдож байгаагүй нөхцөлд ажиллаж байгаа Банк, Банкны гүйцэтгэх удирдлагад стратегийн удирдлага, дэмжлэг үзүүлж, Банкны тогтвортой байдлыг хамгаалах, түүний тэсвэрлэх чадварыг нэмэгдүүлэх, улмаар нийгэм, харилцагчдын Банканд итгэх итгэлийг хадгалж бэхжүүлэхэд анхаарлаа хандуулж ажилласан.

ТУЗ-ийн бүтэц

ТУЗ нь ТУЗ-ийн гишүүн бүрийг асуудлын хэлэлцүүлэгт оролцуулж үр дүнтэй үйл ажиллагааг хангах, нөхцөл байдлыг өргөн цар хүрээтэй харж дүгнэлт гаргаж, түүнийгээ үндэслэн оновчтой шийдвэр гаргахад ТУЗ-ийн бүтэц, гишүүдийн тоо, чадвар, мэргэшсэн дадлага туршлага, гүйцэтгэх удирдлагын төлөөлөл, хараат бус гишүүдийн оролцоо нь нэн чухал ач холбогдолтой гэсэн зарчмаар ажилладаг. Банкны тулгарч буй асуудлуудыг ойлгож шийдвэрлэх, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавьж, чиглүүлэхэд ТУЗ-ийн гишүүдийн банкны салбарын мэдлэг боловсрол, туршлага, мэргэжлийн ур чадвар, жендер, харьяаллын тэнцвэртэй байдал чухал гэдгийг хүлээн зөвшөөрч, Банкны стратегийн чиглэлтэй уялдуулан ТУЗ-ийн бүрэлдэхүүн, бүтцийг үнэлж нягталж, өөрчлөх шаардлагатай эсэх талаар дүгнэлт зөвлөмж гаргадаг.

2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар ТУЗ нь Хувьцаа эзэмшигчдээс нэр дэвшүүлсэн 6 гишүүн, гүйцэтгэх удирдлагын төлөөлөл болох нэг гишүүн, 3 хараат бус гишүүнээс бүрдсэн бүрэлдэхүүнтэй байсан. ТУЗ-ийн даргын үүргийг хувьцаа эзэмшигч бус, аливаа хувьцаа эзэмшигчийн холбогдох, нэгдмэл сонирхолтой этгээд бус, хараат бус байр суурьтай гишүүн гүйцэтгэдэг. ТУЗ-ийн бүрэлдэхүүнд банкны салбарын олон талын туршлагатай, ур чадвартай гишүүд ажилладаг.

#	Нэр	Албан тушаал	Төлөөлөл
1	Санжай Гүпта	ТУЗ-ийн дарга	Хараат бус
2	Гүмэнжавын Цэвэгжав	ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал	_*
3	Альбертус Брагинк**	ТУЗ-ийн гишүүн	ОРИКС
4	Андрезеж Витак	ТУЗ-ийн гишүүн	ЕСБХБ
5	Мелисса Мой Тиан	ТУЗ-ийн гишүүн	ОУСК
6	Майкл Мадден	ТУЗ-ийн гишүүн	Ронок Партнерз
7	Нямтайширийн Цэлмүүн	ТУЗ-ийн гишүүн	МАК ХХК
8	Ив Жако	ТУЗ-ийн гишүүн	Канадын Үндэсний Банк
9	Баянсаны Уламбаяр	ТУЗ-ийн гишүүн	Хараат бус
10	Нираж Вэдва	ТУЗ-ийн гишүүн	Хараат бус
11	Морис Лам	ТУЗ-ийн гишүүн	Хараат бус

*Дүрэмд заасны дагуу

*ТУЗ-ийн шийдвэрээр 2021 оны Хувьцаа эзэмшигчдийн хурал хүртэл ТУЗ-ийн шийдвэрээр түр томилогдсон гишүүн

Банкны засаглал

ТУЗ-ийн гишүүд



Санжай Гүпта
ТУЗ-ийн дарга

Санжай Гүпта ХасБанк болон түүний толгой компани Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн ТУЗ-ийн даргаар 2019 оны 3 дугаар сарын 28-ны өдөр томилогдсон. ТУЗ-ийн даргаар томилогдохоос өмнө тэрбээр Олон Улсын Санхүүгийн Корпораци (IFC)-аас нэр дэвшиж сонгогдсон ТУЗ-ийн гишүүнээр 2 жил ажиллаж бөгөөд энэ хугацаанд ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүн, Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны гишүүнээр, сүүлийн нэг жилийн хугацаанд тус хорооны даргаар ажиллаж байсан. Санжай Гүпта 2019 оны 3 дугаар сард хуралдсан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар улиран сонгогдсон бөгөөд түүний 2 жилийн бүрэн эрхийн хугацаа 2021 оны 3 дугаар сарын Хувьцаа эзэмшигчдийн хурлаар дуусгавар болж, түүнийг улируулан сонгох сонгууль явагдана. ТУЗ-ийн даргаар томилогдоход Санжай Гүпта-гийн ОУСК-ийн төлөөллийн мандат нь дуусгавар болж, тэрбээр бие даасан, аливаа хувьцаа эзэмшигчээс хараат бус байр суурьтай болсон. Санжай Гүпта Банк оф Америка (Bank of America), Креди Агриколь Групп (Credit Agricole Group)-ын Ази, Номхон Далай, Европ, ойрх Дорнод болон Африкийн бүс нутаг, БНЭУ дахь салбаруудад удирдах албан тушаал хашиж, олон улсын банкны салбарт 34 жил ажилласан туршлагатай.



Гүмэнжавын Цэвэгжав
ТУЗ-ийн гишүүн ба Гүйцэтгэх захирал

Гүмэнжавын Цэвэгжав 2019 оны 5-р сарын 8-ны өдрөөс ХасБанкны Гүйцэтгэх захирлаар томилогдож, 2020 оны 4 дүгээр сарын Хувьцаа эзэмшигчдийн хурлаар ХасБанкны гүйцэтгэх захирлын бүрэн эрхийг хэрэгжүүлэх хугацаанд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнээр сонгогдон ажиллаж байна. Г.Цэвэгжав мөн Тэнгэр Даатгал ХХК-ийн ТУЗ-ийн даргаар ажилладаг. Үүнээс өмнө тэрбээр ХасБанк, ТСН ХХК-ийн хэмжээнд 2011 оноос хойш ХасБанк, ТСН ХХК-ийн Санхүү хариуцсан захирал, Хас Лизинг ХХК-ийн Гүйцэтгэх захирал, ХасБанкны Иргэдийн банк хариуцсан захирал, Ерөнхий захирлаар тус тус ажиллаж байсан. ХасБанк, ТСН ХХК-д ажиллаж эхлэхээс өмнө тэрбээр 2004-2011 онуудад АНУ-д томоохон компаниудад хөрөнгө зохицуулалтын менежер, санхүүгийн шинжээчээр ажиллаж амьдарч байсан.



Альбертус Браггинк
ТУЗ-ийн гишүүн

Албертус Браггинк нь ОРИКС Корпораци (ORIX Corporation)-аас нэр дэвшиж, 2020 оны 6-р сараас Хувьцаа эзэмшигчдийн дараагийн хурал хүртэл ХасБанкны ТУЗ-ийн гишүүнээр ТУЗ-ийн шийдвэрээр түр томилогдож, ТУЗ-ийн Эрсдэлийн удирдлагын хороо, Аудитын хорооны гишүүнээр тус тус ажиллаж байна. Альбертус Браггинк нь Нидерландын олон улсын санхүүгийн байгууллага болох Rabobank-д 30 жил ажилласан туршлагатай мэргэшсэн банкир юм. Тэрбээр мөн Rabobank-аас гадна JP Morgan, Robeco групп, Нидерландын Хөгжлийн Агентлаг (FMO Dutch Development Bank), Нидерландын Friesland банк зэрэг нэр хүндтэй санхүүгийн байгууллагуудад ТУЗ-ийн түвшинд ажиллаж байсан туршлагатай.



Андрезеж Витак
ТУЗ-ийн гишүүн

Андрезеж Витак нь Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (EBRD)-наас нэр дэвшиж, 2019 оны 3 дугаар сард Хувьцаа эзэмшигчдийн хурлаар ХасБанкны ТУЗ-ийн гишүүнээр 2 жилийн хугацаагаар сонгогдон ажиллаж байгаа бөгөөд 2021 оны хурлаар түүнийг улируулан сонгох сонгууль явагдана. Андрезеж Витак ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны гишүүн, Аудитын хорооны гишүүнээр тус тус ажилладаг. Андрезеж Витак Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банканд олон жил ажилласан туршлагатай мэргэшсэн банкир бөгөөд одоогоор чанаргүй актив, эрсдэлтэй зээлийн удирдлагын чиглэлээр хэрэгжүүлж буй тодорхой төслүүдэд бие даасан зөвлөхөөр ажиллаж байна. Тэрээр 1997-2007 онд Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкны Узбекистан дахь Суурин төлөөлөгчийн газрын захирал, Суурин төлөөлөгч, Украин дахь Суурин төлөөлөгчийн газрын Орлогч захирал, Польш, ОХУ, Монгол Улс, хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан орнууд болон Зүүн Европын орнууд дахь байгууллагуудад ТУЗ-ийн гишүүнээр тус тус ажиллаж байв.



Мелисса Мой Тиан
ТУЗ-ийн гишүүн

Мелисса Мой Тиан Дэлхийн Банкны гишүүн байгууллага болох Олон Улсын Санхүүгийн Корпораци (IFC)-аас нэр дэвшиж, 2019 оны 6 дугаар сард ТУЗ-ийн шийдвэрээр ХасБанкны ТУЗ-ийн гишүүнээр түр томилогдож, 2020 оны 3 дугаар сарын Хувьцаа эзэмшигчдийн хурлаар ТУЗ-ийн гишүүнээр 2 жилийн хугацаагаар сонгогдсон. Мелисса Мой Тиан ТУЗ-ийн Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо болон Аудитын хорооны гишүүнээр ажилладаг.

Мелисса Мой Тиан JP Morgan, HSBC, Citigroup зэрэг томоохон хөрөнгө оруулалтын банкуудад удирдлагын албан тушаалд 25 жилийн ажилласан туршлагатай.

Банкны засаглал

ТУЗ-ийн гишүүд



Майкл Мадден
ТУЗ-ийн гишүүн

Майкл Мадден 2009 оноос ХасБанкны ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байна. Майкл Мадден 2011, 2013, 2015, 2017, 2019 онуудад Хувьцаа эзэмшигчдийн хурлаар улиран сонгогдсон бөгөөд 2021 оны хурлаар түүнийг улируулан сонгох сонгууль явагдана. Майкл Мадден ТУЗ-ийн Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны даргаар ажилладаг. Тэрээр 2007 онд байгуулагдсан Ирландын Дублин хотод байрладаг Ронок компани, Нью Йорк хотод 2011 байгуулагдсан Тенео Капитал, 2015 онд Мьянмарт байгуулагдсан Ронок Ази буюу Онго компаниудын үүсгэн байгуулагч, удирдах түнш/захирлаар ажилладаг.



Нямтайширийн Цэлмүүн
ТУЗ-ийн гишүүн

Нямтайширийн Цэлмүүн нь 2013 онд Хувьцаа эзэмшигчдийн хурлаар ТУЗ-ийн гишүүнээр сонгогдсон бөгөөд 2015, 2017, 2019 онуудад улиран сонгогдсон. 2021 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлаар түүнийг улируулан сонгох сонгууль явагдана. Н.Цэлмүүн ТУЗ-ийн Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүн, Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны гишүүнээр тус тус ажилладаг. Тэрээр Монголын томоохон компаниудын нэг болох Монголын Алт /МАК/ ХХК-ийн Ерөнхийлөгч, ТУЗ-ийн гишүүнээр ажилладаг.



Ив Жако
ТУЗ-ийн гишүүн

Ноён Ив Жако нь Канадын Үндэсний Банкнаас нэр дэвшиж, 2016 оны 3 дугаар сард ХасБанкны ТУЗ-ийн гишүүнээр анх сонгогдож, 2018, 2020 онд 2 жилийн хугацаатай тус тус улиран сонгогдсон. Ив Жако ТУЗ-ийн Эрсдэлийн удирдлагын хорооны дарга, Аудитын хорооны гишүүнээр ажилладаг. Тэрээр Канадын Үндэсний Банкны олон улсын үйл ажиллагааг хариуцсан Тэргүүн Дэд Ерөнхийлөгч, мөн Канадын Үндэсний Банкны охин компани болох NATCAN International компанийн Дэд захирлаар ажилладаг. Ив Жако мөн Камбоджийн АВА Банк, Ливаны Byblos Банк, Тайландын АТА компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний үүрэгт ажлыг гүйцэтгэдэг.



Нираж Вэдва
ТУЗ-ийн хараат бус гишүүн

Нираж Вэдва 2018 оны 6 дугаар сард ТУЗ-ийн шийдвэрээр ХасБанкны ТУЗ-ийн хараат бус гишүүнээр түр томилогдож, 2019 онд Хувьцаа эзэмшигчдийн хурлаар ТУЗ-ийн хараат бус гишүүнээр 2 жилийн хугацаагаар сонгогдсон бөгөөд 2021 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлаар түүнийг улируулан сонгох сонгууль явагдана. Нираж Вэдва ТУЗ-ийн Аудитын болон Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүнээр ажилладаг. Тэрээр 30 гаруй жил банкны өөрчлөн байгуулалт, мэдээллийн технологийн чиглэлээр ажилласан туршлагатай. Нираж Вэдва нь Дубай хотод байрладаг Acceleric FZ LLE мэдээллийн технологийн зөвлөгөөний компанийн үүсгэн байгуулагч, гүйцэтгэх захирал бөгөөд үүнээс өмнө тэрээр Энэтхэг Улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй Тек Махиндра (Tech Mahindra) мэдээллийн технологийн компани, Швейцар Улсын Теменос компанид удирдлагын албан тушаалд, 1987-1999 онуудад Энэтхэгт мэдээллийн технологийн Nucleus Software зэрэг компаниудад ажиллаж байсан ажилласан туршлагатай.



Баянсаны Уламбаяр
ТУЗ-ийн хараат бус гишүүн

Баянсаны Уламбаяр нь 2015 оны 7 сараас ХасБанкны ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдон ажиллаж байна. Б.Уламбаяр 2018, 2020 онуудад Хувьцаа эзэмшигчдийн хурлаар ТУЗ-ийн хараат бус гишүүнээр хоёр удаа улиран сонгогдсон бөгөөд 2017 оны 7 дугаар сараас 2018 оны 3 сар хүртэл ТУЗ-ийн хараат бус гишүүнээр түр томилогдон ажилласан. Б.Уламбаяр ТУЗ-ийн Аудитын болон Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүнээр ажилладаг. Б.Уламбаяр Говь Бизнес Финанс ХХК-ийн үүсгэн байгуулагч түнш, зөвлөхөөр ажилладаг. Тэрээр хөрөнгө оруулалтын банкны чиглэлээр мэргэшсэн олон улсын хэмжээнд Токио хотод Леман Бродерс, Номура Секьюритис зэрэг хөрөнгө оруулалтын банкуудад ажилласан туршлагатай. Монголд эргэж ирснийхээ дараа тэрээр Драпер Капитал, Композит Капитал, Монет зэрэг хөрөнгө оруулалтын сан, компаниудад зөвлөх болон захирлаар, мөн Алтай Холдинг ХХК-д ерөнхий захирлаар ажилласан байсан.



Морис Лам
ТУЗ-ийн хараат бус гишүүн

Морис Лам нь ХасБанкны ТУЗ-ийн хараат бус гишүүнээр 2019 оны 3 дугаар сард ТУЗ-ийн шийдвэрээр түр томилогдож, 2020 онд Хувьцаа эзэмшигчдийн хурлаар ТУЗ-ийн хараат бус гишүүнээр 2 жилийн хугацаагаар сонгогдсон. Морис Лам олон улсын банк санхүүгийн салбарт 40 гаруй жил ажилласан туршлагатай. Тэрээр одоо гэр бүлийн бизнесүүдэд зориулсан бизнесийн стратеги, засаглалын чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлдэг Сингапурт байрладаг Stewardship Consulting компанийг үүсгэн байгуулж, захирлаар нь ажиллаж байна. 1999 онд энэ хувийн бизнесийг эхлүүлэхээс өмнө тэрээр олон улсын банкны салбарт Нью-Йорк, Сингапур, Токио болон Лондон хотуудад ажиллаж амьдарч байсан.

Банкны засаглал

ТУЗ-ийн үүрэг

ТУЗ-ийн дарга, Гүйцэтгэх захирлын үүрэг
ТУЗ-ийн дарга болон Банкны Гүйцэтгэх захирлын үүргийг өөр өөр хүн гүйцэтгэх ба энэ талаар Банкны дүрэмд тодорхой заагдсан байдаг. ТУЗ-ийн дарга болон Банкны Гүйцэтгэх захирал хоорондоо уялдаа холбоотой, эрх мэдлийн тэнцвэртэй харилцаатай ажиллаж, шийдвэр гаргалтад бие даасан байдалтай оролцдог.

2019 оны 3 дугаар сараас эхлэн ТУЗ-ийн даргаар Санжай Гүпта ажиллаж байна. ТУЗ-ийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж удирдах, ТУЗ-өөс гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, үнэлэх ажлыг удирдах, ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудлыг тодорхойлж боловсруулах, хурлаар асуудал бүрийг зохистой түвшинд хэлэлцэж, гишүүн тус бүрээс хэлэлцүүлэгт оролцож санал гаргах явдлыг дэмжин ажилладаг. ТУЗ-ийн дарга шийдвэр гаргах явцад ТУЗ-ийг удирдаж, ТУЗ-ийн багийн ажиллагааг хангаж ажилладаг. Үүнээс гадна ТУЗ-ийн дарга Гүйцэтгэх захирлыг чиглүүлж, удирдлага зөвлөмжөөр хангаж, хяналт тавьж ажилладаг.

2019 оны 3 сараас эхлэн ХасБанкны Гүйцэтгэх захирлаар Гүмэнжавын Цэвэгжав ажиллаж байна. Гүйцэтгэх захирал нь банкны өдөр тутмын удирдлага, үйл ажиллагааг удирдаж, ТУЗ-өөс батлагдсан стратеги, зорилт, бодлогыг хэрэгжүүлж ажилладаг. Гүйцэтгэх захирал нь стратегийн болон бизнесийн төлөвлөгөө, бүтэц зохион байгуулалт, хяналтын систем, дотоод дүрэм журмыг боловсруулах ажлыг хариуцдаг.

ТУЗ-ийн гишүүний үүрэг
ТУЗ-ийн гишүүн Банкны гүйцэтгэх захирлыг стратегийн удирдлагаар хангах, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг сорих хянах үүрэг гүйцэтгэдэг. Нэр дэвшүүлсэн хувьцаа эзэмшигчийн төлөөлөл болохоос гадна ТУЗ-ийн гишүүн нь нэн тэргүүнд Банк болон нийт хувьцаа эзэмшигчид, нэгдмэл сонирхолтой талуудын ашиг сонирхлын төлөө үнэнч хараат бус байдлаар ажиллах үүрэгтэй.

ТУЗ-ийн хараат бус гишүүний үүрэг
ТУЗ-ийн хараат бус гишүүн Банкны гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагыг хараат бус байдлаар хянаж, хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, ТУЗ-ийн шийдвэрийн талаар зөрүүтэй байр суурьтай байсан бол энэ тухайгаа мэдээлж, хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулах, тодруулга хийх үүрэг гүйцэтгэдэг.

ТУЗ-ийн гишүүдийг сонгох, улируулан сонгох

ТУЗ-ийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар 2 жилийн хугацаатай сонгодог. ТУЗ-ийн гишүүд дахин сонгогдох эрхтэй. Сонгуулийн хугацаа дуусах үед гишүүн үүрэгт ажлаа өгнө эсвэл хувьцаа эзэмшигчдийн хурлаар дахин сонгогдоно. ТУЗ-д орон тоо гарах эсхүл Дүрэмд заасан бусад нөхцөл байдал үүсэх тохиолдолд ТУЗ-ийн гишүүнийг ТУЗ-ийн шийдвэрээр түр томилж, хувьцаа эзэмшигчдийн дараагийн ээлжит хурлаар оруулж батлуулдаг. Түр томилогдсон гишүүн нь ТУЗ-ийн гишүүний бүх эрх, үүргийг эдэлнэ.

ТУЗ-ийн гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, сонгох, улируулан сонгох, чөлөөлөх журам нь Банкны дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны дотоод журам болон ТУЗ-ийн гишүүдийг нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулах журамд тусгагдсан байдаг. Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн Яамны хамтарсан тушаалаар батлагдсан “Банкны ТУЗ-ийн хараат бус гишүүдийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам” болон бусад холбогдох хууль тогтоомжийн заалтыг дагаж мөрдөх үүднээс 2017 онд Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж, хараат бус гишүүний талаарх тусдаа заалт оруулсан.

ТУЗ-ийн Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо нь ТУЗ-ийн бүрэлдэхүүн, ТУЗ-ийн гишүүнд тавигдах шаардлага, гишүүдийг сонгон шалгаруулах журам боловсруулах, ТУЗ-ийн гишүүнд, түүнчлэн хараат бус гишүүнд нэр дэвшигчид ТУЗ-ийн гишүүнд тавигдах шаардлагыг хангасан эсэхийг үнэлэн шалгаж, ТУЗ-д зөвлөмж гаргаж танилцуулах асуудлыг хариуцдаг.

ТУЗ-ийн дараах гишүүдийг 2021 оны хувьцаа эзэмшигчдийн хурлаар сонгох эсхүл улируулан сонгохоор оруулж батлуулна.

- Андрэеж Витак (улируулан сонгох)
- Майкл Мадден (улируулан сонгох)
- Н.Цэлмүүн (улируулан сонгох)
- Санжай Гүпта (улируулан сонгох)
- Нираж Вэдва, /улируулан сонгох/
- Альбертус Браггинк (сонгох)

Хуульд заасны дагуу төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшиж байгаа этгээд нь хуульд заасан шалгуурыг хангаж байгаа эсэхийг Банкнаас хүргүүлсэн мэдээлэлд үндэслэн Монголбанк тогтоож, энэ тухай мэдэгддэг.Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн дотроос ТУЗ-ийн хурлаар сонгодог.

ТУЗ-ийн хурал

ТУЗ нь Банкны дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны дотоод журмын дагуу үйл ажиллагаагаа явуулдаг. ТУЗ-ийн үйл ажиллагааны гол хэлбэр нь ТУЗ-ийн хурал бөгөөд хурлын шийдвэрийг тогтоолоор баталгаажуулж гаргадаг. ТУЗ-ийн ээлжит хурлын чөлөөт цагт ТУЗ-ийн үйл ажиллагааг онлайн болон холбооны бусад хэрэгслээр дамжуулан явуулж эчнээ санал хураалтаар шийдвэр гаргадаг.

2020 онд Ковид цар тахлаас үүдэлтэй хөдөлгөөний хязгаарлалт болон бусад хамгаалалтын арга хэмжээнүүдийн нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөг бууруулах, ТУЗ-ийн үйл ажиллагаа, шийдвэр гаргалтыг тасралтгүй явуулахын тулд ТУЗ нь уян хатан бодлого хэрэгжүүлж, үйл ажиллагааны цахим хэлбэрт шилжсэн.

- Skype, Webex, Zoom зэрэг харилцааны холбооны хэрэгслүүдээр дамжуулан ээлжит болон бусад хурлуудыг зохион байгуулж хуралдуулсан.
- Ээлжит хурлын чөлөөт цагт онлайн санал хураалтаар шийдвэр гаргах явдлыг түлхүү ашигласан.
- Шийдвэр тогтоолыг цахим хэлбэрээр онлайн санал хураалтаар шийдвэрлэж гаргасан.
- Ээлжит хурлын чөлөөт цагт сар бүр ТУЗ-ийн мэдээллийн чанартай онлайн уулзалтуудыг зохион байгуулсан.

2020 онд ТУЗ-ийн 4 ээлжит, 4 онлайн санал хураалтын хурлуудыг хуралдуулж, 6 удаагийн онлайн хэлэлцүүлэг хурал хуралдуулсан. Бүх хурлыг цахимаар Webex ба Zoom харилцаа холбооны хэрэгслүүдээр дамжуулан хуралдуулсан. Хурлын ирцийг дараах хүснэгтээр харуулав.

#	Огноо	Хурал	Ирц
1	2020 оны 1 дүгээр сарын 14	Онлайн санал хураалт	11/11
2	2020 оны 2 дугаар сарын 11	Онлайн санал хураалт	11/11
3	2020 оны 3 дугаар сарын 2	Онлайн санал хураалт	11/11
4	2020 оны 3 дугаар сарын 25	Ээлжит	11/11
7	2020 оны 6 дугаар сарын 24	Ээлжит	10/11
9	2020 оны 8 дугаар сарын 20	Мэдээлэл	9/11
10	2020 оны 9 дүгээр сарын 16	Ээлжит	10/11
11	2020 оны 10 дугаар сарын 21	Мэдээлэл	9/11
12	2020 оны 10 дугаар сарын 27	Онлайн санал хураалт	11/11
14	2020 оны 12 дугаар сарын 9	Ээлжит	11/11

2020 онд ТУЗ нь 25 тогтоол шийдвэр гаргасан ба үүнээс 4 тогтоол шийдвэрийг ТУЗ-ийн хурлыг хуралдуулалгүйгээр онлайн санал хураалтаар гаргасан болно.

Банкны гүйцэтгэх удирдлагын багийн гишүүд шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийн бүх ээлжит хурал, ТУЗ-ийн хороодын болон бусад хуралд оролцож Банкны бизнес, санхүү нягтлан бодох бүртгэл, хянан нийцүүлэлт, засаглал болон банкны үйл ажиллагааны бусад асуудлуудаар шаардлагатай мэдээлэл, тайлбар гаргаж өгдөг.

ТУЗ-ийн хурлын үеэр албан ёсоор харьцаж тайлагнахаас гадна ТУЗ-ийн гишүүд Банкны гүйцэтгэх удирдлагын гишүүдтэй тогтмол албан бус байдлаар харилцах боломжтой байдаг нь удирдлагын баг болон ТУЗ-ийн хооронд нээлттэй хэлэлцүүлэг, мэдлэг туршлага солилцох үйл ажиллагааг хангадаг.

Банкны засаглал

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн жил

Focus area	2020 3 сар	2020 5 сар	2020 6 сар	2020 8 сар	2020 9 сар	2020 10 сар	2020 11 сар	2020 12 сар
Бизнесийн үйл ажиллагаа	Удирдлагын улирлын тайлан, 2019 оны санхүү, үйл ажиллагааны жилийн тайлан, 1-р улирлын байдал, цаг үеийн асуудлуудыг хэлэлцэв.	4-р сарын удирдлагын тайлан, зээлийн багцад үзүүлж буй Ковид-19 цар тахлын нөлөөг хэлэлцэв.	Удирдлагын тайлан, цаг үеийн дараах асуудлуудыг хэлэлцэв. Үүнд: - 2020 оны сонгууль, банкны салбарын реформ - 2020 оны төсөөлөл тооцоо	7- сарын удирдлагын тайлан, Засгийн газраас хэрэгжүүлж буй Ковид-19 цар тахлын хариу арга хэмжээ, Банкны хариу арга хэмжээний дэлгэрэнгүй тайлан, мөн цаг үеийн дараах асуудлуудыг хэлэлцэв. Үүнд:: - Эдийн засгийн тойм - Улс төрийн тойм - Банкны хууль тогтоомжийн реформ	7, 8-р сарын удирдлагын тайлан, цаг үеийн дараах асуудлуудыг хэлэлцэв. Үүнд: - Ковид-19 цар тахлын хариу арга хэмжээ; - ББСБ, банкны салбарын реформ	9-р сарын удирдлагын тайлан, Засгийн газраас хэрэгжүүлж буй Ковид-19 цар тахлын хариу арга хэмжээ, Банкны хариу арга хэмжээний дэлгэрэнгүй тайлан, мөн цаг үеийн дараах асуудлуудыг хэлэлцэв. Үүнд: - Улс төрийн тойм - 2021 оны мөнгөний бодлого - 2021 оны улсын төсөв - 9-р сарын эдийн засгийн тойм	Стратегийн хэлэлцүүлэг явуулж, дараах сэдвүүдийг хэлэлцэв. - Үйл ажиллагааны орчин гол үзүүлэлтүүд - Бизнесийн төлөвлөлт - Санхүүжилт, өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцаа - Маркетинг, харилцагчдын санал - Хүний нөөц	10, 11-р сарын удирдлагын тайлан, цаг үеийн дараах асуудлуудыг хэлэлцэв. Үүнд: - Ковид-19 цар тахлын нөхцөл байдал - Эдийн засгийн болон банкны салбарын реформ
Санхүүгийн гүйцэтгэл	2019 оны жилийн санхүүгийн тайланг хэлэлцэж батлав. Дараах асуудлаар мэдээ тайлан танилцуулав. Үүнд: - Өөрийн хөрөнгө - Своп		2020 оны Санхүүжилтийн төлөвлөгөөг хэлэлцэж батлав.	Хагас жилийн санхүүгийн тайланг хянаж баталгаажуулсан Делойтын тайланг хэлэлцэж батлав.				
Зохистой засаглал	Жил бүрийн 1-р улирлын ээлжит хурлаар хэлэлцэх асуудлуудыг хэлэлцэж батлав. Үүнд: - Гүйцэтгэх захирлын ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, урамшуулал - ТУЗ-ийн даргын ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, урамшуулал - ТУЗ-ийн гишүүдийн сонгууль - ТУЗ-ийн Хүндэт даргын зөвлөх үйлчилгээний гэрээний сунгалт		2020 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны өөрийн үнэлгээ, гишүүн тус бүрийн үнэлгээ явуулах асуудлыг хэлэлцэв.	Шинэ журмын дагуу Банкны эцсийн өмчлөгчийг бүртгүүлэх асуудлыг хэлэлцэв..		2021 оны 9-р сарын ТУЗ-ийн хурал хуралдуулах өдрийг өөрчлөх асуудлыг хэлэлцэж, шинэ огноог батлав.		
Стратеги	2019 оны үр дүнгийн ногдол ашгийг хуваарилахгүй байх шийдвэрийг хэлэлцэж батлав.					11 дүгээр сард зохион байгуулагдах Стратегийн хэлэлцүүлгийн үеэр хэлэлцэх асуудлуудыг тохиролцов.		Удирдлагаас санал болгосон 2021 оны төсвийг нягтлан үзэж, нэмэлт өөрчлөлт оруулж, 2021 оны шинэчилсэн төсвийг батлав.
Мэдээллийн технологи			Мэдээллийн технологийн төслүүдийн танилцуулга, тайланг хэлэлцэв.		Мэдээллийн технологийн тайланг хэлэлцэв.		Мэдээллийн технологийн тайланг хэлэлцэв.	
Эрсдэлийн удирдлага	ТУЗ-ийн Эрсдэлийн удирдлагын ээлжит тайланг хэлэлцэв.		ТУЗ-ийн Эрсдэлийн удирдлагын ээлжит тайланг хэлэлцэв.		Фитч-ийн үнэлгээг хэлэлцэв.	ТУЗ-ийн Эрсдэлийн удирдлагын ээлжит тайланг хэлэлцэв.		ТУЗ-ийн Эрсдэлийн удирдлагын ээлжит тайланг хэлэлцэв.

Банкны засаглал

ТУЗ-ийн үнэлгээ

Зохистой засаглалын зарчмын дагуу ТУЗ нь засаглал, үйл ажиллагаагаа сайжруулан ажиллах зорилгоор хамтын гүйцэтгэлийг үнэлэх, дутагдлыг илрүүлэх, үйл ажиллагааг сайжруулах тодорхой арга хэмжээ авахын тулд жил бүр ТУЗ-ийн үйл ажиллагааны үнэлгээ явуулдаг. Үүнээс гадна тодорхой шалгуурыг үндэслэн ТУЗ-ийн гишүүн тус бүрийн үнэлгээ хийдэг.

Банкны ТУЗ нь 2020 онд тус үнэлгээгээ дараах байдлаар хийж гүйцэтгэсэн.

Үнэлгээний аргачлал

2020 оны 6 дугаар сарын ээлжит хурлаараа ТУЗ-ийн Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо нь 2019 онд ТУЗ-ийн Үнэлгээний Бодлоготой хамт батлагдсан үнэлгээний маягтуудыг хэлэлцэж, сонирхлын зөрчил болон ТУЗ-ийн гишүүний ур чадвартай холбоотой асуудлуудыг тодруулах зарим нэмэлт өөрчлөлтүүдийг оруулав.

ТУЗ-ийн өөрийн үнэлгээ, гишүүдийн үнэлгээг 2020 оны 7, 8 дугаар саруудад дараах маягтуудыг ашиглан явуулсан. Үүнд:

- ТУЗ-ийн үйл ажиллагааны өөрийн үнэлгээ
- ТУЗ-ийн гишүүний үнэлгээ

ТУЗ-ийн үйл ажиллагааны өөрийн үнэлгээний маягт дараах 4 бүлэг 35 асуулттай байв.

- Стратеги ба бүтэц
- ТУЗ-ийн гишүүн / ажиллагсад
- Үр дүн
- ТУЗ-ийн ажлын алба

ТУЗ-ийн гишүүний үнэлгээний маягт дараах 3 бүлэг 14 асуулттай байв

- Гишүүний ур чадвар
- Мэдлэг
- Үүрэг, хариуцлага

ТУЗ-ийн гишүүд бусад санал оруулах боломжтой байв.

Үнэлгээ нь 2019 оны 5 дугаар сараас 2020 оны 8 дугаар сар хүртэл хугацааг хамрав. Маягтуудыг ТУЗ-ийн гишүүдэд хүргүүлж, хариуг Гүйцэтгэх захирал, Компанийн н/б-ийн даргаар дамжуулан нэгтгэж авсан. 11 гишүүдээс 9 гишүүн үнэлгээнд оролцсон.

Үнэлгээний хариу /нэргүйгээр/ Компанийн н/б-ийн дарга нэгтгэж, үр дүнг ТУЗ, Хувьцаа эзэмшигчдэд мэдээлсэн.

Үр дүн

Үнэлгээний үр дүн:

- ТУЗ нь дараах чиглэлээр сайн ажиллаж байна гэдэг дээр ТУЗ-ийн гишүүд санал нэгтэй байв. Үүнд:
 - Стратеги ба бүтэц
 - ТУЗ-ийн гишүүн / ажиллагсад
 - ТУЗ-ийн ажлын алба.
- ТУЗ, байгууллагын ирээдүйн зорилтуудын талаар алсын хараатай даргатай гэдэг дээр ТУЗ-ийн гишүүд санал нэгтэй байв.

Үнэлгээний дараах зөвлөмж, арга хэмжээ

- ТУЗ-ийн үйл ажиллагааг улам боловсронгуй болгох төлөвлөгөө хэрэгжүүлэх
- Хуулийн шаардлагатай уялдуулах үүднээс ТУЗ-ийн хурлын хуваарийг шинэчлэх
- Стратегийн асуудлууд, Гүйцэтгэх захирал, удирдлагын гишүүдийн халаа залгамжид илүү цаг хугацаа хандуулах

Банкны засаглал

ТУЗ-ийн гишүүдийн сургалт

ТУЗ-ийн шинээр сонгогдсон гишүүдийг Банкны үйл ажиллагаа, байгууллагын соёлтой танилцуулж, ТУЗ-ийн гишүүдийн үүрэг хариуцлагын талаар мэдээлэл өгөх зорилгоор ТУЗ-ийн гишүүдийг сургалт танилцуулгын дараах хөтөлбөрт хамруулдаг.

- ТУЗ-ийн шинэ гишүүдэд Банкны стратеги, бизнес төлөвлөгөө, дотоод засаглалын баримт бичиг, санхүүгийн тайлан, үйл ажиллагааны болон дотоод хяналтын бодлого, ТУЗ болон түүний хороодын хурлын тэмдэглэл, тогтоол, болон ТУЗ-ийн гишүүдэд шаардлагатай бусад баримт бичиг, холбогдох хууль тогтоомж зэрэг багц баримт бичгүүдийг хүргүүлдэг.
- ТУЗ-ийн шинэ гишүүдийг Банкны гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдтэй танилцуулах, Банкны санхүүгийн байдал, үйл ажиллагаа, тулгарч буй хүндрэлүүдийн талаар газар дээр танилцуулж хэлэлцэх зорилгоор уулзалтуудыг зохион байгуулдаг.
- Шаардлагатай тохиолдолд гол гол харилцагч, нэгдмэл сонирхолтой талуудтай уулзалт зохион байгуулдаг.

Шинэ гишүүд Банкны Ёс зүйн хэм, хэмжээ ба Сонирхлын зөрчлийн журам, ТУЗ-ийн гишүүдийн үүрэг хариуцлагын заалтуудтай танилцаж, хүлээн зөвшөөрч буйгаа гарын үсэг зурж мэдэгдэх үүрэгтэй.

2020 оны 6 дугаар сард ТУЗ-ийн гишүүнээр Хувьцаа эзэмшигчдийн хурал хүртэл ТУЗ-ийн шийдвэрээр түр томилогдсон Альбертус Браггинк ТУЗ-ийн сургалт танилцуулгын хөтөлбөрийн ихэнх хэсэгт цахимаар хамрагдсан. Ковидын дараах нөхцөл байдал, бизнес, зорчих хөдөлгөөн хэвийн байдалд шилжих эсэхээс хамааран газар дээрх уулзалтуудыг дараа жилд зохион байгуулж гүйцээхээр төлөвлөж байгаа.

Зохистой засаглалын зарчим, Компанийн хуулийн заалтын дагуу ТУЗ-ийн гишүүд зохистой засаглалын сургалтад хамрагдаж, гэрчилгээ авах үүрэгтэй. 2020 онд шинээр түр томилогдсон Альбертус Браггинк “Компанийн зохистой засаглалын орчин үеийн зарчим, сайн туршлага” сэдэвтэй сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан болно.

ТУЗ-ийн гишүүдийн цалин

ТУЗ-ийн гишүүд ТУЗ, хорооны хуралд оролцох болон бусад үүрэг хариуцлагыг гүйцэтгэхтэй холбоотой цалин авдаг. ТУЗ-ийн гишүүний цалингийн хэмжээг хувьцаа эзэмшигчдийн хурлаар тогтоодог.

Зохистой засаглалын зарчмын¹ дагуу ТУЗ-ийн хараат бус гишүүний ажлын хөлс, урамшууллын хэмжээг ТУЗ-ийн гишүүний ажлын хөлс, урамшууллын хэмжээнээс багагүй тогтоодог.

ТУЗ-ийн гишүүнд хуралд оролцсонтой холбоотой зардлын нөхөн олговор олгодог. Нөхөн олговор олгох журмыг ТУЗ-ийн үйл ажиллагааны дотоод журамд заасан байдаг.

ТУЗ-ийн гишүүн зөвлөх үйлчилгээний хөлс болон өөр бусад шагнал урамшуулал авдаггүй.

¹Монголбанкнаас баталсан “Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам”

ТУЗ-ийн хороод

ХасБанкны ТУЗ нь ТУЗ-өөс даалгасан тодорхой үүрэг хариуцлага бүхий 3 байнгын хороотой ба эдгээр хороод нь тодорхой асуудлуудаар мэргэжлийн зөвлөмж гаргаж, ТУЗ-ийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд туслах зорилготой.

Хороодын үйл ажиллагаатай холбоотой ерөнхий заалтууд нь ТУЗ-ийн үйл ажиллагааны дотоод журмаар зохицуулагддаг ба тухайн хороонд хамаарах асуудал нь холбогдох хорооны дүрмээр зохицуулагдана. ТУЗ нь дараах байнгын хороодтой.

- Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо;
- Эрсдэлийн удирдлагын хороо;
- Аудитын хороо.

ТУЗ-ийн хороод нь тав буюу түүнээс дээш гишүүнтэй байх бөгөөд тэдгээр нь ТУЗ-ийн гишүүн байна. ТУЗ-ийн гишүүн нь нэгээс дээш хороонд ажиллаж болох бөгөөд Монгол улсын Банкны тухай хуульд заасны дагуу ТУЗ-ийн хараат бус гишүүн нь Эрсдэлийн удирдлагын болон аудитын хороодод заавал ажиллах үүрэгтэй.

Олон улсын зохистой засаглалын зарчим, Монголбанкнаас гаргасан журмын дагуу ТУЗ-ийн Аудитын хороог хараат бус гишүүн даргалдаг, ТУЗ-ийн гишүүн гүйцэтгэх захирал ТУЗ-ийн Аудит, Эрсдэлийн удирдлага, Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороодын гишүүнээр ажилладаггүй.

Хороодын үйл ажиллагааны гол хэлбэр нь хорооны хурал бөгөөд хорооны шийдвэрийг ТУЗ-д танилцуулах зөвлөмж хэлбэрээр гаргадаг. Хороодын ээлжит хурлууд нь ТУЗ-ийн хурлын өмнөх өдөр товлогддог ба 2020 онд байнгын хороодын ээлжит хурлыг 4 удаа улирал бүр Webex ба Zoom харилцаа холбооны хэрэгслээр хуралдуулсан. Ээлжит хурлын чөлөөт цагт ТУЗ-ийн хороодын үйл ажиллагааг онлайн болон мэдээллийн бусад хэрэгслээр дамжуулан явуулж онлайн санал хураалтаар зөвлөмж гаргаж ажилладаг.

Банкны засаглал

Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо

Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо нь зохистой засаглалын зарчим, бодлого зэрэг компанийн зохистой засаглалын асуудлыг хариуцаж, нэгдмэл сонирхолтой бүх талын эрх ашигт нийцсэн банкны ил тод, тогтвортой үйл ажиллагаа явуулахад чиглэл өгч, мөн хяналт тавихад шаардагдах бүтэц, процесс бүхий зохистой засаглалын тогтолцоог бүрдүүлж ажиллах үүрэгтэй.

Уг хороо дараах үндсэн үүрэг хариуцлагатай.

Үүнд:

(i) ТУЗ-ийн гишүүн болон Гүйцэтгэх захирлын албан тушаалд томилогдох нэр дэвшигчдийг сонгон шалгаруулах, үнэлэх, ТУЗ-д санал болгох, (ii) Гүйцэтгэх захирлын ажлын гүйцэтгэлийн үнэлгээ хийж, цалин урамшууллыг тогтоох, хувьцаанд суурилсан урамшууллын хөтөлбөрт хяналт тавих, ТУЗ-ийн цалин урамшууллын талаар ТУЗ-д санал оруулах, эдгээр болно. Хорооны дүрмийг 2014 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлаар шинэчлэн баталсан.

Эрсдэлийн Удирдлагын Хороо

Эрсдэлийн удирдлагын хороо нь эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын зохистой тогтолцоог бүрдүүлж, эрсдэлтэй холбоотой асуудлаар ТУЗ-д зөвлөмж гаргах үүрэгтэй.

Уг хороо нь эрсдэлийн удирдлагын бодлого, бизнесийн чиглэл бүрийн материаллаг эрсдэлийг бууруулах зохистой төлөвлөгөө, эрсдэлийн удирдлагын чиг үүрэг үр дүнтэй байгаа эсэх, эрсдэл хүлээх хязгаар, зээлийн багцын чанар, зээлийг батлах эрх мэдэл, зээлийг сангаас хаах зэрэг үндсэн үүрэг хариуцлагатай.

Эрсдэлийн удирдлагын хорооны дүрмийг 2019 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлаар шинэчлэн баталсан.

Аудитын хороо

Аудитын хороо нь дотоод хяналтын системийн бүрэн бүтэн, зөв зохистой болон үр дүнтэй байдлыг хянах үүрэгтэй.

Уг хороо нь хөндлөнгийн аудиторыг томилох, дахин томилох эсвэл чөлөөлөх, дотоод аудитын газрын ажлын гүйцэтгэл, санхүүгийн тайлагналын шаардлага, заалтуудыг мөрдөж буй эсэх, аудитлагдсан болон аудитлагдаагүй жилийн ба хагас жилийн санхүүгийн тайланг нягталж хянах, ердийн бус хэлцлийг хянах, хууль тогтоомжийн өөрчлөлт ба санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг хянах үндсэн үүрэг хариуцлагатай.

Аудитын хороо нь Ерөнхий аудиторыг томилдог ба түүний ажлын гүйцэтгэлийг үнэлдэг. Аудитын хорооны дүрмийг 2015 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлаар шинэчлэн баталсан.

Гишүүд

Майкл Мадден, дарга
Мелисса Мой Тиан
Андрезеж Витак
Санжай Гупта
Нямтайширийн Цэлмүүн

Гишүүд

Ив Жако, дарга
Нямтайширийн Цэлмүүн
Альбертус Браггинк
Баянсаны Уламбаяр
(хараат бус гишүүн)
Нираж Вэдва
(хараат бус гишүүн)
Морис Лам
(хараат бус гишүүн)

Гишүүд

Морис Лам
(хараат бус гишүүн) дарга
Ив Жако
Андрезеж Витак
Мелисса Мой Тиан
Альбертус Браггинк
Нираж Вэдва
(хараат бус гишүүн)
Баянсаны Уламбаяр
(хараат бус гишүүн)

СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ БА ТОЛИЛУУЛГА

Ёс зүйн хэм, хэмжээ ба сонирхлын зөрчлийн журам нь сонирхолын зөрчлийг тодорхойлж, сонирхлын зөрчлийг мэдэгдэж шийдвэрлэх журмыг тогтоодог. Үүнд:

- ТУЗ-ийн гишүүд, ажиллагсад нь өөрийн ажил үүргээ гүйцэтгэхдээ аливаа хувийн, санхүүгийн болон бусад сонирхол нөлөөлж болзошгүй тохиолдолд, түүнийгээ мэдэгдэж мэдээлэх;
- ТУЗ-ийн гишүүд Банкнаас хийх гэж буй аливаа хэлцэлтэй холбоотой ямар нэг сонирхлын зөрчилтэй бол энэ талаар тухайн хэлцлийг авч хэлэлцэж буй ТУЗ-ийн хурал дээр мэдэгдэж мэдээлэх,
- ТУЗ-ийн гишүүн аливаа хэлцэл, ажил үйлчилгээ, саналд шууд ба шууд бус сонирхолтой бол ТУЗ-өөр тухайн асуудлыг хэлэлцэж шийдвэр гаргахад санал хураалтад оролцохгүй, ирц бүрдүүлэхгүй байх, эдгээр болно.

2020 онд ТУЗ-ийн болон гүйцэтгэх удирдлагын бүх гишүүд толилуулгын хуудсыг бөглөж, сонирхлын зөрчлийн талаар мэдэгдэж мэдээлсэн. Ил тод байдлыг илүү хангах үүднээс толилуулгын хуудаснуудыг ТУЗ-ийн онлайн портал дээр байршуулж эхэлсэн.

ТУЗ-ийн гишүүд ТУЗ-ийн хурал эхлэхэд, мөн хурлын туршид хэлэлцэх асуудалтай холбоотой аливаа сонирхлын зөрчлийг мэдэгдэж мэдээлэх үүрэгтэй.

АУДИТ БА ТАЙЛАГНАЛ

ТУЗ нь Банкны санхүүгийн тайлан үнэн зөв бэлтгэгдсэн, холбогдох хууль тогтоомж, банкны салбарын зохицуулагч байгууллагын шаардлага болон хэрэглэгдэж буй нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн эсэхэд хяналт тавьж баталдаг. Банкны удирдлага нь ТУЗ-өөр батлуулахаар санал болгосон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-д мэдээлэл тайлбар өгөх, ТУЗ-ийг үндэслэлтэй үнэлгээ дүгнэлт хийж шийдвэр гаргах боломжоор хангах үүрэгтэй.

ТУЗ нь хөндлөнгийн аудиторыг сонгох, томилох, тодорхой хугацааны дараа солих өөрчлөх үүрэгтэй ажилладаг. 2014 онд Эрнст Янг компанийн оронд хөндлөнгийн аудитороор томилогдсон Делойт компани нь 2020 оны аудит хийхээр дахин томилогдсон.



ХасБанкНЫ ТӨВ БАЙР:

Олон Улсын Худалдааны төв, Жамьян гүний гудамж - 9
Ш/салбар 20А, ш/х-72, Улаанбаатар-14200, Монгол улс

Утас:

7577 1888

Лавлах:

1800 1888

И-мэйл:

info@xacbank.mn

Вэб:

www.xacbank.mn